

“Баяр хөөр”

БИБЛИ СУДЛАЛ

Үдм



Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Хирст бидний теее үхсэн.
Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. – Ром 5:8

РОМ НОМНЫ ТАНИЛЦУУЛГА

Шинэ Гэрээний Ром ном нь МЭ 58 онд элч Паул Ромд амьдарч байсан итгэгч нарт зориулан бичсэн захидал юм. Энэ захидал Есүс Христийн гайхамшигт амьдрал болон Тэр бидний төлөө юу хийсэн мөн юу хийхийг хүсэж байгаа тухай тайлбарласан байдаг. Бидэнд Аврагч хэрэгтэй гэдгийг Бурхан харж байдаг гэдгийг Паул өгүүлжээ. Гэмт хүмүүсийн хувьд бид нар үхлээр шийтгэгдсэн бөгөөд Бурханаас үүрд тусгаарлагдсан байдаг. Гэвч энэ захидалаас бид Бурханы бидний төлөө гэсэн гайхамшигт хайрыг харах болно. Тэр бидэнд цорын ганц Хүүгээ бидний эдлэх ёстой байсан нүглийн шийтгэл болгон өгсөн бөгөөд ингэснээр бид гэмээс чөлөөлөгдөн, гайхалтай амьдралаар Түүнийг даган үүрд амьдрах болно. Энэ таны амьдралдаа сонсож байсан хамгийн сайн мэдээ биш гэж үү?

Гэрчлэл нь энэ байна. Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүгийн дотор байна (1 Иохан 5:11). Үхэгсдээс амилсан Есүс Өөрт нь итгэсэн хэнтэй ч болов Өөрийн амьдралаа хуваалцах хүсэлтэй байдаг бөгөөд Өөртэйгөө адил болгохыг хүсч байдаг юм. **Есүс хэлэхдээ, -Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав. (Иохан 8:12)** Паулын Ромчуудад бичсэн захидал бол жинхэнэ эрх чөлөөний тухай байлаа. Та Бурханаас Есүсийг Амьд Нэгэн гэдгийг харуулж өгөхийг зүрх сэтгэлээсээ гуйгаарай. **[Та нарын] зүрхний мэлмийг гийгүүлэх болтугай! Ийнхүү та нар дуудлагын найдварыг хийгээд ариун хүмүүс дотор Түүний өв дэх алдрын баялгийг, мөн итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын хэмжээлшгүй сүр жавхланг мэдэх болно. (Ефес 1:18,19а)**

Паулын Ромд бичсэн захидлыг дүгнэсэн олон зуун ном зохиол бичигдсэн байдаг. Гэхдээ та энэ захидалыг битгий дүгнэхийг бодоорой. Хүүхдүүд эхийнхээ сүүг дүгнэдэггүй харин тэд зөвхөн амьдралын шим тэжээл, хэрэгцээ болгон хэрэглэдэг. **Христ та нарын дотор дүрээ олтол энэ захидлаас дахин дахин ундаалж, өөртөө шингээн Эзэнийг таньж мэдээрэй. (Гал 4:19)**

БИБЛИ СУДЛАЛ

Ром

ХИЧЭЭЛ 1. ПАУЛ БУРХАНЫ САЙН МЭДЭЭГ ТУНХАГЛАСАН НЬ

Ром 1:1-15

Христ Есүсийн боол Паул би элч болохоор дуудагдаж, Бурханы сайн мэдээний төлөө тусгаарлагдсан. ²Энэ сайн мэдээ бол Бурхан эш үзүүлэгчдээрээ дамжуулан Ариун Судруудад урьдаас амласан тэр Хүүгийн тухай сайн мэдээ юм. ³Тэр Хүү нь махан биеэр Давидын удмаас төрсөн бөгөөд ⁴ариун байдлын Сүнсээр үхэгсдээс амилснаар сүр хүчээр Бурханы Хүү гэж тодорхойлогдсон бидний Эзэн Есүс Христ мөн. ⁵Бид Түүний нэрийн төлөө бүх харь үндэстний дунд итгэлийн дуулгавартай байдлыг бий болгохын тулд Түүгээр дамжуулан нигүүлсэл болон элчийн үүргийг хүлээн авсан билээ. ⁶Та нар ч бас тэдний дундаас Есүс Христийнх болохоор дуудагдсан хүмүүс юм. ⁷Ромд буй ариун хүмүүс байхаар дуудагдсан Бурханы хайртай бүх хүнд Бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс нигүүлсэл ба амар тайван нь байх болтугай.

⁸Юуны өмнө, та бүгдийн төлөө би Есүс Христээр дамжуулан Бурхандаа талархаж байна. Яагаад

гэвэл та нарын итгэл бүх ертөнц даяар тунхаглагдаж байна. ⁹Түүний Хүүгийн сайн мэдээний дотор миний сүнсээрээ үйлчилдэг Бурхан та нарыг хэр их тасралтгүй дурсдгийг маань гэрчилнэ. ¹⁰Залбирахдаа үргэлж Бурханы хүслээр одоо л нэг та нар дээр очих завшаан олдоосой гэж гуйдаг. ¹¹Учир нь та нарыг бат болгохын тулд сүнслэг зарим бэлгийг та нартай хуваалцах гэсэндээ би та нарыг харахыг ихэд хүсдэг. ¹²Өөрөөр хэлбэл, та нарын дунд байхдаа бидний хэн хэн нь нөгөөгийнхөө, би та нарын, та нар миний итгэлээр хамтдаа зоригжих юм. ¹³Ах дүү нар аа, бусад үндэстнүүдийн дунд олсны адил зарим үр дүнг та нарын дунд олохын тулд би олон удаа та нар уруу очих санаатай байсан боловч одоог хүртэл саад тотгортой байсныг та нар мэдэлгүй өнгөрөхийг би хүсэхгүй байна. ¹⁴Грекчүүд болон бусад үндэстнүүд, мэргэн болон мунхаг хүмүүсийн хэн хэнд нь би өртэй. ¹⁵Тиймд миний хувьд, Ромд байгаа та нарт ч мөн сайн мэдээг тунхаглахыг маш их хүсэж байна.

Сайн мэдээ гэж юу вэ?

Паул Бурханаас авсан Судрын дагуу Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд ‘оршуулагдан, Судрын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ (1Коринт 15:36, 4) гэсэн сайн мэдээг ариун хүмүүст ярих дуртай байжээ. Энэ нь яагаад сайн мэдээ бөгөөд танд ямар хамаатай вэ? гэдгийг Паул тайлбарлах болно. Та эндээс Бурханы нигүүсэл ба хайраар Есүсийн танд өгөх, гэмээс ангид байх эрх чөлөөг мэдрэх болно. Түүний зүйрлэшгүй бэлгийн төлөө Бурханд талархал байх болтугай (2 Коринт 9:15).

Хийх зүйлс

1-р хуудас дээр байгаа ишлэлийг нөхөж бичээд Есүс болон Бурханы сайн мэдээний тухай илүү ихийг мэдэж аваарай. (Та хариултаа 111-р хуудаснаас харж болно.)

1. Бурхан _____ дамжуулан Ариун _____ урьдаас амласан тэрхүү сайн мэдээ нь (Ишлэл 2)

2. Сайн мэдээ бол Түүний Хүү _____ тухай юм (3)

3. Есүс Христ _____ үр удмаас төрсөн (3)

[Есүс махан биеийг олж төрсөн. Эш үзүүлэгч нар Мессиаг Хаан Давидын удмаас төрнө гэж хэлсэн. (Иеремиа 23:5)]

4. Ариун байдлын Сүнсээр үхэгсдээс _____ сүр хүчээр _____ гэж тодорхойлогдсон бидний Эзэн Есүс Христ мөн. (4)

[Есүс Тэнгэрлэг нэгэн байсан. Тэр “ Бидэнтэй хамт буй Бурхан” байсан.

(Матай 1:23) Түүний дахин амилалт үүнийг баталсан. Бурхан Ариун нэгнийг ялзрахыг зөвшөөрөхгүй. (Дуулал 16:10), Тиймээс тэр үхлээс амилсан юм.]

5. Бид Түүний нэрийн төлөө бүх Харь _____ дунд итгэлийн _____ бий болгохын тулд Түүгээр дамжуулан _____ болон элчийн үүргийг хүлээн авсан билээ.(5)

Ромын итгэгч нар

Паул хэзээ ч Ромд очиж байгаагүй ч тэр Ромын итгэгч нарын итгэлийн тухай яриа Ром даяар тархсан байсныг сонссон байв. Есүс Христ тэдгээр хүмүүсийг дуудсан (6 ишлэл), мөн тэд Бурханаар

хайрлагдан, дуудлага авч ариун болсон гэдгийг Паул мэдэж байжээ. (7-р ишлэл). Есүс Христ үхлээс амилснаас хойш тавин өдрийн дараа Түүний дагалдагч нар Ариун Сүнсээр дүүрч, Иерусалимд Пентекостын өдөр цугларсан хүмүүс (Ромоос ирэгсэд) болон Еврейчүүдийн өмнө ер бусын хэлээр ярьжээ. (Үйлс2:10). Тэнд цугларсан хүмүүсийн зарим нь Их Эзэн Есүст итгэн Ром уруу баяр хөөртэйгөөр буцсан. Дараа нь бүх Иудейчүүдийг Ромоос гарга гэсэн Клаудын зарлигаас болж Акул болон түүний эхнэр Прискила нар Коринт хотод суурьшин амьдрах болсон юм (Үйлс 18:2,3). Тэд майхан хийдэг байсан бөгөөд Паул ч мөн ийм зүйл хийдэг байжээ. Паул илгээлтийн гурав дахь аялалаа дуусгаад Коринтод ирж тэдэнтэй хамт байхдаа Ромын итгэгч нарын тухай ихийг сонссон болов уу. Тиймээс тэр энэ захиагаа Коринтод байхдаа бичсэн юм. Ромын итгэгч нар итгэмээргүй хүнд хавчлагтай учирч байсан. (Есүст итгэсэн итгэлээсээ болж алуулж байв.) Энэ захианд өгүүлсэн үнэн тэдний итгэлийг улам хүчтэй болгожээ.

Есүс Христийн зарц, хоригдол Паул

Паул Ромын итгэгч нарт өөрийгөө олон аргаар танилцуулж болох байв. Еврей хүний хувьд тэр хамгийн их боловсролтой хүн байжээ. Тэр Ромын иргэн болж төрсөн бөгөөд түүнд бүхий л эрх ямба байв. Түүний үйлчлэл нь асар их үр жимстэй байсан. Гэвч тэр эдгээрийн алинийг нь ч дурдаагүй бөгөөд харин тэр өөрийгөө Есүс Христийн зарц гэж хэлсэн. Зарц хүний хувьд тэр Өөрийн Эзэндээ бүхий л зүйлээр үнэнч байлаа. Паул үргэлж Есүс Христийн зарц байгаагүй юм. Тэр өмнө нь Түүнийг эсэргүүцэж, бүхий л зүйлээр Бурханы хүмүүсийг хавчиж байжээ.

Харин одоо Паул Ромын итгэгч нартай Есүс Христийн үхлээс дахин амилсан хүч чадлын тухай хуваалцаж байна. Паул өөрөө амьдралаараа үүнийг харуулж, амьд үлгэр дууриал болж байв. Паул гэдэг нь түүний Ром нэр байсан бөгөөд харин түүний Еврей нэрийг Саул гэдэг байжээ. Тэр шашинлаг байдлаасаа болж Стефаны үхлийг зөвшөөрсөн юм. Энэ нь итгэлээс болж анхны үхэлд хүргэсэн эрүү шүүлт байсаны (Үйлс 7:54-59) зэрэгцээ Иерусалимийн итгэгч нарын эсрэг өрнөсөн хавчлагын эхлэл болсон юм. **“Харин Саул чуулганыг хоосруулж, айлаас айлд орж эр, эм гэлгүй баривчлан шоронд хийж байлаа”**(Үйлс 8:3). Итгэгч нар энд тэндгүй тархаж сургаал номлож байлаа. **“Эзэний дагалдагчдыг алж хядна гэж заналхийлэн, Саул тэргүүн тахилч уруу очиж,**

²тэр Замд хамаарагдах эрэгтэй, эмэгтэй хэнийг ч болов барьж хүлж, Иерусалимд хүргүүлэхийн тулд Дамаскийн синагогуудад захидал илгээхийг түүнээс хүсжээ. ³Саул замд явж байлаа. Тэр Дамаскт дөхөн ирж байтал гэнэт тэнгэрээс гэрэл гарч түүнийг хүрээлэн гэрэлтэхэд, ⁴Саул газар хөсөр унав. Тэгээд

-Саул аа, Саул аа, юунд чи Намайг хавчина вэ? гэх дууг сонсоод,

5-Эзэн, Та хэн бэ? гэжээ. Тэгтэл Тэр

-Би бол чиний хавчиж мөшгөөд байгаа Есүс байна. (Үйлс 9:1-5)

Дараа нь Паул өөрийн харсан зүйлээ гэрчилсэн бөгөөд тэр Есүс Христийн тухай илүү ихийг ярьсан. ¹⁶Гэвч босож, хөл дээрээ зогс. Зөвхөн саяын харсан зүйлийн чинь төдийгүй, мөн хожим Миний чамд үзүүлэх зүйлсийн гэрч, үйлчлэгч болгон Би чамайг томиллоо. Энэ зорилгын үүднээс Би чамд үзэгдсэн юм. ¹⁷Чамайг энэ ард түмэн, харь үндэстнүүдээс чөлөөлөн аваад, Би тэдэн уруу илгээж байгаа нь ¹⁸тэдний нүдийг нээлгэж, тэднийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлэхийн тулд юм. Тэгснээрээ тэд Надад итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно” гэсэн.

(Үйлс 26:16-18)

ХИЧЭЭЛ 2. САЙН МЭДЭЭ БУРХАНЫ ЗӨВТ БАЙДЛЫГ ИЛЧИЛСЭН НЬ.

Ром1:16-17

¹⁶Би сайн мэдээнээс хүртээх зөвт байдал нь сайн ичихгүй. Яагаад гэвэл тэр мэдээний дотор илчлэгдсэн нь итгэгч хүн бүрийг, юуны бөгөөд итгэлээс итгэлд түрүүнд Иудей, мөн түүнчлэн хүргэдэг. Учир нь “Зөвт хүн Грек хүнийг авралд хүргэх итгэлээр амьдарна” гэж Бурханы хүч мөн. ¹⁷Бурханы бичигдсэн байдаг.

Бурхан бидэнд Өөрийн зөвт байдлаа өгсөн

Сайн мэдээ нь Бурханы зөвт байдлын тухай бөгөөд Есүс Христэд итгэсэн хүмүүст өгөгдсөн бэлэг мөн. Бурханы зөвт байдал нь итгэлээр илчлэгддэг ба эхлээд Есүс энэ бүгдийг миний төлөө хийсэн гэдэгт итгэснээр Бурханаас зөвт байдлыг хүлээж авна. Дараа нь итгэлээрээ Бурхан намайг Өөрийн Хүү Есүсийн адил зөвт болгоно гэдэгт итгэж амьдрах юм.

Аврал нь итгэсэн хүн бүрт зориулагдсан.

Аврал гэдэг нь чөлөөлөгдөх гэсэн утгатай. Энэ хичээлээр бид гэмт хүмүүс хэрхэн гэм болон Бурханы уур хилэнгээс чөлөөлөгдөх шаардлагатай байгаа тухай үзэх болно. (Иохан 3:36)

Аврал нь Еврейчүүдээр дамжуулан ирэх ёстой гэсэн Бурханы төлөвлөгөөний дагуу эхлээд Еврей хүмүүст ирсэн. (Иохан 4:22) Энэ нь тэднээр дамжин дэлхий даяар тархах ёстой ажээ. Бурхан Еврейчүүдийн өвөг болох Абрахамд, **Газар дэлхий дээрх бүх үндэстэн чамаар дамжуулан ерөөгдөнө гэж амлажээ.**

(Эхлэл 12:36). Абрахам Есүст итгэсэн бүх хүмүүсийн итгэлийн аав болно (Ром4).

Хийх зүйлс

Гол ишлэл болох Ром номны 1:16-17 цээжил.

ХИЧЭЭЛ 3. БУРХАНЫ УУР ХИЛЭН ТЭНГЭРЭЭС ИЛЧЛЭГДСЭН НЬ.

Ром 1:18-32

¹⁸Бурханы уур хилэн үнэнийг зөвтбусаарнуундарагч хүмүүсийн аливаа бурханлаг бус ба зөвт бус байдлын эсрэг тэнгэрээс илчлэгддэг. ¹⁹Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг юм. Учир нь Бурхан тэдэнд ил болгосон аж. ²⁰Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд,

Түүний мөнх хүч ба бурханлаг төрх нь бүтээгдсэн зүйлсээр дамжуулан ойлгогдон, илэрхий харагдаж байгаа. Иймээс тэдэнд шалтаг байхгүй. ²¹Яагаад гэвэл тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан хэмээн Түүнийг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй. Харин тэд бодол санаандаа хоосорч, мунхаг зүрх сэтгэл нь харанхуй болжээ. ²²Мэргэн

гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон бөгөөд ²³үл муудагч Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ.

²⁴Иймээс Бурхан тэднийг зүрх сэтгэлийнх нь хүсэл тачаалын бузар юмстай нь зөнд нь орхиж, тэднийг өөрсдийнхөө махан биеийг гутаахад хүргэжээ. ²⁵Яагаад гэвэл, тэд Бурханы үнэнийг худал хуурмагаар сольж, Бүтээгчээс илүү бүтээлд нь мөргөн, зарагджээ. Бурхан бол үүрд магтагдах Бүтээгч мөн. Амен.

²⁶Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхижээ. Тэдний эмэгтэйчүүд ч бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ. ²⁷Түүнчлэн эрчүүд ч эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа орхиод, нэг нэгэндээ тэмүүлэх хүсэлдээ шатаж,

эрчүүд эрчүүдтэйгээ ичгүүрт зүйлийг үйлдэж, өөрсдийн алдааны зохих цээрлэлийг өөрсдөдөө хүртэж байна.

²⁸Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан учраас Бурхан тэднийг завхарсан сэтгэлтэй нь зөнд нь орхиж, хийх ёсгүй зүйлсийг үйлдэхэд хүргэсэн бөгөөд ²⁹тэд бүхий л зөвт бус байдал, хорон муу, шунал, бузар булайгаар дүүрэн, атаа жөтөө, аллага, хэрүүл, заль мэх, хар санаагаар дүүрэн, хов жив яригч, ³⁰гүтгэгч, Бурханыг үзэн ядагч, дээрэлхүү, их зантай, сагсуу, хорон мууг санаачлагч, эцэг эхдээ дуулгаваргүй, ³¹ухваргүй, найдваргүй, үл хайрлагч, өршөөл үзүүлдэггүй хүмүүс ажээ. ³²Ийм зүйлсийг үйлдэгч нь үхвэл зохино гэсэн Бурханы зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, харин ч бусдыг үйлдэхэд нь сайшаадаг ажээ.

Гэмийн эсрэг Бурханы уур хилэн

Бурхан бол ариун. Анхны хос болох Адам Ева хоёр Бурханд дуулгаваргүй байснаараа гэмтэй болж тэдэнд зориулж бүтээсэн үзэсгэлэнт цэцэрлэгээс хөөгдсөн юм. Тэд Бурханаас тусгаарлагдаж (сүнсний үхэл), тэдний бие махбодь үхэлд захирагдаж эхлэсэн.

Бурханы уур хилэн бол Түүний ариун хэмжээст үл хүрэх аливаа хандлага болон хийж буй үйлдлийн эсрэг байдаг юм. Бид гэм ямар аймшигтай зүйл вэ гэдгийг мэддэг байх хэрэгтэй .

Бурханлаг бус хүмүүст шалтаг олдохгүй

Библигүй ч гэсэн хүн бүр Бурханы хүч чадал ба зан чанарыг Түүний бүтээсэн зүйлсээс мэдэж болно. “¹⁷Гэвч Тэр Өөрийгөө гэрчгүйгээр орхиогүй билээ. Тэр та нарт сайныг үйлдэн, тэнгэрээс хур бороо оруулж, үр жимстэй улирлыг хайрлаж, зүрхийг тань хоол хүнс, баяр баяслаар цатгадаг гэв” (Үйлс14:17).

Бурханы хуулийг мэддэгүй хүн хүртэл үүнийг хардаг. Тэдний мөс чанар ч хамт гэрчилж, тэдний бодол санаа ч нэг нэгнээ буруутгадаг, эсвэл өмгөөлдөг. (Ром 2:156)

Бурханыг мэдэхийг хүсдэггүй хүн Бурханы тухай үнэнийг хүлээн авдаггүй. Тэд өөрчлөгдхийг хүсдэггүй. Яагаад гэвэл тэд аврагдахын тулд үнэний хайрыг хүлээн аваагүй. ¹¹Тиймээс Бурхан тэдний дээр төөрөгдлийн ажиллагааг илгээдэг. Тэгээд тэд худал хуурмагт итгэх болно. ¹²Ингэснээр үнэнд итгээгүй, харин бузар мууг таалсан бүх хүн яллагдах юм (2 Тесалоник 2:106-12).

Гэмийг шүүх Бурханы нэг арга бол гэмээ дахин дахин хийгээд байгаа хүмүүсийг тэр буруу сонголтонд нь орхих явдал юм. ¹³Тэд Түүний үйлсийг хурдан мартжээ.

Тэд Түүний зөвлөгөөг хүлээгээгүй.... ¹⁵Иймээс Тэр тэдэнд шаардсаныг нь өгсөн боловч Тэдний сүнсийг эцээх өвчинг илгээсэн (Дуулал 106:13,15).

Хийх зүйлс

Доорх ишлэлүүдийг нөхөж бич.

1. Бурханыг мэдсэн атлаа Бурхан хэмээн Түүнийг _____ ч үгүй, Түүнд _____ өргөсөн ч үгүй. Харин тэд бодол санаандаа хоосорч, мунхаг зүрх сэтгэл нь харанхуй болжээ. (ишлэл 21)

2. _____ гэж хэлдэг атлаа тэд _____ болсон. (22)

3. Бурханы _____ мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил _____ сольжээ. (23)

4. Бурхан тэднийг зүрх сэтгэлийнх нь хүсэл тачаалын _____ юмстай нь зөнд нь орхиж, тэднийг өөрсдийнхөө махан биеийг _____ хүргэжээ. (24)

5. Тэд Бурханы _____ сольж, _____ илүү _____ нь мөргөн, үйлчилжээ. (25)

6. Бурхан тэднийг _____ нь орхижээ. Тэдний _____ бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ. (26) Түүнчлэн мөн _____ эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа больжээ. (27)

[²²Эр хүн эмэгтэйтэй унтдагийн адил, чи эр хүйстэнтэй бүү унт. Энэ нь жигшүүрт юм.] (Левит 18:22).]

7. Тэд Бурханыг мэдэх нь зохистой гэж үзээгүй шиг, Бурхан тэднийг _____ сэтгэлтэй нь зөнд нь орхив. (28)

8. Ийм зүйлсийг үйлдэгч нь _____ зохино гэсэн Бурханы _____ тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, харин бусдыг үйлдэхэд нь _____ ажээ. (32)

[³⁰Иймээс ч Бурхан харанхуй балар үеийг харалгүй өнгөрөөсөн. Харин эдүгээ хаа сайгүй хүн бүхэн гэмших ёстойг Тэр хүмүүст хандан тунхаглаж байна. ³¹Өөрийнхөө томилсон нэгэн Хүнээр дамжуулж ертөнцийг шударгаар шүүх өдрөө Тэр тогтоосон агаад тэр Хүнийг үхэгсдээс амилуулснаар үүнийгээ бүх хүмүүст нотолсон ажгуу хэмээв.

(Үйлс 17:30,31)]

ХИЧЭЭЛ 4. БУРХАНЫ ШҮҮЛТ БОЛ ШУДАРГА ЮМ.

Ром 2:1-16

¹Тиймээс шүүдэг хүн бүр ээ, танд шалтаг байхгүй. Учир нь бусдыг шүүдгээрээ та өөрийгөө ялладаг. Яагаад гэвэл шүүдэг та мөн л эдгээрийг үйлддэг шүү дээ. ²Харин ийм зүйлсийг үйлддэг хүмүүс дээр буух Бурханы шүүлт нь үнэний дагуу байдгийг бид мэднэ. ³Ийм зүйлсийг үйлддэг хүмүүсийг шүүдэг атлаа өөрөө мөн л тэдгээрийг үйлддэг хүн ээ, та Бурханы шүүлтээс мултарна гэж бодож байна уу? ⁴Эсвэл та Бурханы энэрэл өөрийг чинь гэмшүүлдэг гэдгийг мэдэлгүй, Түүний энэрэл, хүлцэл ба тэвчээрийн баяныг басамжлах уу? ⁵Харин та өөрийн хатуу байдал,

гэмшдэггүй зүрх сэтгэлээсээ болж уур хилэн ба Бурханы зөв шүүлтийн илчлэлтийн өдөр байх хилэгнэлийг өөр дээрээ хурааж байна. ⁶Бурхан хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө. ⁷Сайныг үйлдэхдээ тэвчээртэйгээр алдар, хүндэтгэл болон мөхөшгүй байдлыг хайдаг хүмүүст мөнх амь өгнө. ⁸Харин хувиа хичээгч, үнэнийг дагадаггүй, харин зөв бусыг дагадаг хүмүүст уур хилэн ба хилэгнэл буулгана. ⁹Бузар мууг үйлдэгч хүн бүрийн дээр цөхрөл, зовлон байх болно. Юуны түрүүнд энэ нь Иудей, мөн түүнчлэн Грек хүмүүст байна. ¹⁰Харин сайныг үйлдэгч хүн бүрд алдар, хүндэтгэл ба

амар тайван нь байх болно. Юуны түрүүнд энэ нь Иудей мөн түүнчлэн Грек хүмүүст байна. ¹¹Бурханд ялгаварлах үзэл байдаггүй. ¹²Хуульгүйгээр нүгэл үйлдсэн бүх хүн мөн Хуульгүйгээр мөхөх болно. Хуулийн дор нүгэл үйлдсэн бүх хүн Хуулиар шийтгэгдэх болно. ¹³Учир нь Хуулийг сонсогчид нь Бурханы өмнө зөв байх бус, харин Хуулийг биелүүлэгчид нь зөвтгөгдөх болно. ¹⁴Харь үндэстнүүд Хуульгүй боловч

төрөлх байдлаараа Хуулийн зүйлсийг үйлдвэл, Хуульгүй боловч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог. ¹⁵Хуулийн шаарддаг үйлс нь тэдний зүрх сэтгэлд бичигдсэнийг тэд харуулдаг. Тэдний мөс чанар ч хамт гэрчилж, тэдний бодол санаа ч нэг нэгнээ буруутгадаг, эсвэл өмгөөлдөг. ¹⁶Миний сайн мэдээний дагуу, энэ нь Бурхан хүмүүсийн нууц зүйлсийг Христ Есүсээр шүүх өдөрт болно.

Шашинлаг гэмтэнгүүд мөн шүүгдэх болно.

Энэ хичээлээр бид библид ыБурханы уур хилэн ёс суртахуунгүй хүмүүсийн дээр бууна хэмээн бичигдсэний дагуу эдгээр хүмүүсийн тухай үзэх болно. Тэд өөрсдийнх нь гэм бусдынхаас бага байвал зөвт байна хэмээн үздэг хүмүүс юм.Тэд хүн бүр Бурханы мэлмийд гэмтэй харагддаг гэдгийг ухаардаггүй. Бурхан маш удаан тэвчдэг учраас тэднийг одоо хүртэл устгаагүй юм. Бурханы нигүүлсэнгүй сэтгэл хүмүүст гэмших боломж олгодог. Бурхантай санал нийлнэ гэдэг нь гэмээ ухаарна гэсэн үг юм. Харин гэмшихийг хүсдэггүй хүмүүс Бурханы нигүүл сэлийг үзэн яддаг. Тэдний зүрх хатуурсан байдаг учир нь тэд Бурханы үгийг сонсдог ч Түүний үгийг дагадаггүй. **“²²Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бологтун” (Иаков1:22)**

“²¹Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно. ²⁶Эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үл үйлддэг аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. ²⁷Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэнд байшин нурав. Эвдрэл нь асар их байлаа гэв.” (Матай 7:21,26,27) ... **“Хэрэв хэн нэг нь Намайг хайрлавал, тэр хүн Миний үгийг сахина.”** (Иохан 14:23а). Есүсийг жинхэнээсээ хайрладаг хүн Түүнийг дагах болно .

Хийх зүйлс

Бурханы шүүлтийн зарчмын тухай ишлэлийг нөхөж бич.

1. Харин ийм зүйлсийг үйлддэг хүмүүс дээр буух Бурханы шүүлт нь _____ дагуу байдгийг бид мэднэ. (Ишлэл 2)

[Бурханы шүүлт баримттай байна. **ЭЗЭНИЙ МЭЛМИЙ ХАА Ч БАЙДАГ БА**

Хорон мууг хийгээд сайныг хардаг. (Сургаалт үгс 15:3)]

2. Бурхан хүн бүрд _____ нь дагуу хариуг өгнө. (6) _____ үйлдэгч хүн бүрийн дээр цөхрөл, зовлон байх болно. (9) Харин _____ үйлдэгч хүн бүрд алдар, хүндэтгэл ба амар тайван нь байх болно. (10)

[Есүсээс ингэж асуужээ. **Бид Бурханы ажилыг хийхийн тулд юу хийх ёстой вэ? Харин тэр “Та нар Бурханы илгээсэн нэгэнд итгэх нь Түүний ажил мөн гэж хариулав”.** (Иохан 6:28б, 29б) **Есүст итгэх жинхэнэ итгэл гэдэг бол сайн зүйлс хийж Түүнийг алдаршуулах явдал юм.** (Матай 5:16)]

3. Бурханд _____ үзэл байдаггүй. (11)

“²⁵Учир нь буруу юм хийсэн хүн, хэн ч бай ялгаагүй, хийсэн буруу зүйлийнхээ уршгийг хүртэнэ. (Коллосай 3:25). **“Бүү мэхлэгд. Бурхан элэг доог болохгүй. Юу гэвэл хүн юу тарьснаа л хурааж авдаг.”** (Галат 6:7)

4. Миний сайн мэдээний дагуу, энэ нь Бурхан хүмүүсийн нууц зүйлсийг _____ шүүх өдөрт болно. (16)

“²²Учир нь Эцэг хэнийг ч шүүхгүй, харин Тэр бүх шүүлтийг Хүүдээ даатгасан.”

(Иохан 5:22)]

Бид бүгд Есүс Христийн өмнө шүүгдэх болно

Есүстэй харилцах бидний харилцаа амьдрал болон үхэлтэй салшгүй холбоотой учир нь Тэр биднийг шүүх Нэгэн юм. **“Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон, ²⁹гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, муу үйлийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ.** (Иохан 5:28б, 29). **¹⁰Учир нь хүн бүр мууг ч бай, сайныг ч бай, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахын тулд бид бүгдээрээ Христийн шүүхийн суудлын өмнө гарч ирэх ёстой.”** (2 Коринт 5:10)

Бурханы өндөр стандартад хүрч Түүнтэй уулзана гэдэг нь

боломжгүй юм. Бид бүгд Бурханы уур хилэнг хүртсэн. (Сүнсээрээ үүрд үхмэл болсон.) Гэвч өөрийн амьдралаа зөвт болгон шүүгдүүлэх арга зам байдаг. Есүс миний төлөө үхсэн гэдэгт итгэж Түүний шинэ амьдралыг хүлээж авснаар бид зөвтөгдөх болно. “³⁶Хүүд итгэдэг хүн мөнх амьтай. Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн тэр хүн дээр байдаг.” (Иохан3:36). “Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь руу шилжив. (Иохан 5:24б).

ХИЧЭЭЛ 5. ОНЦГОЙ ЭРХ ЯМБА БИДНИЙГ АВАРЧ ЧАДАХГҮЙ.

Ром 2:17-29

¹⁷Хэрэв та Иудей хэмээх нэр зүүж, Хуульд найдан, Бурханаар сайрхдаг агаад ¹⁸Хуулиас заалгаснаар Түүний хүслийг мэдэн, онц сайн юмсыг таньдаг юм бол, ¹⁹мөн Хууль дотор мэдлэгийн болон үнэний цогцтой гээд, сохруудын газарч, харанхуйд байдаг хүмүүсийн гэрэл, ²⁰мунхаг хүмүүсийн сургагч, балчир хүмүүсийн багш гэж өөртөө итгэлтэй байдаг юм бол, ²¹тэгвэл бусдад заагч та өөртөө заадаггүй юм уу? Хулгай бүү хий гэж номлодог та өөрөө хулгай хийдэг юм уу? ²²Бүү завхайр гэж ярьдаг та өөрөө завхайрдаг юм уу? Шүтээнүүдийг жигшдэг та өөрөө сүмүүдийг тонодог юм уу? ²³Хуулиар сайрхагч та өөрөө Хуулийг зөрчсөнөөрөө Бурханыг

гутаадаг юм уу? ²⁴Учир нь “Бурханы нэр та нараас болж харь үндэстнүүдийн дунд доромжлогддог” гэж бичигдсэн байдаг. ²⁵Хэрэв та Хуулийг биелүүлбэл хөвч хөндөлт нь тустай ажээ. Харин та Хуулийг зөрчигч нь мөн бол таны хөвч хөндөлт чинь хөвч хөндөлт биш болдог. ²⁶Тиймээс хэрэв хөвч хөндүүлээгүй хүн Хуулийн шаардлагуудыг сахивал тэр хүнийг хөвч хөндүүлээгүй бус, харин хөвч хөндүүлсэн гэж үзэх бус уу? ²⁷Хөвч хөндөлтийг биедээ хийлгээгүй хүн хэрэв Хуулийг сахивал, Хуулийн үсэг болон хөвч хөндөлттэй атлаа Хуулийг зөрчигч таныг шүүх бус уу? ²⁸Учир нь гаднах байдлаараа иудей нь иудей хүн биш бөгөөд махан биеийн гаднах хөвч хөндөлт нь ч хөвч хөндөлт биш. ²⁹Харин доторх байдлаараа иудей нь иудей

хүн мөн. Үсгээр бус, Сүнсээр хийлгэсэн зүрх сэтгэлийн хөвч хөндөлт нь хөвч хөндөлт мөн. Тэр хүний магтаал нь хүнээс бус, харин Бурханаас ирдэг юм.

Ром 3:1-8

¹Иймээс иудей хүний давуу тал, эсвэл хөвч хөндөлтийн ашиг нь юу вэ? ²Аль ч талаараа үлэмж их юм. Бүхнээс өмнө, Бурханы үгс тэдэнд даатгагдсан билээ. ³арим нь итгээгүй бол яах вэ? Тэдний итгэлгүй байдал Бурханы итгэмжит байдлыг хүчингүй болгоно гэж үү? ⁴Бүү ийм байх болтугай! Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн байг. Энэ тухай

“Та айлдахдаа зөвтөгдөж Та шүүгдэхдээ ялна”
5Хэрэв бидний зөв бус нь Бурханы зөвийг харуулдаг юм бол, бид юу хэлэх билээ? Уур хилэн буулгагч Бурхан нь зөв биш гэж үү? Би хүний ёсоор ярьж байна. ⁶Бүү ийм байх болтугай! Тийм бол Бурхан ертөнцийг яаж шүүх юм бэ? ⁷Хэрэв миний худал үгээр Бурханы үнэн нь Өөрийнх нь алдар дотор бялхдаг юм бол яагаад би одоо ч гэсэн нүгэлтэн адил шүүгддэг билээ? ⁸“Сайныг гаргахын тулд мууг үйлдэцгээе” гэж ярьж болохгүй гэж үү? Зарим нь биднийг ингэж ярьдаг хэмээн гүтгэн хэлдэг. Тэдний шийтгэл нь шударга юм.

Хийх зүйлс

1. Хэрэв та _____ хэмээн нэр зүүж.(Ишлэл17)

[Еврей гэдэг үг Иуда гэдэг үгнээс гаралтай бөгөөд утгачилбал “Талархах” гэсэн утгатай. Иуда Израйлын 12 аймгийн нэг байсан. Бурхан Еврейчүүдийг Өөрийг нь магтуулахаар сонгосон. Есүс Израйлын аймгийн энэ овогт төрсөн.]

2. _____ найдан, (17) [Бурханы хууль нь Египетээс изриальчууд гарсны дараа Мосегээр дамжин өгөгдсөн. Еврей хүмүүсийн амьдралыг Бурханы энэ хууль төвлөрүүлж байсан.]

3. Чи _____ сайрхдаг агаад (17)

[Еврей хүмүүс цорын ганц үнэн Бурхан тэдний Бурхан гэдэгт итгэж бахархадаг байсан бөгөөд]

4. Түүний _____ мэдэн., (18)

5. Тэд _____ юмсыг таньдаг. (18)

[Тэд Бурханы үгийг хуучин гэрээгээр дамжуулан мэддэг байсан.]

Хоёр нүүр гаргахын аюул

Паул Бурханы тухай сургадаг хүмүүст хэдэн асуулт тавьсан.

1. тэгвэл бусдад заагч та өөртөө заадаггүй юм уу? Хулгай бүү хий гэж номлодог та өөрөө _____ хийдэг юм уу?(21)

2. Бүү завхайр гэж ярьдаг та өөрөө _____ юм уу?
(22)

3. Шүтээнүүдийг жигшдэг та өөрөө сүмүүдийг _____ юм уу?(22)

4. Хуулиар сайрхагч та өөрөө Хуулийг _____ Бурханыг гутаадаг юм уу?(23)

Бурханы хүмүүс Бурханы стандартад хүрч амьдарч чадахгүй болохоороо Түүний нэрийг хүндлэхээ больдог. Ийм зүйл Хаан Давидад тохиолдсон. **“¹⁴Харин хийсэн энэ хэргээрээ чи ЭЗЭНий дайснуудад доромжлогдоно.”**... (2 Самуел 12:14а)

Бурханы нэрээр гэм хийх нь маш аймшигтай зүйл. Өнөөдөр олон хүмүүс өөрсдийгөө итгэгч хэмээн дууддаг боловч тэд гэмтэй амьдралаараа Бурханы нэрийг гутааж байдаг. Есүс Хоёр нүүртэнгүүдэд хандан олон зүйл хэлсэн.

⁷Зальхай хүмүүс ээ, Исаиа та нарын тухай зөв эш үзүүлсэн юм. Ингэхдээ ⁸Энэ ард түмэн Намайг амаараа хүндэлдэг.

Гэвч тэдний зүрх Надаас алс хол байдаг.

⁹Тэд хүнээс гарсан тушаал зааврыг сургаж,

Надад дэмий хоосноор мөргөж байна (Матай 15:7-9).

Хоёр нүүртэй хүмүүс Бурхан уруу ирж байгаа хүмүүсийг холдуулдаг. Есүс хэлэхдээ **“Түүнийг сүсэгтэн болоход та нар түүнийг өөрсдөөсөө хоёр дахин дор тамын хүү болгодог ажээ.** (Матай 23:15б). Зүрх сэтгэлдээ Бурхангүйгээр байдаг мөртлөө бусдад зөвт юм шиг харагддаг хүмүүс илүү аюулд орно. Есүс Тэдний тухай хэлэхдээ **“³³Могойнууд аа, хорт могойн удам аа, тамын шийтгэлээс та нар яаж зугтаах вэ? (Матай 23:33). “⁸Бурхан амийг эрдэг бөгөөд тэрээр таслагдсан байхад бурхангүй хүний найдлага юу байдаг вэ? (Иов 27:8)**

Харин зүрхэндээ бурхангүй хүмүүс уур хилэнг нөөцөлдөг. (Иов 36:16а). Бурханаас өөрийн зүрхийг хэн мэдэж чадах вэ хэмээн асуугаарай.

Жинхэнэ сүнслэг хүн

Жинхэнэ Еврей хүмүүс Бурханд талархан Есүс Христийн хүчээр өөрийн амьдралаасаа гэмийг зайлуулж байсан. Абрахам хөвч хөндүүлэн Бурхантай гэрээ хийсэн. Энэ гэрээ нь Бурхан бидний зүрх сэтгэлд байх тэмдэг болсон. **“11Христийн хөвч хөндөх ёслолоор махбодын биеийг тайлан, Түүн дотор та нар бас хүний гараар үйлдэгдээгүй хөвч хөндөх ёслолыг хийлгэсэн. (Коллосай 2:11).** Мосе хүмүүст ингэж хэлж байсан. **“6ЭЗЭН Бурхан чинь чамайг өөрийн Бурхан ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэлээрээ хайрладаг болгохын тулд чиний зүрхэнд, чиний үр хүүхдүүдийн зүрхэнд хөвч хөндөх ёслол хийнэ. (Дэд хууль 30:6)**

Паул Еврейчүүдийн эсэргүүцэлд хариулсан нь

Гэмтэй Еврейчүүдэд аврал яагаад хэрэгтэй вэ? “Еврейчүүдэд ямар давуу тал байгаа вэ?” гэж зарим нь хэлж магадгүй юм. Паул хэлэхдээ олон давуу талууд байгаа гэж хэлсэн. “Итгэлгүй Еврей хүмүүст Бурханы амласан хэрэгжихгүй байх уу? Паул “үгүй” гэж хэлжээ. Бурхан итгэлгүй хүмүүст хүртэл өөрийн итгэлтэй үгээ хэлж байжээ.

ХИЧЭЭЛ 6. ХЭН Ч БУРХАНЫ ӨМНӨ ЗӨВТ БАЙЖ ЧАДАХГҮЙ

Ром 3:9-20

⁹Тэгвэл яах вэ? Бид тэднээс давуу юм уу? Огт үгүй. Иудейчүүд болон грекчүүд бүгд нүгэл дор байдаг гэж бид урьд нь ял тулгасан юм. ¹⁰Энэ нь ингэж бичигдсэнчлэн, “Зөвт хүн алга. Ганц ч алга. ¹¹Ухаардаг хүн алга. Бурханыг хайдаг хүн алга. ¹²Бүгд гажиж, цөмөөрөө хэрэгцээгүй болжээ. Сайныг үйлддэг хүн алга. Бүр ганц ч алга”. ¹³“Тэдний хоолой нь онгорхой булш юм. Тэд хэлээрээ хуурч мэхэлдэг”. “Тэдний уруул дор могойн хор бий”. ¹⁴“Тэдний ам хараал болон гашуун үгээр дүүрэн аж”.

¹⁵“Тэдний хөл цус урсгахдаа түргэн, ¹⁶тэдний замд сүйрэл болон гай гамшиг бий. ¹⁷Тэд амар амгалангийн замыг мэдэхгүй”.

¹⁸“Тэдний нүдний өмнө Бурханаас эмээх айдас үгүй” ¹⁹Хуулийн хэлж байгаа болгон нь Хуулийн дор байгч хүмүүст хандан ярьдаг гэдгийг бид мэддэг. Ингэснээр ам болгон таглагдаж, ертөнц даяараа Бурханы өмнө буруутгагдах болно. ²⁰Яагаад гэвэл ямар ч махан бие Хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй. Хуулиар нүглийн мэдлэг ирдэг юм.

Бүх дэлхий Бурханы өмнө зогсох болно.

Паул эрх мэдэл бүхий шүүхийн өмнө гарч ирэн бүх хүн төрөлхтөн Ариун Бурханы өмнө гэмтэй байх болно хэмээн хэлсэн. Бурханыг болон Түүний хуулийг мэддэггүй хүн хүртэл Бурханы уур хилэнг хүртэх болно. Учир нь тэд Бүтээгч Эзэнд талархаж Түүнд магтаал өргөсөнгүй. (Хичээл3)

Бурханы хуулийг мэддэг шашинлаг хүмүүс хүртэл шүүгдэх болно. (хичээл4).

Еврейчүүд Бурхантай харилцаатай байгаагийн тэмдэг болгож хөвч хөндүүлж Бурханы хуулийг дагасан боловч тэдний зүрх Бурханаас хол учир тэд мөн шүүгдэх болно. (Хичээл 5).

Хийх зүйлс

Хуучин гэрээн дээр гардаг шүүлтийн тухай 14 ишлэлийг нөхөж бич.

1. Энэ нь ингэж бичигдсэнчлэн, «Зөвт хүн _____ . _____ ч алга.(10)

[Дэлхий дээр Есүс Христээс өөр хэн ч Бурханы төгс стандартад хүрч чадахгүй. **“Есүс Христ бол зөвт юм”**. (1 Иохан 2:16)]

2. Ухаардаг хүн _____ . (11)

“¹⁴Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг” (1 Коринт 2:14)]

3. Бурханыг хайдаг хүн _____ . (11)

[Хүмүүс нуугддаг боловч Бурхан тэднийг хайдаг. **“¹⁰Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ гэв.”** (Лук 19:10)]

4. _____ гажиж., цөмөөрөө хэрэгцээгүй болжээ. (12)

[Хүмүүс өөрсдийн замаар явахыг хүсдэг. **“⁶Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав.”** (Исаиа 53:6a)]

5. Цөмөөрөө _____ болжээ. (12)

[Гэм хүнийг Бурханаас холдуулдаг. Давс амтаа алдахад. **“Энэ нь гадагшаа хаягдаж, хүмүүсийн хөл доор гишгэгдэхээс өөр юунд ч хэрэг болдоггүй.** (Матай 5:13б).]

6. Бүгд гажиж, цөмөөрөө хэрэгцээгүй болжээ. _____ үйлддэг хүн алга. Бүр _____ ч алга». (12)

“Сайн нь зөвхөн Ганц байдаг”.....(Матай19:17б).]

7. «Тэдний _____ нь онгорхой булш юм.

[Бурханаас тусгаарлагдах нь сүнсээр үхмэл байна гэсэн үг. (Ефес 2:1) Тиймээс муу үгс хүний амнаас амархан гардаг.] (13)

8. Тэд хэлээрээ _____.(13) [**“3Түүний амнаас гарах үг нь хорон муухай бөгөөд хуурамч юм. Тэр мэргэн ухаан ба сайн үйлсээ зогсоосон.”**] (Дуулал 36:3).

9. Тэдний уруул дор _____ бий».(13) [**“8Харин хэн ч хэлийг номхруулж чадахгүй. Хэл бол үхлийн хороор дүүрсэн, амралтгүй бузар эд мөн.”**] (Иаков 3:8).

10. «Тэдний ам _____ болон _____ үгээр дүүрэн аж»

[Хараах нь эелдэг бусаар ярина гэсэн үг. Ерөөнө гэдэг нь бусадтай эелдэг ярихыг хэлдэг. (14) **“10Магтаал, хараал нэг л амнаас гардаг аж. Ах дүүс минь, ийм байж болохгүй. (Иаков 3:10) “15Хэн чинь ч Бурханы нигүүлслээс салахгүйн тулд болон ямар ч гашуун үндэс урган хор учруулан, түүгээр олон хүн бузарлагдахгүйн тулд сэрэмжил”.** (Еврей 12:15)].

11. «Тэдний хөл _____ түргэн, [Энэ бол өнөөдрийн дэлхийн дүр төрх. Хүн алахын эх үүсвэр нь үзэн ядалт байдаг. (15) **“15Ах дүүгээ үзэн яддаг нэгэн нь алуурчин мөн. Ямар ч алуурчны дотор мөнх амь байдаггүйг та нар мэднэ”** (1 Иохан 3:15)]

12. Тэдний замд сүйрэл болон _____ бий. (16) [**“17Яагаад гэвэл чи “Би баян. Баяжсан тул дутах зүйл ер байхгүй” гэдэг. Чи өөрийнхөө хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, ядуу, сохор, нүцгэн байгааг мэдэхгүй байна.”**] (Илчлэлт 3:17)

13. “Тэд _____ замыг мэдэхгүй” (17)

[**“20Гэвч нүгэлтнүүд нь шидлэн давалгаалах далай мэт юм. Учир нь далай бол дөлгөөн байж чаддаггүй, ус нь хог, шавар шидлэн гаргадаг билээ. ²¹“Хилэнцтэнд амар амгалан байхгүй” гэж миний Бурхан айлдаж байна. (Исаиа 57:20, 21)**].

14. «Тэдний нүдний өмнө Бурханаас эмээх _____ үгүй» (18)

[**“13ЭЗЭНээс эмээхүй бол хорон мууг үзэн ядах явдал юм. Бардамнал, ихэмсэг зан, хорон муу зам ба гажсан амыг би жигшдэг. ²⁷ЭЗЭНээс эмээхүй нь амийн ундарга болой.**

Энэхүү эх булаг нь үхлийн зангыг зайлуулах боломжтой. (Сургаалт үгс 8:13, 14:27)]

Хүн төрөлхтний эсрэг Бурханы шүүлт

Паул хааяа Бурханы шүүлтийн тухай ярьдаг байсан. (Хуучин гэрээн дээр). ”⁹Зүрх бол бүх зүйлээс илүү хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй юм. Үүнийг хэн ойлгож чадах билээ? ¹⁰ЭЗЭН Би зүрхийг эрэлхийлж, оюун бодлыг шалгадаг нь хүн бүрд замуудынх нь дагуу, үйлсийнх нь үр дүнгийн дагуу өгөхийн тулд юм.” (Иеремиа 17:9,10).

Хүний зан авирын эсрэг Бурханы шүүлт

Эхний зургаан шүүлтэд хүний зөвт бус зан авирын тухай Дуулал номны 14:1-3 гардаг. “¹Мунхаг хүн зүрхэндээ “Бурхан байдаггүй” гэсэн. Тэд завхарцаасан, тэд жигшүүртэй үйлс хийсэн. Сайн үйл хийдэг хүн огт байхгүй. ²ЭЗЭН тэнгэрээс хүний хөвгүүд уруу өнгийн харсан нь ойлгодог, Бурханыг эрэн хайдаг хүн байгаа эсэхийг харахын тулд юм. ³Тэд бүгдээрээ дур мэдэн явцгааж, Тэд хамтдаа завхарцаасан. Сайн үйл хийдэг хүн байхгүй, Нэг ч байхгүй.”

Хүний үг ярианы эсрэг Бурханы шүүлт

Дараагийн дөрвөн шүүлт нь хүний амтай холбоотой. ⁹Тэдний хэлж байгаа зүйлсэд итгэх юм юу ч үгүй. Тэдний зүрх сэтгэл нь сүйрэл юм. Тэдний хоолой нь онгорхой булш юм. Тэд хэлээрээ магтан хөөрөгддөг. (Дуулал 5:9) ³Тэд могой шиг хэлээ билүүддэг.

Тэдний уруул дор хорт могойн хор байдаг. (Дуулал 140:3) ⁷Түүний ам нь хараал, ов мэх, хавчлагаар дүүрэн.

Түүний хэлэн дор саад төвөг болон хорон санаа байдаг.

(Дуулал 10:7). Яагаад бидний хэл яриа бидний зүрх сэтгэлийг илэрхийлдэг вэ? Есүс хэлэхдээ. “Учир нь зүрхний бялхалаас ам ярьдаг.” (Матай 12:34б). Сүүлд нь тэр хэлэхдээ “Харин амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг.” (Матай 15:18).

Хүний замын эсрэг Бурханы шүүлт

Дараагийн гурван шүүлт нь хүний хөл болон түүний замтай холбоотой. “⁷Тэдний хөл нь муу уруу гүйн, гэм буруугүй цусыг урсгахдаа яардаг. Тэдний бодол нь хилэнцэт бодол бөгөөд тэдний замд эвдрэл, сүйрэл бий. ⁸Тэд энх тайвны замыг

мэдэхгүй, тэдний замд нь шударга ёс гэж байхгүй. Тэд замаа муруй хазгай тавьснаас энэ замаар явагчид нь энх амгаланг үл мэднэ.” (Исаиа 59:7,8)

Бурханы эцсийн шүүлт

Хамгийн сүүлчийн шүүлт нь бардамнал болон зөвт бус байдлын эсрэг шүүлт юм. Түүний нүдэнд Бурханаас эмээхүй нь үгүй. Учир нь тэр өөрийгөө дөвийлгөж..... (Дуулал 36:16, 2а)

Бүх дэлхий шүүлтийн өмнө буруутай байх болно.

Бурхан бүх зүрхийг хайж байдаг. Тэр дэлхийг Өөрийн үг болон хуулиараа шүүх бөгөөд энэ шүүлт бидний гэмийг илчлэнэ. Бурханы хуулийг бүх хэлбэрээр дагасан ч Бурханы хараанд зөвт байна гэдэг боломжгүй юм. **“¹⁰Учир нь бүх хуулийг сахивч нэг дээр нь бүдрэх хэн боловч бүх хуулийг зөрчсөн болно.”** (Иаков 2:10). Одоо бид гэмтэй гэдгээ харлаа. Бурхан бүх дэлхийг буруутгах болно. Бүх дэлхий Бурханы өмнө дуугүй байх болно. Агуу Бурханы өмнө хэн ч өөрийгөө өмгөөлж чадахгүй. Гэмтэй гэдэг үгийг Ром номны 3:19 үгчлэн орчуулбал шийтгэх гэсэн утгатай байдаг. Хүн төрөлхтөн үхлээр шийтгэгдсэн. Адам өөрийн замаар Бурханы энгийн тушаалуудыг эсэргүүцэн зөрчсөн. **“¹⁶Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв. -Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. ¹⁷Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав.”** (Эхлэл 2:16,17)

“²³Учир нь нүглийн хөлс бол үхэл” (Ром 6:23а).

Паул биднийг өөрсдийгөө Бурханы өмнө зөвтгөх нь боломжгүй гэдгийг болон Бурханы өмнө биднийг буруутай гэдгээ мэдээсэй мөн бидэнд Аврагч хэрэгтэй гэдгийг олж хараасай гэж хүссэн. Тэр хүн төрөлхтний муу муухай харанхуй зүйлийн тухай дүрсэлдэг боловч дараагийн бүлэгт хэрхэн агуугаар гэрэлтэх тухай гарна.

ХИЧЭЭЛ 7. ГЭМТЭНГҮҮДИЙГ АВРАХ БУРХАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ: ИТГЭЛЭЭР ЗӨВТГӨГДӨХ БЭЛЭГ

Ром 3:21-31

“²¹Харин эдүгээ Бурханы зөв нь Хуулиас ангид илэрхийлэгдэв. Үүнийг Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилсэн юм. ²²Есүс Христэд итгэх итгэлээр Бурханы зөв нь итгэгч бүх хүнд байна. Ялгаварлал байхгүй. ²³Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй, ²⁴харин Христ Есүс доторх золилтоор дамжуулан Түүний нигүүлслээр үнэгүй зөвтгөгдсөн билээ. ²⁵Түүний цусанд итгэх итгэлээр дамжуулан Бурхан Түүнийг эвлэрүүлэл гэж нийтэд харуулав. Ингэсэн нь Бурхан урьд нь үйлдэгдсэн нүглүүдийг тэвчин өнгөрүүлсэн учраас Өөрийнхөө зөвийг илэрхийлэхийн тулд байсан бөгөөд ²⁶Тэр Өөрөө зөв байж, Есүст итгэгч хүнийг

зөвтөгч байхын төлөө эдүгээ цагт Өөрийнхөө зөвийг илэрхийлэхийн тулд байсан юм. ²⁷Тэгвэл сайрхал хаана байна? Энэ нь зайлуулагджээ. Ямар хуулиар вэ? Үйлсийнх үү? Үгүй. Харин итгэлийн хуулиар ажээ. ²⁸Учир нь хүн Хуулийн үйлсээс ангид, итгэлээр зөвтгөгддөг гэж бид үздэг. ²⁹Эсвэл Бурхан зөвхөн иудейчүүдийнх юм гэж үү? Тэр мөн харь үндэстнүүдийнх биш гэж үү? Тийм ээ, Тэр бас харь үндэстнүүдийнх мөн. ³⁰Хөвч хөндүүлснийг нь ч итгэлээр, хөвч хөндүүлээгүйг нь ч итгэлээр зөвтгөх Бурхан бол үнэндээ ганц болой. ³¹Тэгвэл бид итгэлээрээ Хуулийг хүчингүй болгох уу? Бүү ийм байх болтугай! Харин ч, бид Хуулийг тогтоодог.”

Хийх зүйлс

1. “Харин эдүгээ Бурханы зөв нь _____ ангид илэрхийлэгдэв. үүнийг Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилсэн юм. (21) _____ Бурханы зөв нь итгэгч _____ хүнд байна. Ялгаварлал байхгүй. (22) _____
2. Харин Христ Есүс доторх золилтоор дамжуулан Түүний нигүүлслээр үнэгүй _____ билээ. (24) Түүний _____ итгэх итгэлээр дамжуулан Бурхан Түүнийг _____ гэж нийтэд харуулав. (25)

3. Тэр өөрөө зөв байж, _____ итгэгч хүнийг _____ байхын төлөө эдүгээ цагт Өөрийнхөө _____ илэрхийлэхийн тулд байсан юм. (26)

4. Тэгвэл сайрхал хаана байна? Энэ нь _____ . (27)

[Бид үнэгүй авсан бэлгээрээ сайрхах ёсгүй. 5Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, (Тит 3:5а)]

5. Учир нь хүн Хуулийн _____ ангид, _____ зөвтөгддөг гэж бид үздэг. (28) Харин _____ хуулиар ажээ. (27)

Зөвтгөх Бурханы арга зам

Бид Хуучин гэрээн дээр хүн төрөлхтнийг бүхий л шүүлтээр буруутгаж байсан тухай хардаг. Эдгээр шийтгэлүүд нь үхэх шийтгэлүүд байсан. Харин Паул одоо хуучин гэрээн дээр гардаг үнэнийг өөр нэгэн үнэнээр сольсон. Энэ нь Есүс Христэд итгэх итгэлийн хуулиар Бурханы өмнө зөвтөгдөх явдал юм.

Есүс загалмай дээр үхсэнээр Бурхан хичнээн гайхамшигтай зүйлийг гэмтэй хүмүүсийн төлөө хийгээ вэ! Бурхан Өөрийгөө зөвт Бурхан гэдгийг илчилсэн. Тэр Өөрийгөө итгэлтэй, амлалтаа биелүүлдэг мөн өршөөнгүй, хайрладаг Бурхан гэдгээ илчилсэн.

“Зөвтгөх” гэдэг нь

“Зөвтгөх” гэдэг үгний нэр томъёог утгачилбал “цагаатгах”, “гэмгүй болгох”, эсвэл “зөвт байдлыг тунхаглах” гэсэн утгатай. Шинэ гэрээн дээр гардаг Грек хэлэнд энэ үгийн үндэс нь ижил утгатай байдаг. Зөв арга замаар шүүгч Бурхан хүнийг гэмтэй гэж тунхаглаж үхлийн шийтгэл олгодогч тэр мөн хүнийг “цагаатгаж” зөвт болгож бүх шийтгэлээс чөлөөлдөг. Энэ ямар гайхалтай мэдээ вэ? Ийм зүйл байж болно гэж үү? Ром номны 2:13-д **“¹³Учир нь Хуулийг сонсогчид нь Бурханы өмнө зөв байх бус, харин Хуулийг биелүүлэгчид нь зөвтөгдөх болно.”** (цагаатгах эсвэл зөвт гэж тунхаглах) гэжээ. Гэхдээ хэн ч Бурханы бүх хуулийг биелүүлж чадахгүй. Харин нэг л хүн энэ хуулийг биелүүлсэн энэ бол Есүс! Тэр бидний төлөө үүнийг хийсэн. Бурхан өөрөө махан биеэр хүмүүсийн дунд амьдарсан. (Иохан 1:1,14) Хүүгийн хувьд тэрбээр Тэнгэр дахь Эцэгтээ дуулгавартай амьдарсан. Мессиаатай (Христ) ярих үедээ эш үзүүлэгч Исаиа ингэж хэлсэн, **“Миний Боол, Зөв шударга Нэгэн Өөрийнхөө мэдлэгээр олныг зөвтгөж, тэдний нүглийг нь үүрэх болно.”** (Исаиа 53:11б).

Тиймээ “Тэр хүчирхийлэл үйлдээгүй.

Түүний аманд нь ямар ч худал хуурмаг байгаагүй. ¹⁰**Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь ЭЗЭНий таалал байв.”** (Исаиа 53:9б,10а). Бурхан бидний гэмийн төлөө Есүсийг илгээж Өөрөө гэмийн шийтгэлийг төлжээ. Тэр шийтгэлийг зөвтгөлөөр сольсон. ²¹**Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм.”** (2Коринт 5:21). Ямар гайхалтай солилцоо вэ?

Бурханы энэ зөвтгөл нь Есүст итгэсэн хүмүүст бэлэг болон очих юм. Та зөвтгөгдөнө. (цагаатгагдан, зөвт болно) Учир нь түүний нигүүлсэлээр. (Энэ Бурханы хийж чадах зүйл бөгөөд та үүнийг өөрөө хийж чадахгүй).

“Итгэл”- Бурханы хэлсэн үнэнд итгэх-ингэснээр Бурхнаас ирэх үнэгүй бэлэгийг авах зам нээгдэнэ. ⁸**Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд 9үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно.”** (Ефес 2:8,9)

Ямар гайхалтай аврал вэ! Үүнээс өөр аргаар аврагдана гэж байдаггүй. ¹²**Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв.”** (Үйлс 4:12). Есүс хэлэхдээ, **“Учир нь хэрэв та нар “Би байдаг” гэдэгт итгэхгүй бол та нар нүглийнхээ дотор үхнэ гэлээ.”** (Иохан 8:24б)

“Төлөөс”

“Төлөөс” гэдэг нь “буцааж төлөх” эсвэл “төлөөсийг бүрэн төлөх” гэсэн утгатай байдаг. Сатан Адамын толгойг эргүүлж хүн төрөлхтөнг үхэл болон гэмийн хүч чадалд захируулж эхэлсэн. Харин Есүс энэ төлөөсийг төлсөн бөгөөд Бурханы шаардлагаар гэмийн болон үхлийн энэ шийтгэлээс хүнийг чөлөөлсөн. ²⁸**Харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв.”** (Матай 20:28б) ⁵**Учир нь ганц Бурхан байна. Мөн Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна. Тэр нь хүн болох Христ Есүс билээ. 6Тэр Өөрийгөө бүгдийн төлөө золиос болгон өгсөн.”** (1Тимот 2:5,6а)

⁷**Түүний нигүүлслийн баялгийн дагуу Түүний дотор цусаар нь золилт,”** (Ефес 1:7а). Та яг одоо таны авралын төлөө төлсөн түүний төлөөсийн төлөө талархаж байна уу? Тэр үүрд талархалыг авах зохистой нэгэн. **“Учир нь Та нядлуулсан бөгөөд бүх овог, хэл,**

ард түмэн болон үндэстнүүдээс хүмүүсийг Бурханд Өөрийнхөө цусаар худалдан авч өгсөн билээ.” (Илчлэлт 5:96)

“Эвлэрүүлэл”

“Эвлэрүүлэл” гэдэг нь Бурханы ариун хуулинд нийцүүлэх гэсэн утгатай. Есүсийн цус үүнийг бидний төлөө хийсэн. “Учир нь цус бол амийн төлөө эвлэрүүллийг хийдэг юм.” (Левит 17:11б). Есүс дэлхийн гэмийн төлөө цусаа асгаруулах үед хуулийг нийцүүлж эхлэсэн. Ингэснээр үхлийн шийтгэл бүрэн төлөгдсөн.

“¹⁰Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн төлөө Хүүгээ эвлэрүүлэл болгон илгээсэн билээ. Үүнд хайр байгаа юм.” (1 Иохан 4:10) “2Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн төлөө бус, бас бүх ертөнцийн нүглийн төлөө билээ.” (1 Иохан 2:2)

ХИЧЭЭЛ 8. АБРАХАМ ИТГЭЛЭЭР ЗӨВТГӨГДСӨН НЬ

Ром 4:1-25

¹Тиймд махан биеэрээ бидний өвөг болсон Абрахам юуг олсон гэж бид хэлэх вэ? ²Хэрэв Абрахам үйлсээрээ зөвтгөгдсөн бол тэр сайрхах юмтай. Гэхдээ Бурханы өмнө биш. ³Сударт юу гэж байна вэ? “Абрахам Бурханд итгэсэн. Энэ нь түүнийг зөвд тооцуулсан байна” гэдэг. ⁴Ажил хийдэг хүний хувьд цалин нь өглөг бус, харин төлбөр гэж тооцогддог. ⁵Харин ажил хийдэггүй боловч, бурханлаг бус хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг хүний хувьд итгэл нь зөвд тооцогддог. ⁶Түүнчлэн Давид бас үйлсгүйгээр Бурханд зөв хэмээн тооцогдсон хүний ивээгдсэнийг ийнхүү хэлжээ.

”Хууль бус явдал нь

уучлагдаж,

Нүглүүд нь далдлагдсан хүмүүс ерөөлтэй.

⁸Эзэн нүглийг нь огт үл тооцох тэр хүн ерөөлтэй” ⁹Тэгвэл энэ ерөөл нь хөвч хөндүүлсэн хүмүүст хамаатай юу? Эсвэл хөвч хөндүүлээгүй хүмүүст бас хамаатай юм уу? Учир нь бид “Итгэл нь Абрахамыг зөвд тооцуулсан” гэж ярьдаг. ¹⁰Тийм бол энэ нь яаж тооцуулсан юм бэ? Хөвч хөндүүлсэн байхдаа юм уу, эсвэл хөвч хөндүүлээгүй байхдаа юм уу? Хөвч хөндүүлсэн байхдаа биш, хөвч хөндүүлээгүй байхдаа юм. ¹¹Абрахам хөвч хөндүүлээгүй үедээ итгэлийн зөвийн

тамгаар хөвч хөндөх ёслолын тэмдгийг хүлээн авчээ. Тэр хөвч хөндүүлэлгүй итгэдэг бүх хүний эцэг нь болж, тэднийг зөвд тооцуулахын тулд ингэжээ. ¹²Мөн хөвч хөндүүлээд зогсохгүй, бас хөвч хөндүүлээгүй байхад нь бидний эцэг Абрахамд байсан итгэлийн мөрөөр мөшгөгч хүмүүст хөвч хөндөлтийн эцэг болов.

¹³Учир нь ертөнцийн өв залгамжлагч байх болно хэмээн Абрахамд болон түүний үр удамд өгөгдсөн амлалт нь Хуулиар бус, харин итгэлийн зөвт байдлаар байсан аж. ¹⁴Учир нь хэрэв Хуулиар байгсад нь өв залгамжлагчид юм бол, итгэл нь хоосон болгогдсон бөгөөд амлалт устгагдсан юм. ¹⁵Учир нь Хууль уур хилэнг авчирдаг. Харин хаана хууль байхгүй байна, тэнд бас зөрчил гэж байхгүй. ¹⁶Тиймээс нигүүлслийн дагуу байхын тулд тэр амлалт нь итгэлээр ирдэг. Ингэснээр тэрхүү амлалт нь бүх үр удамд, зөвхөн Хуулийн үр удамд төдийгүй, мөн Абрахамын итгэлийн үр удамд ч баталгаатай байх юм. Абрахам бол ¹⁷(Энэ нь “Би чамайг олон үндэстний эцэг

болгосон” гэж бичигдсэнчлэн ажээ) үхэгсдэд амь өгөгч, байхгүйг байгаагаар дуудагч, өөрийн итгэсэн Бурханы өмнө бид бүгдийн эцэг юм. ¹⁸”Чиний үр удам ийм болно” гэж урьд нь айлдсан ёсоор тийнхүү олон үндэстний эцэг болохын тулд тэр найдах аргагүй үед найдан итгэсэн. ¹⁹Тэр зуугаад насалсан тул биеийнхээ бараг үхсэнийг болон Сарагийнх нь умай үхмэл болсныг мэдсэн хэдий ч итгэлээр дорой болсонгүй. ²⁰Харин Бурханы амлалтын талаар тэр үл итгэн тээнэгэлзэлгүй, харин ч итгэлээр хүчирхэгжихдээ Бурханд алдрыг нь өргөн, ²¹Бурхан амласнаа биелүүлэх чадвартай гэдэгт бүрэн итгэлтэй байлаа. ²²Тиймээс энэ нь түүнийг зөвт байдалд тооцуулсан ажээ. ²³”Тэр зөвт байдалд тооцогдсон” гэж бичигдсэн нь зөвхөн түүний төлөө бус, ²⁴бидний Эзэн Есүсийг үхэгсдээс амилуулсан Түүнд итгэж, зөвт байдалд тооцогдох мөн бидний төлөө билээ. ²⁵Есүс бидний нүгэл хилэнцээс болж тушаагдсан бөгөөд бидний зөвтгөлийн төлөө амилуулагдсан юм.

Хуучин Гэрээний үед зөвтөгдсөн хоёр жишээ

Хуучин Гэрээн дээр гардаг итгэлээр зөвтөгдөн гэм нь уучлагдсан хүмүүсийн тухай Паул гэрчилсэн. Абрахам зөвт хэмээн тунхаглагдсан учир нь тэр Бурханд итгэжээ. Давид хэлэхдээ **“Алдаа зөрчил нь уучлагдсан бөгөөд Нүгэл нь далдлагдсан нэгэн юутай ерөөлтэй вэ! 2ЭЗЭНд гэмтэн гэж үл тооцогддог бөгөөд”** (Дуулал 32:1,2а). Таны гэм уучлагдсаныг та мэдсэн үү?

Абрахам хэрхэн зөвтөгдсөн тухай.

Абрахам өөрийн хийсэн зүйлийнхээ төлөө зөвтөгдсөн үү? Паул “үгүй” гэж хариулсан. Абрахам сайн зүйл хийсэн учраас зөвтөгдөөгүй харин энэ нь Бурханы бэлэг байсан. Паул Ромын итгэгч нарт Бурханы Абрахамд амласан зүйлийг сануулсан. **“Чи тэнгэр өөд хар, хэрэв оддыг тоолж чадваас тоол гэв. Тэр бас дахин түүнд Чиний үр удам ийм олон болно гэв. 6Тэгээд Абрам ЭЗЭНд итгэсэнд ЭЗЭН түүнийг зөвт байдалд тооцуулав.** (Эхлэл 15:5б, 6)

Бурхан Абрахамд ганц хүүхэд амлаж түүнийгээ олон жилийн дараа биелүүлсэн боловч Абрахам Түүнд итгэсээр байсан бөгөөд түүний итгэл хүчтэй байжээ. Абрахам 14 жилийн өмнө зөвтөгдсөн гэдэгтээ итгэлтэй байсан. Мөн тэр Бурханы амлалт боломжтой гэдэгт итгэсэн. Абрахам итгэсэн учраас Бурханыг дуулгавартай дагаж тэгсэнээр тэр аль хэдийн уучлагджээ.

Бурханд итгэсэн хэн боловч Абрахамын жинхэнэ хүүхдүүд.

Паул өөр нэг захидалдаа **“7Тиймээс итгэлийн хүмүүс нь Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав. 9Тиймээс итгэлийн хүмүүс итгэгч Абрахамын хамт ерөөгдсөн ажээ.”** (Галат 3:7,9) гэж бичсэн

Хийх зүйлс

Ром номны 4-р бүлэгийн эдгээр асуултад хариул.

1. Хэний итгэл зөвт тооцогдох вэ? Харин _____ хийдэггүй боловч, _____ хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг хүний хувьд _____ нь зөвд тооцогддог. (Ишлэл 5)

2. Хэзээ Абрахамын итгэл зөвт тооцогдсон бэ? Абрахам _____ үедээ итгэлийн зөвийн тамгаар хөвч хөндөх ёслолын тэмдгийг хүлээн авчээ. (10)

3. Абрахам хөвч хөндүүлээгүй үедээ _____ зөвийн _____ хөвч хөндөх ёслолын тэмдгийг хүлээн авчээ. (11)

4. Тэр хөвч хөндүүлэлгүй _____ бүх хүмүүсийн _____ нь болж, тэднийг _____ тооцуулахын тулд ингэжээ. (11)

[тамга нь үнэний бэлэг тэмдэг болдог]

5. Абрахам Бурханы юунд итгэсэн бэ? _____ амь өгөгч, байхгүйг _____ дуудагч, (17б)

¹Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв. (Ефес2:1)

Бурхан таны төлөө дээрх бүгдийг хийсэн гэдэгт та итгэж байна уу?]

6. Абрахам итгэл нь хүчтэй гэдгээ хэрхэн харуулж байсан бэ? Бурханд _____ нь өргөснөөр, (20)

7. Абрахам юунд бүрэн итгэсэн бэ? Бурхан амласнаа _____ чадвартай гэдэгт бүрэн итгэлтэй байлаа. (21)

[Есүс Христийн цус таны гэмийг угааж танд амласан мөнхийн амьдралыг өгсөн гэдэг та бүрэн итгэж байна уу? хэрэв тийм бол итгэл дотроо хүчтэй байж Түүнд алдрыг өргөгтүн **“Учир нь би хэнд итгэсэнээ мэддэг. Тэр надад хариуцуулсан зүйлээ тэрхүү өдрийг хүртэл хамгаалах хүчтэй гэдэгт би итгэлтэй байна”** (2Тимот 1:12б)].

8. Бидний Эзэн Есүсийг _____ Түүнд _____ зөвт байдалд тооцогдох мөн бидний төлөө билээ. (24)

9. Яагаад Есүс цовдлогдон үхлээс амилсан бэ? Есүс бидний нүгэл хилэнцээс болж _____ бөгөөд бидний _____ төлөө амилуулагдсант юм. (25)

[Есүс бидний гэмийн шийтгэл болж үхсэн бөгөөд бидний гэмийг биднээс зайлуулсан.Тэр дахин амилсанаар Бурхан Түүнийг хүлээн зөвшөөрч, биднийг зөвт хэмээн хүлээн авсан юм. **“¹⁵Тэр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой”** (2 Коринт 5:15)]

ХИЧЭЭЛ 9. ЗӨВТГӨЖ БУЙ ЕРӨӨЛ

Ром 5:1-11

¹Тиймээс итгэлээр зөвтгөгдсөн бид бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхантай эвлэрсэн билээ. ²Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжуулан итгэлээр орох боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг. ³Түүгээр ч барахгүй, мөн зовлонтойдоо баярладаг. Учир нь зовлон зүдгүүр нь тэвчээрийг, ⁴тэвчээр нь туршлагатай байхыг, туршлагатай байх нь найдварыг төрүүлдэг. ⁵Найдвар нь урам хугалдаггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг. ⁶Биднийг сул дорой байх үед, Христ тогтоосон цагт бурханлаг

бус хүмүүсийн өмнөөс үхсэн билээ. ⁷Зөвт хүний төлөө хэн нэгэн хүн бараг үхэхгүй. Харин сайн хүний төлөө бол хэн нэгэн хүн үхэхээр зүрхэлж магадгүй юм. ⁸Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. ⁹Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан уур хилэнгээс ч аврагдах болно. ¹⁰Учир нь хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний амиар аврагдах болно. ¹¹Зөвхөн үүнд ч биш, мөн Бурханы дотор бидний Эзэн Есүс Христээр дамжуулан баярлан хөөрдөг. Түүгээр бид эдүгээ эвлэрлийг авав.

Хийх зүйлс

Есүст итгэх итгэлээр зөвт хэмээн тунхаглагдаж буй эдгээр ишлэлүүдийг нөхөж бич.

1. “Тиймээс _____ зөвтгөгдсөн бид бидний Эзэн Есүс Христээр дамжуулан _____ эвлэрсэн билээ.” (Ишлэл1)

2. Түүгээр дамжуулан итгэлээр _____ боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг. (2)

[Үүний тулд л Есүс бидний төлөө энэ бүгдийг хийсэн. Бурхан амласан бүхнээ биелүүлж байсан. [“¹⁶Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очицгооё”] (Еврей 4:16)

3. Бид Бурханы _____ найдварт баярладаг.(2)

[Ариун сүнс Бурханыг илчилэх үед бид Бурханы алдрыг харж Түүний үгийг амьдралдаа хүлээж авдаг. **“Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн.”** (Коллосай 1:276). Нэг л өдөр бид Түүнтэй нүүр нүүрээрээ уулзах болно. (1 Иохан 3:2)

4. Түүээр ч барахгүй, мөн _____ баярладаг. Учир нь зовлон зүдгүүр нь _____, тэвчээр нь туршлагатай байхыг, _____ байх нь _____ төрүүлдэг. (3,4)

[“2Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. 3Та нарын итгэлийн сорилт тэсвэр хатуужлыг төрүүлдэг гэдгийг та нар мэдэх билээ.” (Иаков1: 2,3)]

5. Найдвар нь _____. Учир нь бидэнд өгөгдсөн _____ дамжуулан Бурханы _____ бидний зүрхэнд цутгагдсан байдаг. (5)

[Ариун сүнс бидэн уруу Бурханы мэдлэг болон хайрыг цутгаж байдаг бөгөөд үүгээр бид бусдыг хайрладаг. Бурхан бидэнд хайртай гэдгийн нэг баталгаа бол Тэр биднийг гэмтэй байхад хүртэл Өөрийн амиа бидний төлөө зориулсан явдал юм. (ишлэл 8)]

6. Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан _____ ч аврагдах болно. (9)

[“9Яагаад гэвэл Бурхан биднийг уур хилэнгийн төлөө бус, харин бидний Эзэн Есүс Христээр дамжуулан авралыг олж авахын төлөө томилсон юм. 10Биднийг сэрүүн ч бай, унтсан ч бай, Өөртэйгөө хамт амьдруулахын тулд Тэр бидний төлөө үхсэн билээ.” (1Тесалоник 5:9,10)]

7. Учир нь хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний _____ болно.(10)

[Бидний дотор амьдарч байгаа Есүс биднийг гэмээс аварсан бөгөөд Тэр биднийг Мөнхийн улсаас удирдаж байдаг. **25Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрэн төгс аврах чадвартай. Учир нь Тэр тэдний төлөө зуучлан залбирахын тулд үргэлж амьд байдаг** (Еврей 7:25)]

ХИЧЭЭЛ 10. ХОЁР АДАМЫН ДҮР ЗУРАГ.

Ром 5:12-21

¹²Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн. Тиймээс бүгд нүгэл үйлдсэн тул үхэл нь бүх хүнд иржээ. ¹³Учир нь Хуулиас өмнө ертөнцөд нүгэл байсан. Гэвч хэрэв хууль байхгүй бол нүгэл нь нүгэл хэмээн тооцогдохгүй. ¹⁴Гэсэн хэдий ч үхэл нь Адамаас Мосе хүртэл ноёрхсон төдийгүй, ирэх байсан Түүний дүрс болох Адамын гэм буруутай адил байдлаар нүглийг үйлдээгүй хүмүүс дээр ч ноёрхож байсан ажээ.

¹⁵Харин үнэгүй бэлэг бол алдаа зөрчилтэй адилхан биш. Учир нь хэрэв ганц хүний алдаа зөрчлөөс болж олон хүн үхсэн бол, тэгэх тусмаа Бурханы нигүүлсэл болон Есүс Христ гэгч ганц Хүний нигүүлслээр ирэх бэлэг нь олон хүнд бялхагдсан юм. ¹⁶Бэлэг нь нүгэл үйлдсэн ганц хүнээр дамжуулан ирсэн зүйлтэй адилхан биш. Учир нь нэг талаас, нэг алдаа зөрчлийг дагалдан шүүлт нь ирж, ялд унагасан бол, нөгөө талаас

олон алдаа зөрчлийг дагалдан үнэгүй бэлэг нь ирж, зөвтгөлд хүргэсэн билээ. ¹⁷Учир нь хэрэв ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжуулан үхэл нь ноёрхсон бол, тэгэх тусмаа нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн бялхалыг хүлээн авагсад нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжуулан амь дотор ноёрхоно. ¹⁸Тиймээс нэг алдаа зөрчлөөс болж бүх хүн ялд унасны адил, ийнхүү нэг зөвт үйлээс болж бүх хүмүүс амийн зөвтгөлд хүрэв. ¹⁹Учир нь ганц хүний дуулгаваргүй байдлаас болж олон хүн нүгэлтэн болгогдсоны адил түүнчлэн ганц Хүний дуулгавартай байдлаар олон хүн зөвт болгогдоно. ²⁰Алдаа зөрчил ихэссэн байхын тулд Хууль орж ирсэн. Гэвч хаана нүгэл ихэссэн байна, тэнд нигүүлсэл улам илүү бялхсан юм. ²¹Ингэснээр нүгэл нь үхлээр ноёрхсончлон, нигүүлсэл нь бидний Эзэн Есүс Христээр дамжуулан мөнх аминд хүргэх зөвт байдлаар ноёрхох юм.”

Хийх зүйлс

Эхний Адам (Бурханаар бүтээгдсэн) болон сүүлчийн Адам (Есүс Христ) хоёрын ялгааг олж нөхөж бич.

Эхний Адам

1. Тиймээс _____ нь ганц хүнээр ертөнцөд орсны адил _____ нь нүглээр дамжуулан орж ирэв. Тэрчлэн _____ нүгэл үйлдсэн тул бүх хүмүүст үхэл тархав.(12)

2. Учир нь хэрэв ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжуулан үхэл нь _____ (17a)

3. Тиймээс нэг алдаа зөрчлөөс болж _____ хүмүүс _____ унасан. (18a)

[Яллах гэдэг нь “Гэмтэй” гэсэн утга илэрхийлдэг. Харин үл итгэдэг хүн аль хэдийн ялагдсан. Учир нь тэр хүн Бурханы цорын ганц Хүүгийн нэрэнд итгээгүй юм. (Иохан 3:18б)]

4. Учир нь ганц хүний _____ байдлаас болж олон хүн _____ болсон.(19a)

[Адам гэмд унах үед Түүний үр удам бүгд гэмд унасан.]

5. Ингэснээр нүгэл нь _____ ноёрхсон. (21a)

[²²Адам дотор бүгд үхсэн (1Коринт 15:22a)]

Сүүлчийн Адам Есүс Христ

6. Бурханы нигүүлсэл болон Есүс Христ гэгч ганц Хүний нигүүлслээр ирэх _____ нь _____ хүнд бялхагдсан юм.(15б)

[Нигүүсэл гэдэг нь Бурхан бидний төлөө хийсэн зүйлийг хэлэх бөгөөд бид өөрсдөө хичээгээд энэ зүйлийг олж авч чадахгүй. Энэ бэлэг зөвхөн Есүст итгэсэн хүмүүст өгөгдөх боломжтой.]

7. Учир нь нэг талаас, нэг алдаа зөрчлийг дагалдан _____ нь ирж, ялд унагасан бол, нөгөө талаас олон алдаа зөрчлийг дагалдан _____ бэлэг нь ирж, зөвтгөлд хүргэсэн билээ.(16б)

[Бурханы эсрэг алдаа зөрчлийг зөвхөн үнэгүй бэлэг зөвтгөж чадна. Есүс бидний үхлийн шийтгэлийг төлсөн. Ингэснээр Бурхан Түүнд итгэсэн хүмүүсийг гэмгүй хэмээн тунхагласан. Зөвтгөл гэдэг нь буруугүй гэсэн утга илэрхийлэнэ. Энэ ямар гайхамшигтай бэлэг вэ!]

8. Тэгэх тусмаа _____ баялгийг болон зөвт байдлын бэлгийн бялхалыг хүлээн авагад нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжуулан амь дотор _____ . (17a)

[“нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр дамжуулан ирсэн

билээ.” (Иохан 1:17б) Есүс нигүүслээр дүүрэн бөгөөд Түүнийг амьдралдаа хүлээн авсан хүмүүс нь хангалтай их нигүүслээр амьдралыг ялан дийлдэг. **“Тиймээс “Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлсэл өгдөг” гэдэг.”** (Иаков 4:6б). **“¹⁴Харин Бурханд талархлууд нь өргөгдөх болтугай. Тэр нь биднийг Христ дотор ямагт ялуулдаг”.**

(2 Коринт 2:14а)]

9. Ийнхүү нэг _____ үйлээс болж _____ хүмүүс _____ зөвтгөлд хүрэв.(18а)

[Бурханы хуулийн шийтгэлийн төлөө Есүс үхэж өөрийгөө золиослон зөвт үйлсийг хийсэн. Ингэснээр тэр зөвт хэмээн тооцогдон (сайн шалтгаанаар) бидэнд амьдрал өгсөн юм. **“Христ дотор бүгд амьдруулагдах болно. Сүүлчийн Адам нь амь өгөгч сүнс болов.”** (1Коринт 15:22б, 45б)]

10. Түүнчлэн ганц Хүний _____ байдлаар олон хүн _____ болгодоно.(19а)

“Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов.”

(Филлипой 2:8б). Үүний тулд Есүс дуулгавартай байсан бөгөөд Түүнтэй нэгдсэн хэн боловч зөвт хэмээн тооцогдох болно. Тэдний дотор байгаа Түүний хүчирхэг амьдрал (Есүс шиг амьдрал) тэднийг зөвт болгосон.

Та дахин төрөх шаардлагатай

Та Адамын гэмийг авч төрдөг бөгөөд энэ нь үхэлд хүрдэг. Хүний зүрх хуурамч байдаг ба (Иеремиа 17:9) үүнийг засах боломжгүй юм. Та дахин шинэ зүрх сэтгэлтэй болж төрөх хэрэгтэй. Бурхан таньд үүнийг амласан. **²⁶Түүнээс гадна, Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна.** (Езекиел 36:26а) Есүс Адамын гэмийг өвлөж аваагүй учир нь Тэр Адамын бус Бурханы хүүхэд байсан. Зөвхөн Бурханы гэмгүй хүүхэд итгэлээр хүмүүст шинэ чиг шугам өгч чадах бөгөөд ингэснээр Тэнгэр дахь Эцэгээс зөвт байдлыг өвлөн авах юм. **“¹²Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв.”** (Иохан1:12).

Та Бурханы хүүхэд болж төрөн Есүс таны төлөө үхсэн гэдэгт итгэн Түүнийг хүлээж авсан уу? Хэрэв та хүлээж аваагүй бол яг одоо хүлээж аваарай.

Тэгээд Бурханы танд өгсөн бэлэг болох Есүс доторх шинэ амьдралд талархаарай!

¹⁷Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна.” (2 Коринт 5:17).

Дараа дараагийн хичээлүүдэд бид хэрхэн шинэ амьдралыг хүлээж авах тухай үзнэ.

ХИЧЭЭЛ 11. ХЭРХЭН ГЭМЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ТУХАЙ

Ром 6:1-14

¹Тэгвэл бид юу гэж хэлэх вэ? Нигүүлсэл нь ихсэхийн тулд бид нүгэл дотор байсаар байх уу? ²Бүү ийм байх болтугай! Нүгэлд үхсэн бид, цаашид түүн дотроо хэрхэн амьдрах вэ? ³Эсвэл Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? ⁴Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм. ⁵Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний амилалттай нь ч холбогдох болно. ⁶Ингэхдээ хойшид биднийг нүгэлд боолчлуулалгүй, нүглийн биеийг маань хүчингүй болгохын тулд бидний хуучин хүн нь Түүнтэй хамт

цовдлогдсоныг бид мэддэг. ⁷Учир нь үхсэн нэгэн нь нүглээс чөлөөлөгдсөн. ⁸Хэрэв бид Христтэй хамт үхсэн бол, мөн Түүнтэй хамт амьдрах болно гэдэгтээ бид итгэдэг. ⁹Христ үхэгсдээс амилуулагдсан тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ. Үхэл цаашид Түүнийг захирахгүй. ¹⁰Учир нь Түүний үхсэн үхлийн хувьд, Тэр нэг удаа нүгэлд үхсэн бөгөөд харин Түүний амьдардаг амьдралын хувьд, Тэр Бурханд амьдардаг. ¹¹Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаа гэж тооц.

¹²Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх ёстой хэмээдэг үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог. ¹³Биеийнхээ эрхтнүүдийг зөвт бус байдлын зэвсэг болгон нүгэлд бүү өргө. Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсад мэт, мөн биеийнхээ эрхтнүүдийг

зөвт байдлын зэвсэг болгон гэвэл та нар хуулийн дор Бурханд өргө. ¹⁴Учир нь нүгэл байгаа бус, харин нигүүлслийн та нарыг захирахгүй. Яагаад дор байдаг.

Есүс Христтэй хамт байгаагаа таних нь

10-р дугаар хичээлээр Адам дотор төрсөн бид Есүсийн тухай илүү ихийг мэдэж авсан. Буруутгал ганц хүн болох Адамаар дамжин хүн төрөлхтөнд ирсний адил Аврал Есүс Христээр дамжин хүн төрөлхтөнд иржээ. Адамаас махан биеийн амьдралыг авсан хүмүүс гэмийн боол болж төрсөн. Харин Есүс Христээс сүнсний амьдралыг авсан хүмүүс гэмийн боолчлолоос чөлөөлөгдсөн. Тэд Бурханы төлөө амьдрахаар чөлөөлөгдсөн юм. Баптисм (утгачилбал “Усаар угаах” гэдэг нь) үнэндээ Есүс Христэд дотроо итгэсэн гэдгээ харуулж буй хэрэг юм. Итгэлээр итгэгч хүмүүс Түүний үхлээр итгэл дотроо нэгдсэн гэдгээ мэддэг. Усанд өөрийгөө угаах нь итгэгч хүмүүс хуучин гэмээ булж алга болгож байгаа гэсэн утга илэрхийлдэг. Уснаас гарч ирснээр итгэгч хүмүүс Христийн дахин амилалтаар нэг болж шинэ амьдрал хүлээн авч Бурханд үйлчлэн үр жимстэй шинэ амьдралтай болдог. **“²⁰Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биедээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм”** (Галат 2:20)

2-р дугаар хичээлээр бид бурханаас ирэх зөвт байдал нь итгэлээр илчлэгддэг гэж үзсэн. Есүс Христ үхэх үед Түүнд итгэх итгэлээр эхлээд бид буруутгал болон шийтгэлээс чөлөөлөгдсөн. Бурхан зөвхөн Есүс Христийн зөвтгөсөн зөвтгөлөөр биднийг буруугүй хэмээн тунхаглаж чадна. Тиймээс Аврал гэдэг нь гэмээс чөлөөлөгдөх хүч чадал юм. Ром номны 6:1-14 ишлэл бидэнд энэ гэмээр дүүрсэн дэлхий дээр юу хийхийг хэлсэн байдаг. Энэ ишлэлүүд бидэнд Есүсийн дахин амилалтаар бид хэрхэн зөвт амьдралаар амьдрах хүч чадлын тухай хэлсэн байдаг. Биднийг өнгөрсөнд удирдаг байсан гэмд бид боолчлогдох ёсгүй.

Хийх зүйлс

Ром номны 6-р бүлгээс нөхөж бич. Паул биднийг мэдээсэй гэж юунд найдаж байсан бэ.

Паул бидэнд үнэнг мэдүүлсэн:

1. Ингэхдээ хойшид биднийг нүгэлд _____, нүглийн биеийг маань хүчингүй болгохын тулд бидний хуучин хүн нь Түүнтэй хамт _____ бид мэддэг.(6) Учир нь үхсэн нэгэн нь нүглээс _____(7)

2. Христ үхэгсдээс _____ тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ.(9) Учир нь Түүний үхсэн үхлийн хувьд, Тэр _____ удаа нүгэлд үхсэн бөгөөд харин Түүний амьдардаг амьдралын хувьд, Тэр _____ амьдардаг.(10)

[Христ гэмийн төлөө үхэх үед Түүнтэй нэгдсэн хүмүүс ч бас гэмийн төлөө үхсэн. Христ Бурханы төлөө амьдарсаны адил тэд мөн Бурханы төлөө амьдардаг.]

Паул бидэнд найд хэмээн хэлсэн. (найд, үнэнд итгэ)

3. Түүнчлэн та нар өөрсдийгөө _____ боловч _____ Христ Есүсээр _____ байгаа гэж тооц.(11)

[Бид Бурханы өмнө зөвхөн Есүсийн хүчээр амьд байж чадна. ЗУчир нь та нар үхсэн бөгөөд та нарын амь Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан. (Коллосай3:3) Учир нь та үхсэн, та өөрийнхөө махан биеийг заавал дагах шаардлаггүй. "Христийн хайр биднийг албаддаг. ¹⁵Тэр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой." (2 коринт 5:14б,15)]

4. Харин Бурханд өөрсдийгөө _____ болгогсод мэт(13б)

5.Мөн биеийнхээ эрхтнүүдийг _____ байдлын _____ болгон Бурханд өргө. [13б]

[Бид нар өөрсдийн махан биеийг гэм хийхийг зөвшөөрч болохгүй. Одоо бидний бие Бурханы нэг хэсэг болсон болохоор бид зөвт зүйлийг хийх хэрэгтэй. Бурхантай нөхөрлөх нь хичнээн гайхамшигтай вэ! Тэр бидний дотор байж, биднийг Христтэй адилхан болгож, биднээр дамжуулан өөрийнхөө ажлыг хийхийг хүсэж байна. Хэрэв та үүнийг хийх юм бол бол Тэр бидэнд гэм дахин биднийг боолчлохгүй гэдгийг амлаж байна. (Ишлэл 14)]

Бурхан биднээр дамжуулан Мэдэж, Итгэж, Ургац хураахад бидний хийж чадахгүй зүйлийг хийдэг.

ХИЧЭЭЛ 12. ИТГЭГЧ ХҮМҮҮС НЬ ЗӨВТ БАЙДЛЫН БОЛУУД ЮМ.

Ром 6:15-23

“¹⁵Тэгвэл яах вэ? Бид хуулийн дор бус, харин нигүүлслийн дор байдаг учраас нүгэл үйлдэх үү? Бүү ийм байх болтугай! ¹⁶Та нар өөрсдийгөө дуулгавартай байхаар боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүглийн ч бай, эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавартай байдлын ч бай, дагах нэгнийхээ боол нь болдгоо мэдэхгүй гэж үү? ¹⁷Харин Бурханд талархал нь байг. Учир нь та нар нүглийн боолууд байсан боловч та нар өөрсдөд чинь өгөгдсөн уг сургаалын хэв маягт зүрхнээсээ дуулгавартай болж, ¹⁸нүглээс чөлөөлөгдөн зөвт байдлын боолууд болсон. ¹⁹Та нарын махан бие сул дорой тул би хүний ёсоор хэлье. Та

нар өөрсдийн эрхтнүүдийг ёс бус явдалд хүргэх цэвэр бус, ёс бус байдалд боол болгон өргөснийхөө адил түүнчлэн одоо өөрсдийн эрхтнүүдээ ариусгалд хүргэх зөвт байдалд боол болгон өргө. ²⁰Учир нь та нар нүглийн боол байхдаа зөвт байдлаас чөлөөтэй байжээ. ²¹Тэгэхэд та нар одоо ичиж байгаа зүйлсээс ямар үр жимс авсан бэ? Учир нь тэдгээр зүйлсийн төгсгөл бол үхэл болой. ²²Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн бөгөөд Бурханд боолчлогдсон та нарт ариусгалд хүрэх үр жимс авдаг. Төгсгөл нь мөнх амь болой. ²³Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн.”

Аль Эзэнд нь үйлчлэх вэ?

Бурхан биднийг Христ дотор зөвт хэмээн тунхаглахаас өмнө бид гэмд үйлчилж байсан. Гэм нь маш хүнд хэцүү зүйл бөгөөд биднийг буруу зүйл болон үхэл уруу дагуулдаг. Зөвт байдлын төлөө үйлчлэх нь хичнээн гайхмшигтай вэ! Одоо бид гэмээс чөлөөлөгдсөн учир Бурханы хүсэж байгаа зөвт байдлыг дагах боломжтой юм.

Хэн таны Эзэн гэдгийг та мэдэж байна уу? “²⁴Хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй. Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлах болно. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцнэ.”(Матай 6:24а)
“¹⁰Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг үйлддэггүй аливаа хүн Бурханых биш. Ах дүүгээ

хайрладаггүй нэгэн нь ч Бурханых биш.” (1 Иохан 3:10) Есүс хоёр өөр Эзэний ялгааг тодорхой дүрслэн хэлсэн байдаг. “10Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм. “11Би бол сайн хоньчин мөн. Сайн хоньчин хоньдынхоо төлөө амиа өгдөг.” (Иохан 10:10,11) Хулгайч дээрэмчин болох Сатан биднийг гэм хийлгэж мөн устгахаар ирсэн. Харин сайн хоньчин болох Есүс бидэнд бялхсан амь өгөхөөр ирсэн. Тэр бидний төлөө хүртэл үхсэн. Та дагаж байгаа Эзэнийхээ боол нь болдог. Нэг эзэн нь гэмийн хөлс болгож үхэлийг өгдөг. Харин нөгөө эзэн нь таны олж авч чадахгүй Есүс дотор байгаа мөнхийн амийг өгдөг. “3Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.” (Иохан17:3)

Христ доторх Үр жимс

Есүс хэлэхдээ: “5Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй.” (Иохан 15:5). Христтэй нэг болсон хүмүүс Түүн шиг үр жимс ургуулах болно. “22Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, 23дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм.” (Галат 5:22,23а). Таны дотор Христийн хийсэн зүйлээр дамжуулан та мөнхийн зүйлийг авах болно.

Гэм болон зөвт байдал нь хоёулаа нэмэгдэх болно.

Гэмийн боол байж өөрийн биеийг хуулийн дагуу захирахгүй байх нь улам л хуульд захирагдахгүй байх нөхцөл болдог. Харин Бурхан биднийг гэмээс чөлөөлөх үед (Аврал) та зөвт байдлын боол болох бөгөөд шинэ хүсэл мөрөөдлөөр зөв зүйлийг хийж эхлэдэг. Энэ нь таныг улам ариун болгодог. (Ариусгал). “13Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.” (Филлипой 2:13)

ХИЧЭЭЛ 13. БООЛЧЛОЛООС ЧӨЛӨӨЛӨГДӨХ БУРХАНЫ ХУУЛЬ

Ром 7:1-13

¹Ах дүү нар аа (хуулийг мэддэг хүмүүст би хэлж байна), хууль нь хүнийг амьд байхад л хүнийг захирдаг гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? ²Учир нь гэрлэсэн эмэгтэй нөхрийгөө амьд байх үед нь нөхөртэйгөө хуулиар холбогддог. Харин хэрэв нөхөр нь нас барвал тэр эмэгтэй нөхрийн талаарх хуулиас чөлөөлөгдөх аж. ³Тиймээс нөхрийгөө амьд байхад нь, тэрэмэгтэй өөр эртэй холбогдвол түүнийг завхай эм гэнэ. Харин хэрэв нөхөр нь нас барвал тэр эмэгтэй хуулиас чөлөөлөгдөнө. Ингэснээр тэрээр өөр эртэй холбогдсон ч тэр завхай эм биш юм. ⁴Тийм учраас ах дүү нар минь, та нар Христийн биеэр дамжуулан Хуульд үхсэн. Ингэснээр Бурханы төлөө бид үр жимс гаргахын тулд үхэгсдээс амилсан өөр Нэгэнтэй та нар холбогдох юм. ⁵Учир нь биднийг махан биеийн дотор байхад Хуулиар сэргээгдсэн нүгэлт хүсэл тачаалууд үхэлд хүргэх үр жимс ургуулахын тулд бидний эрхтнүүдэд ажиллаж байсан. ⁶Харин бид юугаар хүлэгдсэн, түүндээ үхэн эдүгээ бид Хуулиас чөлөөлөгдсөн. Ингэснээр бид үсгийн хуучрал дотор

биш, харин Сүнсний шинэлэг байдал дотор үйлчилдэг.

⁷Тэгвэл бид юу ярих вэ? Хууль нь нүгэл үү? Бүү ийм байх болтугай! Гэхдээ Хуулиар биш бол би нүглийг мэдэхгүй байх байсан. Учир нь хэрэв Хууль “Бүү шунахайр” гэж хэлээгүй байсан бол би шунахайрлыг мэдэхгүй байх байсан. ⁸Харин нүгэл тушаалаар шалтаглаж миний дотор зүсэн бүрийн шунахайрлыг төрүүлсэн. Учир нь Хуулиас ангид бол нүгэл нь үхмэл юм. ⁹Нэгэн цагт би Хуульгүйгээр амьдарч байв. Харин тушаал ирснээр нүгэл амьдарч, би үхсэн. ¹⁰Аминд хүргэх байсан энэхүү тушаал нь үхэлд хүргэдгийг би мэдэв. ¹¹Учир нь нүгэл тушаалаар шалтаглаж намайг мэхэлсэн бөгөөд намайг тушаалаар алсан. ¹²Тиймээс Хууль бол ариун бөгөөд тушаал ч ариун, зөвт бөгөөд сайн юм. ¹³Тиймд юу нь сайн, тэр нь надад үхлийн шалтгаан болсон уу? Бүү ийм байх болтугай! Харин юу нь сайн, түүгээр дамжуулан миний үхлийн шалтгаан болсноор нүгэл нь нүгэл гэж харагдахын тулд, тушаалаар дамжуулан нүгэл нь туйлын нүгэлт болохын тулд нүгэл нь үхэл болсон.

Гэрлэлтийн тухай тайлбарласан нь

Паул Бурханы хуультай харилцах харилцааг гэрлэлтэй зүйрлэсэн. Паул хэлэхдээ Бурханы хууль нь нөхөртөй адил юм гэж хэлсэн. Бид нар эхнэр нөхөр нь үхэн үхэтлээ хамт байдгийг мэддэг.

Бурханы хууль мөхөж алга болоогүй. **“89Өө, ЭЗЭН, Таны үг тэнгэрт Мөнхөд бат тогтдог.”** (Дуулал 119:89). Есүс хэлэхдээ **“17Хуулийг эсвэл Эш үзүүлэгчдийг хэрэгсэхгүй болгохоор Намайг ирсэн гэж бүү бод. Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн юм.... тэнгэр газрыг алга болтол, бүгд биелэгдтэл Хуулиас ганц ч үсэг, ганц ч зураас алга болохгүй.”** (Матай 5:17,18) **“Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно.”** (Исаиа 40:86)

Паул эдгээр тайлбаруудаараа бид үхэж болох бөгөөд хэрэв бид үхвэл хууль биднийг дахин захирахгүй гэдгийг харуулахыг оролдсон. Үүний дараа бид чөлөөлөгдөж дахин шинэ харилцаа холбоо тогтоох болно. Энэ сонирхолтой биш гэж үү? Бид гэмтэй учир үхэх ёстой юм. Есүс Христ бидний өмнөөс Өөрийн зөвт амьдралаар бүх хуулийг биелүүлж бидний өмнөөс үхэж бидэнд шинэ амьдрал өгсөн нь хичнээн гайхамшигтай вэ! Хэрэв бид Христ дотор амьд байгаа юм бол(Түүнийг Аврагчаа хэмээн итгэсэн) бид Түүнийг үхэх үед мөн Түүнтэй хамт үхсэн. Ингэснээр бид хуулийн боолчлолоос чөлөөлөгдсөн. Христтэй хамт үхлээс амилсаны дараа бид шинэ амьдралыг олж авах бөгөөд Түүнтэй үүрд “гэрлэн” нэгддэг. Энэ нэгдэл нь зөвт байдлын үр жимсийг ургуулдаг. Есүс Христгүйгээр шинэ амьдрал, аврал, ариун амьдрал гэж байхгүй.

Хууль таныг зөвт болгож чадахгүй.

Хууль танд амьдрал болон Бурханыг дагах хүч чадал өгч чадахгүй.

“Учир нь хэрэв амьд болгох чадалтай хуулийг өгсөн байсан бол зөвт байдал нь үнэхээр хуулиас ирэх байсан.” (Галат 3:21б) **“19(учир нь Хууль юуг ч төгс болгосонгүй) нөгөө талаар илүү сайн найдвар өгөгдөж, энэхүү найдвараар дамжуулан бид Бурханд ойртдог”** (Еврей 7:19)

Та шинэ амьдралыг хуулийг дагаснаар бус харин Хүнээс олж болно. Есүс бол амьдрал. Тэр хэлэхдээ, **“Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй”** (Иохан 14:6б). Есүс Түүнд итгэдэггүй хүмүүсийн тухай ингэж хэлсэн. **“39Та нар Судруудыг**

судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ. ⁴⁰Та нар амьтай болохын тулд Над уруу ирэхийг хүсдэггүй” (Иохан 5:39,40) Есүс хэлэхдээ: “Надад итгэдэг хүн үхэвч амьдарна. ²⁶Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй. Чи үүнд итгэж байна уу? гэж асуув. (Иохан 11:25б,26)

Таныг үхэлд хүргэх хуулийн өгүүлбэр

Хууль хэлэхдээ: “Хүн бүр өөрийнхөө нүглийн төлөө цаазлагдах ёстой” (Дэд хууль 24:16б) “Нүглийг үйлдэгч сэтгэл нь үхэх болно” (Езекиел 18:4б). “Учир нь нүглийн хөлс бол үхэл” (Ром 6:23а)

Хуулийн зорилго

1. Хууль гэмтэй хүмүүст зориулагдсан.(гэмийг тэвчихийн тулд). “⁹Хууль нь зөв хүнд зориулагдаагүй, харин хуульгүй болон тэрслүү хүмүүст зориулагдсан” (1 Тимот 1:9а) “¹³Ингэж ЭЗЭН та нарт гэрээгээ зарлаж, та нарт даган мөрдүүлэхээр тушаасан.

(Дэд хууль 4:13а)

2. Хууль бидэнд гэм юу болохыг хэлдэг. “Хуулиар нүглийн мэдлэг ирдэг юм” (Ром 3:20б) Жишээлбэл Паул шунах нь гэм гэдгийг мэдэж байсан. Учир нь Бурханы арван тушаалд энэ тухай хэлсэн байдаг. (Египетээс гарсан нь 20). Хэрэв бид Бурханы тушаалыг мэдэхгүй бол өөрсдийгөө ямар их гэмтэй вэ гэдгээ мэдэхгүй байх байсан. (Ром 7:13)

3. Хууль биднийг Бурханы өмнө гэмтэй болгодог. “¹⁹Хуулийн хэлж байгаа болгон нь Хуулийн дор байгч хүмүүст хандан ярьдаг гэдгийг бид мэддэг. Ингэснээр ам болгон таглагдаж, ертөнц даяараа Бурханы өмнө буруутгагдах болно” (Ром 3:19)Тушаалууд нь биднийг алдаг. Учир нь шийтгэл нь үхэлд хүргэдэг.

4. Хууль Христийн замыг бэлтгэдэг. “¹⁹Тэгвэл юуны тулд Хууль байгаа юм бэ? Энэ нь амлалтыг авсан нэгэнд үр иртэл зуучийн гараар тэнгэр элч нараар дамжуулж тогтоогдон”

(Галат 3:19а) Үр нь Христ байсан. (Галат 3:16). Хууль аврагдах гэж буй хүмүүсийг бэлтгэдэг. Бурханы үг Есүс дээр ирсэн хүмүүст авралд хэрэгтэй зүйлсийг харуулдаг.

5. Хууль Христийг бидэн дээр авчирдаг. “²³Гэвч итгэл ирэхээс өмнө, бид хожим илчлэгдэх итгэлд хаагдаж хуулийн дор хорионд

байсан билээ. ²⁴Тиймд бид итгэлээр зөвтгөгдөхийн тулд бидний хувьд Хууль нь биднийг Христ уруу хандуулах зааварлагч болов. ²⁵Харин эдүгээ итгэл ирсэн тул бид цаашид зааварлагчийн дор байхаа болив. (Галат 3:23-25)

Бурханы хууль нь Ариун бөгөөд Сайн

“Хэрэв хуулийг мэдэж байвал хууль биднийг гэмтэй (дуулгаваргүй) болгодог учир хууль нь сайн биш гэж та хэлж магадгүй юм. Паул харин “үгүй” ! гэж хэлсэн. (Ром 7:13) ¹⁴⁰Таны үг бол маш цэвэр тунгалаг билээ. Тиймээс Таны зарц түүнийг хайрладаг юм”

(Дуулал 119:140) “7ЭЗЭНий хууль нь төгс төгөлдөр, сэтгэлийг сэргээдэг” (Дуулал 19:7а). Хууль бол сайн: харин бид сайн биш бол хууль биднийг сайн болгодоггүй. Бурхан бидэнд Есүс Христээр дамжуулан шинэ амьдрал өгсөн. ²⁴зөвт байдал болон үнэний ариун байдал дотор Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өөртөө өмс” (Ефес 4:24)

Христтэй хамт нэгдэх нь

Адам Ева хоёрыг Бурхан бүтээж байх үед тэд нэг бие байсан. Адам хэлэхдээ: ²³-Энэ бол яснаас минь авсан яс, Махнаас минь тасалсан мах” (Эхлэл 2:23а). Христийн биеийн нэг хэсэг болохын хувьд гэрлэлт нь биднийг Христтэй итгэлээрээ хэр ойр байгаа вэ гэдгийг дүрслэн үзүүлдэг. ³⁰Яагаад гэвэл бид Түүний биеийн эрхтнүүд юм. ³²Энэ нууц бол агуу билээ. Гэвч би Христ болон чуулганы тухай хэлж байна. (Ефес 5:30,32) Есүс Түүний биеийн нэг хэсэг болох сүмийг тэтгэж байдаг. (Ефес 5:29) Учир нь бид Христтэй нэгдсэн юм. (Бид Түүнтэй гэрлэсэн сүйт бүсгүй мөн бөгөөд мөн түүний биеийн нэг хэсэг юм.) бид ариун байх ёстой бөгөөд Тэр биднийг цэвэршүүлсээр байдаг. “Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. ²⁶Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад ²⁷түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ” (Ефес 5:25б-27). ¹⁷Харин Эзэнтэй нийлсэн хүн нэг сүнс байна” (1 Коринт 6:17)

Христ таныг хуулийн шаардлагаас чөлөөлсөн.

¹³Та нар гэм нүглүүд болон махан биеийн хөвч хөндөх ёслолоосоо болж үхсэн байхад Тэр бидний бүх гэм нүглийг уучлаад, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон бөгөөд ¹⁴бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг хүчингүй болгов. Тэр үүнийг загалмайд хадаж, замаасаа зайлуулжээ” (Колоссай 2:13,14) Бурханы хуулийг зөрчсөн бидний бүх зүйлийг Есүс загалмай дээр цовдолсон. “Бүрэн төлсөн”. Энэ ямар их эрх чөлөө вэ! Энэ нь биднийг гэмээс чөлөөлсөн гэсэн үг биш. Харин Христ доторх бидний шинэ амьдрал л Бурханд үнэнч байхыг Тэр хүсдэг. ¹⁹Учир нь би Бурханд амьд байхын тулд Хуульд Хуулиар үхсэн” (Галат 2:19)

Харин одоо бид Христийн ариун амьдралыг авсан төдийгүй ариун амьдралаар амьдрахад Христийн амьдрал бидэнд эрч хүч өгч байдаг. ¹⁹Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу? ²⁰Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун” (1 Коринт 6:19,20).

ХИЧЭЭЛ 14. ХОЁР МӨН ЧАНАРЫН ЗӨРЧИЛ

Ром 7:14-25

¹⁴Учир нь Хууль бол сүнслэг гэдгийг бид мэддэг. Харин би махан биетэй бөгөөд нүглийн боолчлолд худалдагдсан. ¹⁵Би юу үйлдэж байгаагаа өөрөө ч ойлгодоггүй. Учир нь би хийх хүсэлтэй зүйлээ хийдэггүй, харин үзэн яддаг зүйлээ хийж байна. ¹⁶Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийдэг юм бол, Хуулийг сайн гэдгийг өөрөө зөвшөөрч буй юм. ¹⁷Харин эдүгээ цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг юм. ¹⁸Учир

нь миний дотор буюу миний махан биед ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг. Учир нь хүсэл нь миний дотор байвч, харин сайныг хийх нь үгүй. ¹⁹Би өөрийн хүсдэг сайныг хийдэггүй, харин хүсдэггүй бузар муугаа хэрэгжүүлдэг. ²⁰Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг. ²¹Ингээд сайныг үйлдэхийг хүсдэг миний дотор бузар муу нь байдаг гэсэн хуулийг би олж мэдлээ. ²²Би доторх хүнийхээ хувьд

Бурханы хуульд баярладаг. ²³Гэвч миний эрхтнүүдэд өөр хууль байдаг бөгөөд тэр нь миний оюун ухааны хуультай дайтаж, намайг өөрийн минь эрхтнүүдэд байдаг нүглийн хуулийн хоригдол болгодог юм байна гэдгийг би харж байна. ²⁴Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн

энэ биеэс ангижруулах вэ? ²⁵Бидний Эзэн Есүс Христээр Бурханд талархал нь байх болтугай. Иймд нэг талаар би өөрийн оюун ухаанаар Бурханы хуульд үйлчилдэг боловч, нөгөө талаар би өөрийн махан биеэрээ нүглийн хуульд үйлчилдэг

Таны мөхөс байдал

Гэм болон Бурханы хуулийн шаардлага дотор үхэх нь хичнээн гайхамшигтай вэ! Бид Бурханы төлөө амьд байгаа бөгөөд Есүс Христэд итгэх итгэлээр бид зөвтгөгдсөн. Есүс бидний төлөө юу хийснийг бид харсан. Бид Бурханы төлөө ариун амьдралаар амьдрахаас өмнө нэг бэрхшээлтэй зүйлийг шийдсэн байх хэрэгтэй гэж Паул сануулсан. Паул Бурханы хуулинд байдаг хоёр жаргалын аль нэгийг нь сонгох хэрэгтэйг дүрслэн хэлжээ. Бид Бурханы хуулийг сайн гэдгийг мэднэ. Тэр бидний зөв гэсэн зүйлийг хийж бидний төлөө хамгийн сайн зүйлийг хийхийг хүсэж байсан. Гэвч өөрийн хүчээр Христийн амьдралаар амьдрахыг хүссэн хүн болгон Паултай тохиолдсон зүйлтэй учирдаг. Энэ нь махан бие (Бурханаас тусдаа байх хүний оюун ухаан, хүсэл) болон түүнтэй хамт байгаа Бурханы Сүнс (Бурханы хүсэж байгаа зүйлийг хүсдэг) хоёрын агуу тэмцэл юм.

Паул өөрийгөө аврагдсаны дараа мөн түүнээс өмнө түүний “махан бие” Бурханд таалагдахаа больсон гэдгийг олж мэдсэн. Тэр өөрийнхөө махан биед бүх муу зүйл байгаа гэж дүгнэсэн. Энэ нь гайхалтай илчлэлт. Учир нь тэр хэн нэгнээс тусламж гуйсан. Түүнд зөвхөн ганц хүн тусалж чадна гэдгийг тэр мэдэж байсан. Аврал Есүс Христээр дамжин ирсэн гэдгийг Паул мэдсэн төдийгүй талархалтайгаар гуйж байв. “Бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхан танд талархаж байна. Дараагийн хичээлээр та бидний дотор байдаг Христийн сүнс болон махан биеийн тэмцэлийг үзэх болно. Галатын итгэгч нарт нэгэн төрлийн бэрхшээл тулгарч байсан. Тэд Христийг итгэлээр хүлээж авсан боловч өөрсдийн хүчээр (махан биеэр) бүгдийг хийхийг хүсэж байлаа. Паул энэ бэрхшээлийг сайн

мэддэг хүний хувьд тэдэнд ингэж бичжээ. “1Мунхаг галатчууд аа, хэн та нарыг мэхлэв? Есүс Христ загалмайд цовдлогдсон нь та нарын нүдний өмнө дүрслэгдсэн. ²Та нар Сүнсийг Хуулийн үйлсээр хүлээн авсан уу? Эсвэл итгэлээр сонссоноор хүлээн авсан уу? Би зөвхөн үүнийг та нараас мэдэхийг хүсэж байна. ³Та нар тийм мунхаг гэж үү?” (Галат 3:1-3). Итгэлээрээ Есүсийг хүлээж авсан хүмүүс Христийн шинэ амьдралаар амьдарч чадна. “Зөвт хүн итгэлээр амьдарна”. (Галат 3:11б).

Бидэнтэй хамт байх Христийн хүч чадал

Христэд итгэх итгэлээрээ гэм болон шийтгэлээс чөлөөлөгдөж аврагдсаны дараа бид гэмийг үргэлж хойш түлхэж байхын тулд Түүнд итгэх итгэлээ үргэлжлүүлэх ёстой. “Есүс” гэдэг нь “Ехова бол Аврагч” гэсэн утга илэрхийлдэг. “³⁰Харин та нар Түүнээс болж Христ Есүс дотор байгаа юм. Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон юм. ³¹Ингэсэн нь “Сайрхагч нь Эзэн дотор сайрхаг” гэж бичигдсэнчлэн байхын тулд ажээ” (1 Коринт 1:30,31). Есүс өөрөө биднийг ариусгаж байдаг. Бид өөрийн хүчээр хэзээ ч Христийн амьдралаар амьдарч чадахгүй. Зөвхөн бидний дотор байх Христ л ариун амьдралаар амьдарч чадна. Бид Түүний төлөө амьдарч Түүний төлөө өөрсдийгөө зориулбал Тэр бидэнд Бурханы хүсэл болон ариун амьдралаар амьдрах хүч чадал өгдөг. “²⁰Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биедээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм” (Галат 2:20)

Махан бие болон Сүнс

Бид хуулийн дор байх хуулийг дагаж амьдрал нэг бэрхшээлтэй учирдаг. Паул үүнийг ийм арга замаар тайлбарлажээ:

“²²Абрахам хоёр хүүтэй байсан бөгөөд нэг нь шивэгчнээс, нэг нь эрх чөлөөт эмэгтэйгээс төрсөн гэж бичигдсэн байдаг. ²³Харин шивэгчний хүү махан биеийн дагуу төрсөн байтал эрх чөлөөт эмэгтэйн хүү амлалтаар төрсөн” (Галат 4:22,23). Хуучин хүн (Бидний хуучин амьдрал) махан биеэс дөнгөж төрсөн хүүхэдтэй адил бөгөөд тэд гэм болон хуулийн боол болон төрдөг. Харин шинэ

хүн “шинэ амьдрал” Бурханы сүнсээр төрдөг бөгөөд Бурханы амласан хүүхэд болж Бурханы нигүүсэлээр эрх чөлөөтэй амьдардаг. Нэгэнт “шинэ хүн” болон “хуучин хүн” бие биентэйгээ тэмцэлддэгээс хойш бид Библи юу гэж хэлснийг хийцгээе: **“⁸Харин эдүгээ та нар бас уур хилэн, хорон санаа, гүтгэлэг болон амнаас гарах жигшүүрт үгс бүгдийг нь зайлуулж хаягтун. ⁹Бие биедээ худал бүү ярь. Яагаад гэвэл та нар хуучин хүнээ бузар муу зуршилтай нь тайлж, ¹⁰шинэ хүнийг өмссөн. Энэ нь өөрийг нь бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу үнэн мэдлэгт шинэчлэгдсэн хүн юм”** (Коллосай 3:8-10). Та бол Христийн шинэ бүтээл. Хэрэв та дүрмийг өөрийн хүчээр дагахыг оролдвол та эрх чөлөөтөй байхаа болино. Та хуулийг дагаж Бурханд таалагдахыг оролдож байвал Христээс холдож буй хэрэг. (Галат 5:2-4) **“¹Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм. Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун ⁵Учир нь бид Сүнсээр дамжуулан итгэлээр зөвт байдлын найдварыг хүлээж байна** (Галат 5:1,5)

Паулын анхааруулга: **“¹³Ах дүү нар аа, та нар эрх чөлөө уруу дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махан биеийн төлөөх таатай боломж болгож бүү ашигла. Харин бие биедээ хайраар үйлчил”** (Галат 5:13). Та эрх чөлөөтэй болсон боловч (Христээс хүлээж авсан Ариун сүнс дотор) энэ нь та (махан бие дотор) юу хүссэнээ хийнэ гэсэн үг биш юм. **“Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өөртөө өмс”** (Ефес 4:24б)

Махан бие (Бурханы хүслээс саланга байдаг бидний хуучин хүн) үргэлж Сүнсний эсрэг зогсож байдаг.(Бурханы хүсдэг бидний бурханлаг байдал)

“¹⁶Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ. ¹⁷Учир нь махан бие Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махан биеийн эсрэг хүсдэг юм. Яагаад гэвэл хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махан бие ба Сүнс нь нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. ¹⁸Хэрэв та нар Сүнсээр удирдуулдаг бол Хуулийн дор байхгүй байна” (Галат 5:16-18)

Есүс Өөрийн дагалдагч нартаа нэгэн сайн зөвлөгөөг өгчээ: **“⁴¹Соригдохгүйн тулд сэргэг бай, залбир. Сүнс хүсэж байна, харин махан бие сул дорой юм гэв”** (Матай 26:41)

Бид дараа дараагийн хичээлээр Сүнс дотор алхах тухай илүү ихийг үзэх болно.

ХИЧЭЭЛ 15. ЕСҮС ХРИСТИЙН СҮНСНИЙ АМЬДРАЛ

Ром 8:1-4

"Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. ²Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ. ³Махан бие мөхөс болохоор Хуулийн

хийж чадаагүйг Бурхан хийсэн юм. Тэр Өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв. "Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно"

Хийх зүйлс

А.Ишлэлийг нөхөж бич.

1. Тиймд эдүгээ _____ дотор байгаа хүмүүст ямар ч _____ байхгүй. (Ишлэл1)
2. Учир нь Христ Есүс доторх _____ Сүнсний _____ нь чамайг _____ болон үхлийн _____ ажээ.(2)
3. "Махан бие мөхөс болохоор _____ хийж чадаагүйг Бурхан хийсэн юм. Тэр Өөрийн Хүүг нүгэлт _____ адил байдалд нүглийн тулд илгээж, _____ дотор _____ шийтгэв"(3)

[Бурханы хууль нь ариун бөгөөд гайхамшигтай. Гэвч энэ хууль нь хүнийг зөвт болгоход хангалттай хүч чадалтай байж чаддаггүй. Есүс хүний биеийг олж дэлхий дээр ирсэн (Филлипой 2:7), харин тэр ямар ч гэмгүй байжээ. (Еврей 4:15).]

4. Ингэснээр Хуулийн _____ нь _____ дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно. (4)
5. Ром 8:1-4 ишлэлийг дахин нэг сана.

Хоёр хүчирхэг хууль

14-р хичээлээр Паул хэдийгээр буруу зүйл хийхийг хүсэхгүй байвч түүнд үүнийг хийх хүсэл байгааг олж харсан. Тэр энэ уруу татдаг зүйлийг "Үхэл ба гэмийн хууль гэж хэлсэн." Эдгээр зүйл нь биднийг дэлхийн татах хүчний хуулийн адил гэм хийхэд хүргэдэг. (үр дүн нь үхэл). Бид үүнийг өөрийн хүчээр даван туулж чадахгүй. Харин нэгэн хууль үүнийг даван туулж чадна.

Есүс Христ дотор байгаа хүмүүс ял зэмлэл доор байхгүй. Учир нь Есүст итгэх итгэлээр тэд зөвт хэмээн тунхаглагджээ. Махан бие (Үхлийн хуулийг дагадаг) одоо бидний амьдарч байгаа мөнх бус биеийг төлөөлдөг. Харин бид сүнс дотор алхахдаа Эзэний алдартай хамт байж Түүнийг дагаж махан биед удирдуулдаггүй учир нь үүнээс илүү “Есүс Христийн сүнсний амьдрал” гэсэн хүчирхэг хууль байдаг. Энэ хуулийг зүйрлүүлбэл онгоцны хөдөлгүүр бөгөөд татах хүчний хуулийг эсэргүүцэж хүнд онгоцыг далай дээгүүр хөвүүлэхтэй адил юм. Татах хүчний хууль үйлчилж байгаа боловч хүчирхэг хөдөлгүүртэй онгоцыг хэзээ ч доош нь татаж дийлдэггүй.

Есүс Христ доторх амьдрал

“Түүнд амь байсан” (Иохан 1:4а). Есүс бидэнд ингэж хэлсэн **“Би..... амь мөн”** (Иохан 14:6б) Есүс дотор нь байгаа хэн боловч амьтай. **“¹²Хүүтэй хүнд амь бий”** (1 Иохан 5:12а)

Есүс Христийн амийг авсан хүн маш хүчирхэг бөгөөд Сүнс дотор алхсанаар гэм болон үхлийн хуулиас чөлөөлөгддөг. Ром номны 8-р бүлэг нь Христ доторх амьдралын тухай болон Христэд итгэх амьдралаар хэрхэн амьдрах тухай маш тодорхой бичжээ. Христ доторх амьдрал махан биеийн хүсэл бүрийг эсэргүүцдэг. **“Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно”** (Матай 10:39б)

Христ доторх амьдрал нь амьд устай адил

Христ доторх амьдрал нь итгэгч хүмүүсийн амьдралыг үргэлж шинэ болгон цэвэршүүлж байдаг. Есүс нэгэн удаа гэмтэй бүсгүйд ингэж хэлжээ. **“¹⁴Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно”** (Иохан 4:14)

Хуучин гэрээн дээр Түүний хүмүүс Өөрийг нь үгүйсгэхэд Бурхан гашуудаж байжээ. **“¹³Учир нь Миний хүмүүс хоёр бузар мууг үйлдсэн билээ: Тэд өөрсдөдөө зориулан ус тогтоож чаддаггүй эвдэрхий нөөцлүүрүүдийг чулуу ухан хийхийн тулд амийн усны ундарга болох Намайг умартсан юм”** /Иеремиа 2:13/. Энэ нь өнөө үеийн олон хүний дүр зураг биш гэж үү? Бурхантай амин чухал харилцаатай байхын оронд тэд өөрсдийн замаар хайрыг олохыг хичээдэг. Энэ тэднийг ямар ч амьдралгүй болгодог.

Дэлхийн амьдралаас дээгүүрх Есүсийн амьдрал

Христийн амьдралыг шинээр авч төрсөн хүмүүс Түүнийг Түүний үхэл болон дахин амилалтаар нь таньдаг. Тэд мөн Есүсийг Эцэгийнхээ баруун гар талд байгаагаар нь таньдаг. Махан бие дотор амьдарч байгаа ч бид Есүс Христтэй сүнсээрээ “тэнгэрлэг газар” амьдарч болно. “**5Биднийг гэм нүгэл дотроо үхсэн байхад Христтэй хамт амьд болгосон юм. Та нар нигүүлслээр аврагдсан билээ. 6Биднийг Түүнтэй хамт амилуулж, тэнгэрлэг газарт Христ Есүс дотор Түүнтэй хамт суулгасан**” (Ефес 2:5,6) “**Тэрээр Христ дотор тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн**” (Ефес 1:36). Онгоц болон өндөр уулнаас доор байгаа зүйлийг харвал маш жижиг харагддаг. Хэрэв та сүнслэг амьдралаар амьдарч тэнгэрлэг газар Есүс Христтэй хамт байвал учирч буй бэрхшээлүүд танд маш жижигхэн харагдах болно. Та Бурханы нүдээр юмыг харах болно.

Есүсийн амьдрал бол дотны холбоо юм.

Бидний доторх Есүсийн амьдрал болон Түүнд зориулах бидний амьдрал нь гэрлэж буй дотны харилцаатай адил юм. Энэ бол хайрын холбоо. Бид Түүний хайрыг хүлээж авч мөн Түүнд өөрсдийн хайрыг өгдөг. Тэр Өөрийн үгээр бидэнтэй ярьж шинэ зүйлүүдээр Өөрийгөө илчилдэг. Бид Түүнтэй залбиралаар ярьж байхдаа гэмээ гэмшин Түүнд өөрийн нөхцөл байдлаа хэлэх хэрэгтэй. Өөрсдийн баяр хөөр болон уй гашуугаа бид Есүстэй хуваалцах хэрэгтэй. Бид Түүнд өөрсдийн бие дотор амьдрах боломж олгох хэрэгтэй бөгөөд ингэснээр Тэр бидэнд юу хийх хэрэгтэй болон юу хэлэхийг сануулдаг.

Шөнө сэрсэн үедээ ч бид Түүнтэй харилцаа холбоотой байж болно. “**Учир нь Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй. Би чамайг хэзээ ч мартахгүй” гэж айлдсан**” (Еврей 13:5б)

Таныг өөрчилсөн Есүс Христийн амьдрал

Бид Есүстэй ойр алхаж байхдаа Түүнтэй адил болж өөрчлөгддөг. Бурхан Өөрийн дүр төрхөө бидэн дээр сэргээж байдаг. Түүнд зориулах бидний хайр бусад бүх хайр болон дэлхийн сонирхолыг орлодог. Махан биетэй бүү тэмцэлд- махан бие улам л хүчтэй болох болно. Харин Есүс таныг аль хэдийн Бурханы шинэ амьдралаар хангасан. “**Та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ**”. (Галат 5:16б)

Хэрэв та Бурханы нигүүлсэл дор идэвхитэй байж (тэвчээр гаргаж), Түүний сүнснийг дуулгавартай дагах юм бол махан биеийн хүсэл Түүний хүч чадлаар үгүй болж эхэлдэг. Бурханы сүнс таныг гайхамшигтай Авралын Хүргэн Хүүтэй учруулах болно. **“¹⁸Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг. Энэ нь Эзэний Сүнсээр болдог”** (2 Коринт 3:18) Түүний дотор амар тайван бай, Түүний дотор баяр хөөртэй бай Түүнтэй хамт нөхөрлө! Тэр таны төлөө гайхалтай өөрчлөлтийг хийх болно.

ХИЧЭЭЛ 16. МАХАН БИЕ ДЭЭГҮҮРХ АРИУН СҮНСНИЙ ХҮЧ ЧАДАЛ

Ром 8:5-13

“Учир нь махан биеийн дагуу байгчид нь махан биеийн юмсыг боддог. Харин Сүнсний дагуу байгчид нь Сүнсний юмсыг боддог. ⁶Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой. ⁷Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй. ⁸Махан бие дотор байгсад Бурханд таашаагдаж чадахгүй. ⁹Хэрэв Бурханы Сүнс үнэхээр та нарын дотор оршиж байвал, та нар махан бие дотор бус, харин Сүнс дотор байна. Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх

биш. ¹⁰Хэрэв Христ та нарын дотор байгаа бол, нүглээс болж бие нь үхмэл хэдий ч, зөвт байдлын улмаас сүнс нь амьд байна. ¹¹Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжуулан үхлийн биест чинь амь өгнө.

¹²Тиймд ах дүү нар аа, бид махан биеийн дагуу амьдрахын тулд махан биед өртөнгүүд биш. ¹³Учир нь хэрэв та нар махан биеийн дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно”

Хийх зүйлс

Нөхөж бичиж байхдаа махан бие дотор алхаж яваа (өөрийн замаар яваа) болон Сүнс дотор алхаж байгаа (Бурханы замаар явж байгаа) хоёрын ялгааг олж хараарай:

1. Учир нь махан биеийн дагуу байгчид нь _____ юмсыг боддог. Харин Сүнсний дагуу байгчид нь _____ юмсыг боддог. (5)

2. Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол _____ ба _____ болой. (6)

3. Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг _____ юм. Учир нь энэ нь Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй. Махан бие дотор байгсад Бурханд _____ чадахгүй.

[Бид хэзээ ч өөрсдийн замаар Бурханы тааллыг олж авч чадахгүй. Бид зөвхөн түүнд итгэснээр Бурханы тааллыг олно. “6Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” (Еврей 11:6).]

Сүнсний амьдрал дахь баталгаа

Та “махан бие” “сүнс” хоёрын алинаар нь удирдуулж байна вэ? Хэрэв Бурханы сүнс таны дотор оршиж байвал та сүнс дотор байна гэж Бурхан хэлж байна. (Ром 8:9) “Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш.” (Ром 8:9) Энэ бол Бурханаас ирсэн маш тодорхой үг юм. Хэрэв Христийн сүнс таны дотор байхгүй бол та жинхэнэ итгэгч биш. Бурхан хэлэхдээ: “6Махан биеийн бодол санаа бол үхэл” (Ром 8:6а) “13Учир нь хэрэв та нар махан биеийн дагуу амьдарвал үхэх ёстой” гэжээ (Ром 8:13а). Бурханы үгэнд итгээрэй. Та бүү мэхлэгдээрэй. Махан бие дотор алхаж байгаа зарим тачаадсан оюун бодолтой хүмүүс “Та лав үхэхгүй” гэж хэлж магадгүй юм. Ийм үгийг Еден цэцэрлэгт Сатан Евад хэлж байсан. (Эхлэл 3:4б) Паул хэлэхдээ: “3Гэвч могой залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ уруу хандсан [цэвэр,] энгийн байдлаас та нарын санаа бодлуудыг төөрүүлчих вий гэхээс би айж байна” (2 Коринт 11:3) Танд өөрөөр аврагдах боломж байхгүй.

Санагтун “1Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст

ямар ч ял байхгүй” (Ром 8:1) Харин Христ дотор байхгүй хүмүүст ял шийтгэл ирэх болно. “¹⁸Түүнд итгэдэг хүн яллагдахгүй. Харин үл итгэдэг хүн аль хэдийн яллагдсан. Учир нь тэр хүн Бурханы цорын ганц Хүүгийн нэрэнд итгээгүй юм” (Иохан 3:18)

Есүсийн ирсэн зорилго нь Тэр бидний гэмийг авч бидний дотор байж, Түүний хүч чадлаар бид гэмгүй амьдрах юм. Есүсийн амьдралаар гэмгүй амьдарч буй хэн ч бай гэмтэй амьдралынхаа хэв маягийг үргэлжлүүлж чадахгүй.

“⁵Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үзэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. ⁶Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй. ¹⁰Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг үйлддэггүй аливаа хүн Бурханых биш. Ах дүүгээ хайрладаггүй нэгэн нь ч Бурханых биш” (1 Иохан 3:5,6,10)

Элч Иохан итгэгч хүмүүс гэм хийж болохгүй гэж хэлсэн. Итгэгч хүмүүс төгс биш учраас тэр бидэнд юу хийхийг хэлж өгсөн. **“Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн” (1Иохан 1:26) “⁹Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ” (1 Иохан 1:9) Бид гэмүүдээ гэмшсэний дараа цэвэршиж үргэлжлүүлэн Бурханы гэрэл дотор алхаж эхэлдэг. “⁷Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг ажээ” (1 Иохан 1:7)**

Сүнс дотор алхах нь

Бурхан Өөрийнх нь замаар явж байгаа Өөрийн ард түмэндээ Өөрийн сүнсээ туслуулахаар өгнө гэж амлажээ. **“²⁷Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно” (Езекиел 36:27) Сүнс дотор алхах гэдэг нь Бурханыг зүрх сэтгэлдээ байлгана гэсэн үг. Энэ нь шинэ амьдрал дотор алхах гэсэн утгыг илэрхийлнэ. (Ром 6:4). Бурханы Хүүд итгэх итгэлээр алхах гэдэг нь “Эдүгээ би махан биендээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм”**

(Галат 2:20). Хэрэв та Бурханд өөрийг тань өөрчлөх боломж олгох юм бол Тэр таны оюун бодолд үгээ хэлж Түүний хүч чадал тань дээр ажиллах болно. Сүнс дотор алхах гэдэг нь бүхэл өдөржингөө Бурхантай хамт нөхөрлөнө гэсэн үг. Өөрөөр хэлбэл та Түүнээс асуулт асууж, Түүний заавраар явж, итгэл дотор баяр хөөртэй байж, Түүний амлалтанд итгэнэ гэсэн үг юм. Христ таны дотор амьдарч байгаа цагт ийм зүйл үргэлжлэх болно. Бурхантай нөхөрлөснөөр Түүнтэй санал нийлж, Түүнийг хайрлаж, өөрийн тэмцэл болон баяр хөөрөө Түүнтэй хамт хуваалцаж, өөрийн бодол санаагаар Түүнийг хүндлэнэ гэсэн үг юм. **“Түүний дотор оршдог гэж ярьдаг нэгэн Түүний хэрхэн явсанчлан өөрөө бас тийн явдаг байх ёстой”** (1 Иохан 2:6). Есүсийг зүгээр хааяа нэг дуурайх биш харин тэр бол бидний амьдрал юм.

Тачаангуй оюун бодол

“Тачаангуй” гэсэн үг нь шинэ гэрээн дээр **“махан бие”** гэж орчуулагддаг. Энэ нь гэмтэй амьдралаар амьдарч буй хүмүүсийг дүрсэлдэг. Заримдаа махан бие гэдэг үг нь хүний бие махбодь гэж тайлбарлагддаг. Есүс Өөрөө **“махан биетэй” Бурхан байсан** (Иохан 1:1, 14) Тэр ямар ч гэмгүй бөгөөд энэ дэлхий дээр хүний биеийг олж хүмүүсийн дунд амьдарч байсан. Заримдаа шинэ итгэгчид Христэд итгэх итгэлээр гэмээсээ чөлөөлөгдөж, эрх чөлөөтэй болсоноо мэдээгүйн улмаас махан биеийн дагуух амьдралаа үргэлжлүүлсээр байдаг. Паул Коринт дахь итгэгчдийн энэ зүйлсийг мэдээд тэдэнд захидал бичсэн. **“Та нарын дунд атаархал, маргаан байгаа нь та нар махан биеийнхээ дагуу, хүний ёсны дагуу явдаггүй гэсэн хэрэг үү?”** (1Коринт 3:36) Махан биеийн бодол нь бардамналд захирагддаг. Харин Бурханы хамгаалалтанд түших нь Түүний нигүүсэлд найдах юм. Жинхэнэ итгэгчид өөрсдийн оюун бодлоо Амьд Бурханы хүчинд суурилуулдаг. Есүс махан бие дотор алхахдаа гэмийн ямар ч муу зуршил хийгээгүй. Хэрэв Тэр махан биеийн үйлсээр явсан бол Түүнтэй хамт буй Сүнс Түүний бурууг хүлээлгэнэ. Бурханы өмнө гэмээ улайх юм бол Тэр бидний гэмийг цэвэрлэж эргээд бид Бурхантай нөхөрлөх болно. Та Бурханы хүч чадалд найдвал Түүний үнэнч шударгын үр жимсийг цаашдаа хүртэнэ. (38-р хуудас үз) Энэ нь хэрхэн Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэх тухай юм. (Ром 8:13).

Сүнслэг оюун бодол

Сүнслэг оюун бодол бол махан биеийн оюун бодлын эсрэг тал нь юм. Христийн оюун ухаан нь Бурханд захирагддаг, Бурханыг хайрладаг ба бусдад хайртай, Бурханд үйлчилэн бүх зүйлд талархдаг. Энэ оюун ухааны шинж чанар бол амь ба амар тайван. Энд ямар ч маргаан үхэл байхгүй. **“Харин бидэнд Христийн оюун ухаан бий”** (1 Коринт 2:166). Паул Христийн оюун ухааныг тодорхойлохдоо: **“³Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэж, ‘хүн бүр зөвхөн хувийн ашиг сонирхлыг бус, харин бусдын ашиг сонирхлыг хар’** (Филиппой 2:3, 4). Эдгээр ишлэлүүд нь таныг юу хий гэж өгүүлж байна вэ? Сүнслэг оюун бодол нь бардамнадаггүй бөгөөд даруу төлөв юм. Энэ оюун бодол нь Бурханы хүсэлд дуулгавартай хандах ба Есүс загалмайн үхэлд дуулгавартай захирагдсаны адил юм. **“⁶Ингэхдээ хойшид биднийг нүгэлд боолчлуулалгүй, нүглийн биеийг маань хүчингүй болгохын тулд бидний хуучин хүн нь Түүнтэй хамт цовдлогдсоныг бид мэддэг”** (Ром 6:6). Завхарсан оюун ухаан бол талархдаггүй гэдгийг бид 3-р хичээлийн эхний алхамаар үзсэн. Сүнслэг оюун ухаан бол талархалтай оюун ухаан юм. **“¹⁶Үргэлж баяртай бай. ¹⁷Тасралтгүй залбир. ¹⁸Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. ¹⁹Сүнсийг бүү бөхөө”** (1 Тесалоник 5:16-19)

Христийн Сүнс амь өгдөг

Таны махан бие үхэхээр тогтоогдсон (Еврей 9:27) боловч хэрэв таны дотор Христийн Сүнс байвал та мөнх амьтай, учир нь энэ нь Түүний зөвт байдал юм. (Ром 8:10). Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Бурханы Сүнс та нарын дотор оршвоос Тэр таны махан биеийг үхэгсдээс нэг л өдөр амилуулна. (Ром 8:11). **“¹⁴Бурхан зөвхөн Эзэнийг амилуулсан төдийгүй биднийг ч бас Өөрийн хүчээрээ амилуулна”** (1 Коринт 6:14). Одоо ч Түүний төлөө үйлчлэн Түүнд хандан залбирахад өвчтэй буюу эцэж цуцсан биеийг тань таны доторх Есүсийн амь өгөгч Сүнс үргэлж сэргээх болно. **“¹⁶Тиймээс бид зүрх алддаггүй. Хэдийгээр гаднах хүн маань ялзарч байгаа ч доторх хүн маань өдрөөс өдөрт шинэчлэгдэж байна”** (2 Коринт 4:16).

ХИЧЭЭЛ 17. БУРХАНЫ ТӨЛӨВШСӨН ХҮҮХЭД БОЛОХ

Ром 8:14-18

¹⁴Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм. ¹⁵Дахин айдаст хүргэх боолчлолын сүнсийг та нар хүлээн аваагүй, харин үрчлэлийн Сүнсийг авсан билээ. Түүгээр бид “Аав! Эцэг минь!” гэж дууддаг. ¹⁶Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнсстэй хамт гэрчилдэг.

¹⁷Хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид нь бас мөн. Христтэй хамт алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм.

¹⁸Учир нь энэхүү өнөө үеийн зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү алдартай зүйрлүүлшгүй гэж би боддог”

Хийх зүйлс

Бид Бурханы хүүхэд болсон гэдгээ дөрвөн арга замаар мэдэж болно:

1. “Бурханы _____ байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм” (Ишлэл 14).

[Бурханы Сүнс биднийг ариун амьдрал руу татаж чиглүүлэхэд бид хариу үйлддэг.]

2. “Дахин _____ хүргэх _____ сүнсийг та нар хүлээн аваагүй” (15).

[¹⁷Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг”(2 Коринт 3:17). ¹⁷Учир нь Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн” (2 Тимот 1:7).]

3. “Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг _____ Өөрөө бидний сүнсстэй хамт _____” (16).

[Бурханы үг: бид нарыг Бурханы хүүхэд гэдгийг үнэнээр гэрчилдэг. ²⁶Учир нь та нар бүгд Христ Есүст итгэх итгэлээр Бурханы хөвгүүд болсон ажээ” (Галат 3:26). Бас нэг гэрчилдэг зүйл бол Бурханы Сүнсний “дотоод гэрчлэл”. Тэр нь бидний сүнс Бурханд хамааралтай болохыг мэдүүлдэг. “Би Түүнийх, Тэр минийх.” Бид Бурханыг “Аав” гэж дууддаг бөгөөд энэ үнэн.]

4. “Бид хүүхдүүд нь юм бол, Түүнтэй хамт _____ юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм” (17).

Есүс төлөвшсөн Хүү шиг амьдарсан

Бурханы Хүү Есүс, тэнгэрт байгаа Эцэгтэйгээ тааламжтай нягт харилцаатай байсан. Тэд нэг билээ. Есүс хэлэхдээ, “**Хүү Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээр зүйлийг түүнчлэн хийдэг**” (Иохан 5:19б).

³⁸“**Яагаад гэвэл Би Өөрийнхөө хүслийг хийхийн тулд бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хийхийн тулд тэнгэрээс бууж ирсэн юм**” (Иохан 6:38).

“**Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг**” (Иохан 8:29б).

Үрчлэлийн Сүнс

Бид Бурханы гэр бүлд шинээр төрсөн. “**Есүс бол Христ мөн гэдэгт итгэдэг бүхэн Бурханаар төрөгсөд болой**” (1 Иохан 5:1а)

Шинэ гэрээн дээр “Үрчлэл” гэсэн үг нь“ өв хөрөнгөө хүлээн авахад бэлэн болсон насанд хүрсэн Бурханы хүүхэд” гэсэн утгатай байдаг.

Паулын үеийн грекчүүд өөрсдийн хүүхдүүдийг өв хөрөнгөө өвөлж авахад нь эцгийнх нь тогтоосон хугацаанд хүртэл дүрэм журман дунд асрагчийн дор хүмүүжүүлдэг байсан. Харин төлөвшсөн хүүхдэд бол дүрэм журамын шаардлага байхгүй. Есүс Бурхан Эцэгтээ таалагдах дотоод чин хүсэлтэй байсан. Бурханаар төрсөн хүүхдүүд Үрчлэлийн Сүнсийг хүлээж авахдаа онцгой эрхтэйгээр төлөвшсөн хүүхдийн хариуцлагыг бүгдийг нь хамт хүлээж авдаг. Тэд Есүс шиг амьдарч, өөрсдөө Бурханы Үг ба Бурханы Сүнсээр удирдуулдаг. Бичигдсэн хуулийн үгсэд боолчлогдсон хүн Бурханы хүүхэд биш, харин Бурханы Сүнсний хуулийг дагаж мөрддөг хэн ч Түүний зүрхэнд байна.

“**Түүний зүрхэнд Бурханых нь хууль оршдог; Түүний алхамд алдаа байхгүй**” (Дуулал 37:31). “**Бурхан минь ээ, би Таны хүслийг гүйцэлдүүлэхдээ баярладаг юм.**

“**Таны Хууль миний зүрхэнд бий**” гэж хэлсэн” (Дуулал 40:8).

Христийн Сүнс (Бурханы Хүү) дотор буй биднийг Бурхан “Эцэг” Есүс шиг дуудсан. “**Та нар бол хөвгүүд нь мөн тул, Бурхан Өөрийн Хүүгийн Сүнсийг бидний зүрхэнд илгээсэн байна. Тэр**

Сүнс “Аав, Эцэг” гэж дууддаг. ⁷Тиймээс чи цаашид боол биш, харин хүү нь мөн. Хэрэв хүү нь байх аваас Бурханаар дамжуулан өв залгамжлагч нь мөн байна” (Галат 4:6,7) Есүс Загалмай дээрх ажилаа үнэнчээр биелүүлж, тэнгэр дэх Эцэгтээ хандан залбирах үедээ “Abba” (Аав, Эцэг) (Марк 14:36) хэмээн Түүнийг дуудсан. “Abba” (аав) гэдэг нь Арамей хэлэнд дотны, зүрхний, бяцхан хүүхдүүд өөрийн эцэгээ дуудахдаа царайндаа илэрхийлж дууддаг “Da-da!” гэдэг үгтэй адил утгатай. Бид ч мөн адил өөрийн тэнгэр дэхь Эцэгтэйгээ маш ойр дотно харилцаатай байдаг.

Христийн алдар ба зовлонг Бурханы хүүхдүүд хуваалцдаг

Есүс гэмгүй боловч зовлон амссан. “Тэр Хүү нь байсан хэрнээ зовсон зүйлсээсээ дуулгавартай байдалд суралцсан” (Еврей 5:8). Бид Түүний зовлон ба алдар дахь сайн сайхан зүйлийг хуваалцсанаараа Христийн өв залгамжлагч болдог. **“²Учир нь Христийн төлөө Түүнд зөвхөн итгэх бус, Түүний төлөө бас зовох нь та нарт соёрхогджээ”** (Филиппой 1:29).

Сүнсний хүч чадалаар “махан бие”-ийн гэм нүгэл болон зовлонг таслан хаяж болдог. Ертөнц Түүнийг үзэн ядсан шиг биднийг бас үзэн ядна. (Иохан 15:18). Зовлон бидэнд өгөгдсөн нь Есүстэй маш гүн гүнзгий нөхөрлөх сайхан боломж юм. **“Ингэхдээ би Түүнийг болон Түүний амилалтын хүч, зовлонгуудын нөхөрлөлийг таньж мэдэн, Түүний үхэлтэй адилхан болгогдож”** (Филиппой 3:10). Харин ямар ч зовлон бидний тэнгэр дэхь ивээл ба мөнхийн баяр хөөртэй харьцуулашгүй жижиг шалгуур юм. **“Учир нь цаг зуурын ялихгүй зовлон нь бидэнд мөнх алдрыг үлэмж арвинаар бий болгож байна”** (2 Коринт 4:17). **“Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм”** (Еврей 12:2). Есүс хэлэхдээ **“Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийд заларсны адил Надтай хамт Миний сэнтийд залрахыг ялагчид соёрхоно”** (Илчлэлт 3:21).

ХИЧЭЭЛ 18. БУРХАНЫ ХӨВГҮҮДИЙН ИРЭЭДҮЙН АЛДАР

Ром 8:19-30

¹⁸Учир нь энэхүү өнөө үеийн зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү алдартай зүйрлүүлшгүй гэж би боддог. ¹⁹Учир нь бүтээлийн тэсэн ядаж хүлээдэг нь Бурханы хөвгүүдийн илчлэгдэх юм. ²⁰Учир нь бүтээл нь өөрийнхөө хүслээр бус, харин өөрийг нь захирсан Түүний улмаас хоосонд захирагдсан юм. ²¹Энэ нь бүтээл нь өөрөө ч мөн ялзралын боолчлолоос чөлөөлөгдөж, Бурханы хүүхдүүдийн алдрын эрх чөлөөнд авчрагдах болно гэсэн найдварын улмаас юм. ²²Учир нь өнөөг хүртэл бүх бүтээл нь хамтдаа ёолон, хамтдаа төрөх зовлон эдэлдгийг бид мэднэ. ²³Зөвхөн үүнд ч биш, харин бас бид, өөрсдөдөө Сүнсний анхны үр жимсийг авсан бид ч дотроо ёолон биднийг үрчилж авахыг буюу бидний биеийг золин аврахыг тэсэн ядаж хүлээдэг. ²⁴Учир нь бид найдвараар аврагдсан байлаа. Гэхдээ харагдаж байгаа найдвар нь найдвар биш юм. Хүн харж буй зүйлдээ найдахын хэрэг юу байна?

²⁵Харин бид харахгүй байгаа зүйлдээ найдвал түүнийгээ тэвчээртэйгээр хүлээдэг.

²⁶Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёолон байж бидний төлөө зуучлан гуйдаг. ²⁷Сүнсний бодол санаа юу болохыг зүрхнүүдийг Нягтлагч нь мэддэг. Яагаад гэвэл Тэр Бурханы хүслийн дагуу ариун хүмүүсийн төлөө зуучлан гуйдаг юм. ²⁸Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст тохиолддог бүхий л зүйл эцэстээ тэдний сайн сайхны төлөө байдаг гэдгийг бид мэднэ. ²⁹Тэр Өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм. ³⁰Тэр урьдаас тогтоосон хүмүүсээ мөн дуудсан. Тэр дуудсан хүмүүсээ мөн зөвтгөсөн. Тэр зөвтгөсөн хүмүүсээ мөн алдаршуулсан.

Хийх зүйлс

Хэн яагаад ёолдгийг хоосон зайд нөхөж бөглөөрэй:

1. “Бүх _____ нь хамтдаа ёолон хамтдаа _____ эдэлдгийг бид мэднэ” (22)

Бүтээлийн тэсэн ядаж хүлээдэг нь _____ илчлэгдэх юм. (19)

2. Бид өөрсөддөө _____ анхны үр жимснүүдтэй байх төдийгүй бидний _____ золилт болох үрчлэлийг _____ хүлээхдээ өөрсдийнхөө дотор ёолдог. (23)

3. Харин _____ Өөрөө үгээр _____ ёолон байж бидний төлөө зуучлан гуйдаг. (26b)

Тэр Бурханы хүслийн дагуу _____ хүмүүсийн төлөө зуучлан гуйдаг (27b)

Бүх бүтээлийн ёололт

Адам гэмд унаснаараа энэ дэлхийн хүн төрөлхтөнд уйтгар гуниг, үхэл авчирсан. Мөн дэлхий ертөнц харагдсан. Харин Христийн эргэн ирэхэд Бурханы хүүхдүүдтэй хамт энэ ертөнц, боолчлолын хүлээснээс чөлөөлөгдсөн. **“Харин Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг хүлээн байна”** (2 Петр 3:13). Түүний дүүргэлт ба агуу гайхамшигтай алдрын Эзэн гэдэг нь бүх дэлхийд тэр нэгэн өдөр илчлэгдэх болно. Бурханы хөвгүүд Түүнтэй хамт-Бурханы дүр төрхөөр шинэчлэгдсэнээр-бүх зүйлийг илчлэн харуулах болно.

Паул бидэнд хэлэхдээ яагаад хүнд зовлонг эдэлсэнээ хэлсэн.

“Хүүхдүүд минь, Христ та нарын дотор дүрээ олтол би төрөх зовлонг дахиж эдэлж байна” (Галат 4:19). Бурхан Өөрийн Хүүгийн дүрээ бидний дотор суулгасан. Энэ үйл явц нь ертөнцөөс далд явагдсан. Бурханы хүүхэд гэдгийг нь энэ ертөнц дэхь нэр алдараар нь танихгүй юм. Харин нэгэн өдөр тэр алдар цуу нь илчлэгдэх болно. Бид яг одоогийн байгаа биеэрээ дахин шинээр амилана. **“Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, гэм зэмгүйгээр зогсоож чадах Түүнд”** (Иуда ишлэл 24б). Авралын эцсийн тэр өдрийн төлөө бүх бүтээл хүсэн тэмүүлж байна. Тэгээд Ариун Сүнс бид нар дээр иртэл, “Тэр нь Бурханы эзэмшлийн золилт хүртэл бидний өвийн батлан даагч болж Түүний алдрыг магтуулахын тулд өгөгдсөн юм” (Ефес 1:14).

Хүүхэд бол өөрийн эцэгийнхээ дүр төрх нь

Хүүхэд хэний хүүхэд вэ? гэдэг нь маш тодорхой байдаг, Учир нь эцэг эхийнхээ дүр төрх нь хүүхэд нь юм. Есүс энэ зүйлийг маш сайн мэддэг байсан.

“Абрахам бол бидний эцэг” Есүс хэлэхдээ, “**Хэрэв та нар Абрахамын хүүхдүүд байсан бол, Абрахамын хийснийг үйлдэхсэн. Та нар эцгийнхээ үйлсийг хийж байна**” (Иохан 8:39б, 41а). Тэд Түүнд хэлэхдээ “Бидэнд Бурхан хэмээх нэг л Эцэг байгаа гэв. ⁴²**Есүс тэдэнд**

-**Хэрэв Бурхан та нарын Эцэг байсан бол, та нар Намайг хайрлах байсан** ⁴⁴**Та нар эцэг чинь болох диаволаас гаралтай. Та нар эцгийнхээ хүслийг хийхийг хүсдэг. Тэр чинь эхнээсээ алуурчин байсан бөгөөд үнэн дотор зогсдоггүй.**” (Иохан 8:41б, 42а, 44а). Бид яагаад дахин төрөх хэрэгтэй вэ?

⁴²**Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар байх нь хараахан үзэгдээгүй. Түүнийг үзэгдэх үед бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг яг байгаагаар нь харах болно. ³Түүнд ийнхүү найдаж байгаа аливаа хүн өөрийгөө цэвэршүүлдэг. Учир нь Тэр цэвэр ажээ.”/Иохан 3:2-3/**

Найдвар гэдэг нь бидэнд ямар ч боломжгүй байсан зүйл хэрвээ бид хүсвэл тэр маань библийн дагуу биелэнэ гэсэн үг. Найдвар гэдэг үг нь библид ямар нэг зүйл зайлшгүй болж тохиолдох гэсэн утгатай. Учир нь гэвэл та нар тэр зүйлээ хүлээж байх зуур итгэлийг ч олж авдаг. Иохан хэлсэнчлэн итгэл найдварыг бий болгох нь хүлээх хүлээлт юм гэсэн.

Таньд зориулсан Бурханы зорилго

Хэн Бурханаас төрсөн, хэн Бурханд хайртай тэр бүхэнд зориулсан нэг л зорилго бий. ²⁹**Тэр Өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм.** /Ром 8:29б/. Хэн Бурханых гэснийг Бурхан бүгдийг мэддэг. Тэд Түүний хүү Есүс шиг байхыг Тэр урьдаас тогтоосон. Бурхан Өөрийнхөө алдрыг тэдэнд өгч /тэдэнд зөвт байдлыг тунхагласан/ Тэр тэднийг шүүсэн бөгөөд Бурхан тэднийг дуудсан. Есүс Өөрийн Эцэгт залбирсан. ²²**Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Таны Надад өгсөн сүр жавхланг Би тэдэнд өгсөн билээ. ²³Би тэдний дотор, Та Миний дотор байдаг.**” (Иохан 17:22-23а).

“²⁷Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн.” (Колоссай 1:27)

Христ та нар дотор амьдрах үед Түүний дотор алдрыг хуваалцан хэзээд Түүнтэй хамт байж итгэлтэйгээр эцсийн өдрийг хүлээж чадна. **“¹⁰Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ.”**(Ефес 2:10).

Одоогийн зовлонгууд сайн зүйлрүү дагуулж байгаа

Паул хэлсэн: **“Бурханыг хайрладаг хүмүүст тохиолддог бүх зүйл тэдний сайн сайхны төлөө байдаг”** (Ром 8:28a). Зовлон бэрхшээл байсан ч гэсэн хэрэв Бурханд хайртай л бол Түүний хүүтэй адил сайн сайхан зүйлийг хүсэж, сайн сайхны төлөө ажиллах хэрэгтэй. **“¹²Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. ¹³Харин та нар Христийн зовлонгуудыг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгөөр баярлах юм”** (1Петр 4:12-13).

“⁶Хэдийгээр та нар эдүгээ түр зуур шаардлагатай бол элдвийн зовлонг эдэлж байгаа ч гэсэн үүндээ үлэмж баярладаг. ⁷Ингэснээр та нарын итгэлийн шалгуур нь галаар шалгах боловч мөхөх алтнаас ч илүү үнэтэй байн, Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм.”(1Петр 1:6-7).

ХИЧЭЭЛ: 19 БУРХАНЫ ЗҮРХ СЭТГЭЛ ДЭХ ИТГЭГЧДИЙН МӨНХИЙН УЛС

Ром 8:31-39

³¹Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ? ³²Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ? ³³Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах вэ? Бурхан нь зөвтгөгч нэгэн мөн. ³⁴Ялладаг нь хэн юм бэ? Христ Есүс нь үхээд, бүр амилуулагдсан, Бурханы баруун талд байдаг, бидний төлөө зуучлан гуйдаг Нэгэн юм. ³⁵Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг

уу, зүдрэл үү, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэн байдал уу, аюул уу, илд үү?

³⁶Таны төлөө бид бүхэл өдөржингөө үхэж,

Бид нядлагдах хонь мэт тооцогдож байв” ³⁷Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжуулан давуулан дийлдэг. ³⁸Учир нь үхэл ч, амь ч, тэнгэр элч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, 39 өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэж би бат итгэлтэй байна.”

Бурхан бол биднийх

Энэ хичээл олон асуулт болон гайхамшигтай хариултаар дүүрэн. Бид Бурханы бидэнд зориулсан зориулалтын зорилго нь юу болох тухай сурсан: бидний тэнгэрлэг эцэг Бурханы дүр төрхөөр бид дахин төрж, бүх зүйлийг Есүс шиг хийх. Есүс Өөрийнхөө зорилгыг хэрэгжүүлсэн үү?

⁴⁶Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна.”/Филлиппой 1:6/.

Бурхан бидний төлөө Өөрийн хүүг зориулсаныг бид мэднэ. Хэрвээ бид зөвт гэдгийгээ тунхаглахын тулд бидэнд хамгийн сайнаа өгсөн Бурханы өмнө өөрийнхөө гэмийг илчилж чадах уу? Хэрвээ та нар Христ дотор байгаа бол Тэр Өөрөө та нарыг зөвт хүн гэж тунхагласан юм. Хэн чамайг буруутгаж чадах вэ? Хэн ч чадахгүй. Яагаад гэвэл Есүс таны төлөө нас барсан. Тэр та нарын төлөө дахин

амилж чадсан. Тэр одоо Бурханы баруун талд залран та нарын төлөө залбирч байгаа. **“Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ.”** /Иохан 3:17/

Нэг удаа хэдэн хүмүүс завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйг Есүс руу авчирсан. Тэд тэр эмэгтэйг Есүс буруутгана гэж бодож байсан. Гэвч өөрсдийн гэмээс болж нэг нэгээрээ явцгаасан. **“10Есүс цэх зогсож, тэр эмэгтэйд**

-Эмэгтэй, тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу? гэсэнд 11тэр

-Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс

-Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ. /Иохан 8:10-11/ Хэрвээ та нар Түүний дотор байвал Есүс та нарын хэнийг нь ч буруутгахгүй

Учир нь Түүний зорилго нь бидний гэмийг зогсоохын тулд юм. Бүх зүйл хоорондоо холбоотой.

“2Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулан, та нарын нүглүүд Бурханы нүүрийг та нараас далдалжээ. Тийм учраас Тэр сонсдоггүй.” /Исаиа 59:2/

Учир нь хэрвээ бид Бурханы өмнө ирээд гэмээ гэмших юм бол бид Есүстэй хамт амьдрах болно. Түүнийг дагалдаад бидэнд улам илүү Түүнтэй адил үр жимсүүд гарах болно.

Бурханаас биднийг юу салгаж чадах вэ?

Юу ч чадахгүй. Учир нь бид Түүний хайр дотор эрх чөлөөтэй.

Айдас түгшүүргүйгээр 75бид бүх өдрүүдийнхээ турш

Түүний өмнө ариун болоод зөвт байдал дотор

Түүнд үйлчлэхийн тулд болой. /Лук 1:74б, 75/

Есүс-²⁷**Миний хонин сүрэг дууг минь сонсдог. Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг юм. 28Би тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээ ч мөхөхгүй бөгөөд тэднийг хэн ч Миний гараас булаахгүй.** /Иохан 10:27-28/ гэж хэлсэн.

ХИЧЭЭЛ: 20 БУРХАНЫ АРИУСГАЛ БА НИГҮҮСЭЛ

Ром 9:1-29

¹Христ дотор би үнэнийг хэлж байна. Би худал яриагүй байна. Миний мөс чанар ²зүрх сэтгэлд минь маш их уйтгар гуниг, байнгын зовуур байгааг Ариун Сүнсээр гэрчилж байна. ³Учир нь махан биеэрээ миний хамаатан болох ахан дүүсийнхээ төлөө би Христээс салгагдаж, өөрөө хараал болоосой гэж хүсэж байлаа. ⁴Тэд бол израильчууд бөгөөд үрчлэл, алдар, гэрээнүүд, Хуулийн гардуулалт, үйлчлэл ба амлалтууд нь тэднийх юм. ⁵Эцгүүд ч тэднийх, Христ махан биеэрээ тэднээс гаралтай юм. Тэр бол бүгдийн дээр оршигч, үүрд мөнхөд магтагдах Бурхан мөн. Амен.

⁶Гэвч энэ нь Бурханы үг хүч чадлаа алдсан хэрэг биш юм. Учир нь Израилиас байгаа нь бүгд Израиль биш. ⁷Тэд Абрахамын үр удам ч гэлээ бүгд түүний хүүхдүүд гэсэн үг биш, харин “Чиний үр удам Исаакаар нэрлэгдэх болно” гэжээ. ⁸Махан биеийн хүүхдүүд нь Бурханы хүүхдүүд биш, харин амлалтын хүүхдүүд нь үр удам гэж тооцогддог. ⁹Учир нь “Энэ үед Би ирнэ. Сара хүүтэй болно” гэжээ. Энэ бол амлалтын үг юм. ¹⁰Зөвхөн энэ

ч биш, Ребека бас бидний эцэг Исаак хэмээх нэгэн эрээс хөл хүндтэй болсон. ¹¹Хүүхдүүдийг хараахан төрөөгүй, ямар ч сайн, муу зүйл үйлдээгүй байхад нь Бурханы зорилго нь сонголтын дагуу үйлсээр бус, харин Дуудагчийн улмаас байхын тулд ¹²“Ах нь дүүдээ үйлчилнэ” гэж эхэд нь айлдсан ажээ. ¹³Энэ нь “Би Иаковыг хайрласан, харин Есавыг үзэн ядсан” гэж бичигдсэнчлэн юм.

¹⁴Тэгвэл бид юу хэлэх вэ? Бурханд шударга бус юм байдаг уу? Бүү ийм байх болтугай! ¹⁵Учир нь Тэр Мосед “Би Өөрийн өршөөх хүнээ өршөөнө. Би Өөрийн өрөвдөх хүнээ өрөвдөнө” гэж айлдсан юм. ¹⁶Ингэхлээр энэ нь хүсдэг, эсвэл хичээдэг хүнээс биш, харин өршөөлт Бурханаас хамаардаг ажгуу. ¹⁷Учир нь Судар Фараонд “Өөрийнхөө хүчийг чамаар үзүүлэхийн тулд, мөн Миний нэр бүх дэлхий даяар тунхаглагдахын тулд чухам энэ л зорилгоор Би чамайг босгов” гэж айлджээ. ¹⁸Тэгэхлээр Тэр Өөрийн хүссэн хүнээ өршөөдөг, хүссэн хүнээ хатууруулдаг.

¹⁹Тэгвэл чи надад “Яагаад Тэр өнөөг хүртэл өө хайсаар байна вэ? Хэн Түүний хүслийг

эсэргүүцсэн юм бэ?” гэж хэлнэ. ²⁰Харин Бурханы эсрэг хариу хэлдэг хүн чи хэн юм бэ? Баримал нь барималчинд “Та яагаад намайг ингэж хийв?” гэж хэлдэг гэж үү? ²¹Нэг л зуурмагны шавраар хүндэтгэлийн нэг сав, ердийн хэрэглээний өөр нэг савыг хийхийн тулд ваарчин шаврынхаа дээгүүр эрх мэдэлгүй гэж үү? ²²Хэрэв Бурхан Өөрийн уур хилэнгээ үзүүлэхийг, мөн хүч чадлаа мэдүүлэхийг хүсэж байвч, сүйрэлд зориулагдсан уур хилэнгийн савнуудыг их тэвчээртэйгээр тэссэн бол юу гэх вэ? ²³Ингэснээр Тэрээр алдрын төлөө урьдаас Өөрийн бэлдсэн өршөөлийн савнуудад, ²⁴зөвхөн иудейчүүдээс ч төдийгүй, мөн харь үндэстнүүдийн дундаас бас Өөрийн дуудсан бидэнд

хүртэл Өөрийнхөө алдрын баялгийг мэдүүлэх юм. ²⁵Тэр Хосеа номд

“Минийх байгаагүй ард түмнийг Би “Миний ард түмэн”, хайрлагдаж байгаагүйг нь “Хайрт” гэж дуудна.

²⁶“Та нар Миний ард түмэн биш” гэж тэдэнд айлдсан газарт Тэд амьд Бурханы хөвгүүд гэж дуудагдах болно” ²⁷Исаиа Израилийн талаар хашхиран “Израилийн хөвгүүдийн тоо далайн элс мэт байсан ч үлдэгсэд нь аврагдана. ²⁸Учир нь Эзэн Өөрийн үгээ дэлхий дээр гүйцэд, түргэн биелүүлэх болно” гэжээ. ²⁹Исаиа

“Хэрэв түмэн цэргийн Эзэн бидэнд үр удам үлдээгээгүйсэн бол бид Содом шиг болж, Гоморратай адил болох байсан” гэж урьдаас хэлсэн юм.”

Паулын гашуудал

Бурхан дэлхийг ерөөж өөрийнх нь хүмүүс, Израильчуудын төлөө аврагчийг илгээхэд тэд Түүнээс татгалзсанд Паул тэдний төлөө харамсан уйлсан

Ром 9-р бүлэгт Бурхан хэрхэн тэднийг сонгосон тухай өгүүлсэн байдаг.

Ром 10-р бүлэгт Бурхан, Израиль яагаад ирээдүйг нь Бурхан бий болгох талаар итгэлгүй болсныг бидэнд хэлсэн. эдгээр бүлгүүдэд Бурханы хүүхдүүд болох бидэнд амласан амлалтуудыг өгүүлсэн.

Израилийн ивээлүүд

Израильчуудыг Бурхан адислан ерөөсөн 8-н зам байдгийг доор хоосон зайд бөглө.

1. Тэд бол Израильчууд бөгөөд _____ /Ишлэл 9:4a/
/Тэд Бурханаар Түүний хүүхдүүд болон үрчлэгдсэн юм." Эзэн ингэж айлдаж байна. / "Израиль бол Миний хүү, Миний ууган хөвгүүн." / Ег.гарсан 4:22б/

2. _____ /9:4/
Бурханы алдар Израильчуудтай байсан юм. ⁴³Би тэнд Израилийн хөвгүүдтэй уулзах бөгөөд энэ газар Миний цог жавхлангаар ариусгагдана. /Ег.гарсан 29:43/

3. _____ /9:4/
/Бурхан Абрахам, Давид, Мосе нартай гэрээ байгуулсан юм. ²⁵Та нар бол эш үзүүлэгчдийн хөвгүүд бөгөөд "Чиний үрээр дэлхийн бүх өрх айлууд ерөөгдөх болно" хэмээн Абрахамд айлдан, эцэг өвгөдтэй чинь Бурханы байгуулсан гэрээний хөвгүүд юм. /Үйлс 3:25/

4. _____ гардуулалт /9:4/
¹³Ингэж ЭЗЭН та нарт гэрээгээ зарлаж, та нарт даган мөрдүүлэхээр тушаасан. Энэ нь Арван Хууль бөгөөд түүнийгээ хоёр чулуун хавтан дээр Өөрөө бичсэн билээ. /Дэд хууль 4:13/

5. _____ Бурханы _____ /9:4/
¹Тэгэхлээр анхны гэрээ нь энэ дэлхийд хамаатай ариун газар ба үйлчлэлийн зарлигуудтай байжээ. /Еврей 9:1/

6. Ба _____ /9:4/
Израильчуудад тэдний ирээдүйн талаар болон ирэх аврагчын талаарх олон амлалтууд Бурханаас өгөгдсөн. ³²Бид эцэг өвгөдөд амлагдсан амлалтын тэрхүү сайн мэдээг л та нарт тунхаглаж байна." /Үйлс 13:32/

7. _____ тэднийх /9:5/
Израильчууд өөрсдийн өвөг эцгүүд болох Абрахам, Исаак, Иаковаар бахархаж байсан. ¹⁵Гэсэн ч ЭЗЭН зөвхөн чиний өвөг дээдсийг хайрлахаар таашаан соёрхож, тэдний үр удмыг сонгосон юм.." /Дэд хууль 10:15a/

8. _____ махан биеэрээ тэднээс гаралтай, Тэр бол бүгдийн дээр оршигч, үүрд мөнхөд магтагдах _____ мөн. /9:5/

/Хамгийн агуу бэлэг бол бүх дэлхий ертөнцийг адислах аврагч байсан юм. ⁴³Түүнд итгэсэн хэн боловч Түүний нэрээр нүглийн уучлалыг хүлээн авдаг гэж бүх эш үзүүлэгчид Түүнийг гэрчилдэг гэв." /Үйлс 10:43/

Есүс бүх гэмийг уучилж чадна. Учир нь Тэр бол Бурхан юм.

Бурханы ариусгалыг тайлбарлах нь

Эхлээд Израильчууд Бурханаар сонгогдсон хүмүүс гэдэгтээ бахархаж байсан. Паул тайлбарлахдаа Бурхан бол ариун зүйл гэдгийг хэлсэн байдаг. Тэгээд Бурханаар сонгогдсон хэн ч бай Түүнийг дуулгавартай дагах хэрэгтэй гэж хэлсэн. Бид Бурханд талархдаг. Учир нь Түүний сонголт нь бидний хэн болон хэн байсан гэдэг дээр тулгууралдаггүй.

Исаакын тухай тайлбар

Абрахам маш олон ерөөлийн хүүхэдтэй. Гэвч Бурханаар амлагдаж Түүний гайхамшигаар төрсөн нь зөвхөн Исаак юм. Бурхан Абрахамд энэ дэлхийг Би чиний үрээр дамжуулан ерөөнө. Энэ бүгдийг чамд өв болгон өгч байна гэж хэлсэн. Бурхан Абрахамд Өөрийнхөө амласан амлалтаа биелүүлэх хэрэгтэй байсан. Абрахам энэ бүгдийг итгэлээрээ өөрийн өв болгон хүлээн авсантай адил бид ч гэсэн энэ бүгдийг өөрийнхөө өв гэж хүлээж авах ёстой. Бурханы зорилго бол Абрахамтай адил олон хүүхдүүдтэй байх юм.”**Тиймээс итгэлийн хүмүүс нь Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав. 9Тиймээс итгэлийн хүмүүс итгэгч Абрахамын хамт ерөөгдсөн ажээ.**” /Галат 3:7,9/

Иаков болон Есав

Исаак амлалтын дагуу хоёр хүүтэй байсан. Энэ үед ууган хүү нь эцэгийнхээ ерөөл болон үүрэг хариуцлагыг өвлөн авдаг байв. Гэвч Бурхан бага хүү болох Иаковыг /сүүлд Израиль хэмээн нэрлэгдсэн/ олон үндэстний эцэг болгон түүгээр дамжуулан дэлхий ертөнцийг ерөөн адислахаар төлөвлөн сонгосон юм. Бурхан Иаковын зан чанар болон байгаа байдалаас нь болж сонгоогүй харин тэднийг төрөөгүй байхад, хүүхдүүдийг ямар нэг сайн эсвэл муу зүйл хийхээс нь өмнө Бурхан Өөрийн энэхүү зорилгогынхоо дагуу Иаковыг сонгосон.

Есаваар дамжсан Исаакын үр удам бол Бурханы ард түмэн биш байсан гэж эш үзүүлэгч Малахын харуулсныг Паул иш татсан байдаг. Иаков болон Есавыг нас барсны хэдэн зуун жилийн дараа Израилийн ард түмэн Бурханы хайрын талаар асуухад Малахи тэдэнд Бурхан Иаков ба түүгээр нэрлэгдсэн Израиль үндэстнийг хэрхэн хайрласан болон Есав ба Едом үндэстэнийг үзэн ядсан бөгөөд Есавын үр удмыг “Хорон нутаг” хэмээн дуудсан тухай ярьсан байдаг. **2”Би та нарыг хайрласан” гэж ЭЗЭН айлдаж байна. Гэвч та нар “Та биднийг яаж**

хайрласан юм бэ?” гэж асуудаг. ЭЗЭН тунхаглаж байна. “Есав нь Иаковын ах бус уу? Гэсэн ч Би Иаковыг хайрлаж, ³харин Есавыг үзэн ядсан. Би түүний уулсыг хоосруулж, түүний өвийг цөлийн цөөвөр чононуудынх болгосон”. “Едом нь “Бид цохигдсон, гэвч бид буцан ирж, балгаснуудыг босгоно” гэж хэлэвч түмэн цэргийн ЭЗЭН ингэж айлдаж байна. “Тэд босгож болно, харин Би нураах болно. Тэднийг хорон муу нутаг, ЭЗЭНий зэвүүцлийг мөнхөд авсан ард түмэн хэмээн дуудах болно”. /Малахи1:2-4/. Гэм нүгэл үйлдэгч бүгдийг Бурхан үзэн яддаг. ⁵Онгирон сагсуурагчид Таны мэлмийн өмнө зогсож чадахгүй.

Гэм нүгэл үйлдэгч бүгдийг Та үзэн яддаг. /Дуулал 5:5/ гэвч Тэр биднийг гэмээ гэмшин аврагдаасай гэж хүсдэг. ¹⁶Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм. /Иохан 3:16/.

Фараон

¹Олон зэмлүүлэвч хүзүү нь хөшсөн хэвээр байгч хүн
Нэг л өдөр эдгэшгүйгээр ойчих болно.

²Зөв шударга хүн дэвжих тусам ард түмэн баяр жаргалтай байдаг. (Сургаалт үгс 29:1-2)

Фараон хар санаатай удирдагч байсныг бид мэднэ. Тиймээс Израилийн ард түмэн Бурхан уруу хашхиран, ёолон уйлж түүнээс чөлөөлж өгөхийг гуйсан. Бурхан Фараонд боломжуудыг өгсөн боловч түүний зүрх хатуу байсан тул Түүнийг сонсолгүй эсэргүүцсэн. Бурхан Фараоны хатуурсан зүрхээр дамжуулан Өөрийн хүч чадлыг харуулахаар болсон. ¹⁶Харин Би Өөрийн хүчийг чамд үзүүлж, Өөрийн нэрийг бүх дэлхий даяар тунхаглахын тулд, үүний төлөө чамайг босгосон юм. /Египетээс гарсан нь 9:16/ Фараон бол Израильчуудад хатуурсан зүрхний нэгэн том жишээ болох байсан боловч сүүлд нь Израилийн ард түмэн зүрхээ хатууруулж, Бурханыг сонсохоо больсон байна. Энэ нь Бурханы маш олон ивээлүүдийг авсан бидэнд Бурханыг сонсолгүй Бурханд итгэлгүйгээр зүрхээ хатууруулахаас хамгаалах сануулга болж байна. “Хэрэв өнөөдөр та нар Түүний дууг сонсох аваас зүрхээ бүү хатуу болго” /Еврей7:76/.

Ваарчин ба шавар

Нэгэн удаа Бурхан үгээ ойлгуулахын тулд эш үзүүлэгч Иеремиад ваарчны гэрт оч гэжээ. Ваарчин дугуйн дээр шавраар юм хийж байв. Гэтэл түүний шавраар хийж байсан ваар нурахад тэрээр ондоо ваар болгож дахин хийв. **Израилийн гэр ээ, энэ ваарчинтай адил Би та нарт мөн ингэж үйлдэж чадахгүй гэж үү?** /Иеремиа 18:6б/ ваарчин амархан эвдэрч хагарах ваар хийхээр төлөвлөөгүйн адил Бурхан ч мөн адил. **“Харин ч Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсэхгүй...”** /2Петр 3:9б/.

Өөрсдийгөө Түүний гарт өгсөн хүмүүст бидний Бүтээгч /ваарчин/ Бурхан өөрийн нигүүслийг харуулдаг. Бид өөрсдийгөө засаж янзалж чадахгүй билээ. **5Хэрэв хүн өөрийн гэрийг хэрхэн захирахыг мэдэхгүй бол яаж Бурханы чуулганыг халамжлах билээ?** /1Тимот 3:5/. Хэрэв ваар гэмтэж түүнийг өөр ваар болгон засахыг ваарчиндаа зөвшөөрөхгүй бол түүнийг сүйрэл хүлээх болно. Гэвч Бурханы “ирээрэй” гэсэн дуудлагыг хүлээн авсан бүх хүмүүст зориулсан гайхамшигтай төлөвлөгөө Түүнд бий. **17Сүнс болон сүйт бүсгүй**

-Ирээрэй гэнэ. Сонсогч нь

-Ирээрэй гэж хэлэг. Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг. /Илчлэлт 22:17/, **4Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор сонгосончлон, хайраараа 5Тэр Өөрийн хүслийн сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр Өөрийнхөө хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоожээ.** /Ефес1:4-5/, **19Би өнөөдөр тэнгэр газрыг дуудаж та нарт гэрч болгон, чиний өмнө амь ба үхэл, ерөөл ба хараалыг тавья. Чи болон чиний үр удам амьдрахын тулд амийг сонгож,** /Дэд хууль 30:19/. Есүс дотор Амь бий.

Таныг багтаах Бурханы нигүүсэл дэндүү их хангалттай.

13Учир нь “Эзний нэрээр дуудах хэн ч аврагдах болно”. /Ром 10:13б/, Хэн нэгэн Бурханы дуудлагыг хүлээн аваад, Түүний нигүүлсэлд орох нь тухайн хүн дахин шинээр төрсөн мэт болдог.

Есүс хэлэхдээ ²³ **-Хэрэв хэн нэгэн Миний араас явахыг хүсвэл, тэр хүн өөрийгөө үгүйсгэж, өдөр бүр загалмайгаа үүрч Намайг дага 25Хэрэв хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал юуны ашиг байх билээ?** /Лук 9:23б, 25/

ХИЧЭЭЛ 21 БУРХАН ИЗРАИЛИЙГ ӨӨРӨӨСӨӨ ХОЛДУУЛСАН НЬ

Ром 9:30-33

³⁰Тэгвэл бид юу хэлэх вэ?

Зөвт байдлыг мөшгөөгүй харь үндэстнүүд зөвт байдалд, бүр итгэлээр ирдэг зөвт байдалд хүрсэн. ³¹Харин зөвт байдлын хуулийг мөшгөн, Израиль нь тэр хуульд хүрсэнгүй. ³²Яагаад? Яагаад гэвэл тэд түүнийг итгэлээр мөшгөсөнгүй, харин үйлсээр ирдэг юм шиг мөшгөжээ. Тэд бүдрүүлэх чулуунд бүдэрцгээжээ. ³³Энэ нь

“Харагтун, Би Сионд бүдрүүлэх чулуу,

Зөрчилд хүргэх хад тавина.

Түүнд итгэгч нь ичгэвтэр байдалд орохгүй”

Ром 10:1-21

¹Ах дүү нар аа, миний зүрх сэтгэлийн хүсэл болон тэдний төлөө Бурханд хандах миний залбирал нь тэдний аврал билээ. ²Тэд Бурханы төлөө хичээл зүтгэлтэй боловч, энэ нь мэдлэгийн дагуу биш хэмээн би тэднийг гэрчилдэг. ³Учир нь Бурханы зөвт байдлыг мэдэлгүй, өөрсдийнхийгөө тогтоохыг эрмэлзэн тэд Бурханы зөвт байдалд үл захирагдав. ⁴Учир нь итгэдэг хүн бүрд зөвт байдлын төлөө Христ бол

хуулийн төгсгөл мөн. ⁵Учир нь хуулиас ирдэг зөвт байдлыг хэрэгжүүлдэг хүн тэрхүү зөвт байдлаар амьдарна гэж Мосе бичжээ. ⁶Харин итгэлээс ирдэг зөвт байдал нь ийнхүү ярьдаг. “Зүрхэн дотроо “Хэн тэнгэрт гарах вэ?” гэж бүү хэл” (Энэ нь Христийг доош авчрахын тулд юм) ⁷Эсвэл “”Хэн ёроолгүй гүнд буух вэ?” гэж бүү хэл”. (Энэ нь Христийг үхэгсдээс босгохын тулд юм) ⁸Харин энэ нь юу хэлдэг вэ? “Үг нь чамд ойр байна. Чиний аманд, чиний зүрх сэтгэлд бий” гэдэг. Энэ нь бидний тунхаглаж буй итгэлийн үг юм. ⁹Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. ¹⁰Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ. ¹¹Учир нь Судар “Түүнд итгэгч нь ичгэвтэр байдалд орохгүй” гэдэг. ¹²Иудей болон грек хүний хооронд ялгаа байхгүй. Бүгдийн Эзэн нэг л бөгөөд Түүнийг дуудагч бүгдэд баялаг бялхана. ¹³Учир нь “Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно”. ¹⁴Тэгвэл Түүнд итгээгүй тэд яаж Түүнийг дуудах вэ? Түүнийг сонсоогүй

тэд яаж Түүнд итгэх вэ? Тэд номлогчгүйгээр яаж сонсох вэ? ¹⁵Илгээгдэхээс нааш тэд яаж номлох вэ? “Сайн мэдээг тунхаглагчдын хөл юутай сайхан!” гэж бичигдсэн байдаг.

¹⁶Харин тэд сайн мэдээнд итгэсэнгүй. Учир нь Исаиа “Эзэн, бидний мэдээнд хэн итгэсэн бэ?” гэж хэлсэн. ¹⁷Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг. ¹⁸Гэвч би хэлье. Тэд хэзээ ч сонсоогүй гэж үү? Үнэндээ тэд сонссон.

“Тэдний дуу хоолой бүх газарт,

Тэдний үгс дэлхийн зах хязгаарт ч хүрсэн” ¹⁹Гэвч би хэлье. Израиль үнэндээ мэдээгүй юу? Эхлээд Мосе

“Би үндэстэн биш хүмүүсээр та нарыг атаархуулж, ухаангүй үндэстнээр уурлуулна” ²⁰Исаиа зоригтойгоор

“Намайг хайгаагүй хүмүүс Намайг олсон.

Намайг сураглаагүй хүмүүст Би илэрхий болсон”

²¹Харин Израилийн талаар Тэр “Бүхэл өдөржин Би дуулгаваргүй, зөрүүд ард түмэнд гараа сунгасан” гэжээ.

Хийх зүйлс:

Ром номны 10-р бүлгээс гүйцээж бичээрэй.

1. Зөвт байдал нь итгэлээр ирдэг бөгөөд Христийг маш холоос хайх хэрэггүй байдаг. /10:6-7/ “Үг нь чамд _____ байна, чиний _____, чиний _____ бий” гэдэг. /10:8/

/"Тэр бид бүхний хэнээс нь ч холгүй"/Үйлс 17:276/, **18ЭЗЭН Өөрийг нь дуудагч бүхэнд,**

Өөрийг нь үнэнээр дуудагч бүхэнд ойр байдаг.

/Дуулал 145:18/, **18ЭЗЭН эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг бөгөөд**

Сүнсээрээ гэмшигчдийг авардаг. /Дуулал 34:18//.

2. Та хэнийг амаараа хүлээн зөвшөөрөх ёстой вэ? _____ /10:9/

3. Зүрх сэтгэлдээ юунд итгэх ёстой вэ? “Бурхан Түүнийг _____ гэдэгт итгэх /10:9/.

4. Хүн зүрхэндээ юуг хийх хэрэгтэй вэ? _____ хүрнэ. /10:10/

5. Хүн амаараа яах хэрэгтэй вэ? _____ хүрнэ. /10:10/.

6. Хэн аврагдах вэ? “Эзэний _____ хэн ч аврагдана. /10:13/.

7. Итгэл нь хэрхэн ярьдаг вэ?” _____ /10:17/. Сонсох нь хэрхэн ирдэг вэ?” Бурханы _____ /10:17/.

Бурханы зөвт байдал

Есүсийн амьдарч байсан тухайн үед шашинлаг Иудейчүүд болох Фарисайчууд Бурханы бүх хуулийг хатуу чанга сахих ёстой гэж үздэг байв. **20Би та нарт хэлье, хэрэв та нарын зөвт байдал чинь фарисайчууд болон хуулийн багш нараас илүү гарахгүй л бол, та нар тэнгэрийн хаанчлалд орохгүй.** /Матай 5:20/. Хатуу чанга Фарисайчуудын зөвт байдал ч гэсэн Бурханы хувьд хангалттай байгаагүй.

Мосед өгөгдсөн хуулиудад **“Чи хүн бүү ал, Чи бүү завхайр” гэсэн байдаг.** /Египетээс гарсан нь 20:13-14/. Эдгээр нь гадна талын үйлс юм. Есүс зөвт байдал гэж зүрх сэтгэлийн дотоод сонирхлын талаар хэлсэн. Бүр шалтгаангүйгээр зүрх сэтгэлдээ хэн нэгэнд уурлах эсвэл хэн нэгнийг мунхаг хэмээн хэлсэн хэн боловч шүүхийн өмнө буруутай гэдгийг Есүс заасан байна.

Бурханы зөвт байдал хамгийн түрүүнд таны ыдотор байх ёстой. **27Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар бол цагаанаар будсан булшнууд шиг гаднаа гоё сайхан харагддаг хэдий ч дотроо үхэгсдийн яс болоод бузар бүхнээр дүүрэн аж.** **28Та нар ч гэсэн хүмүүсийн өмнө гаднаа зөвт хүмүүс мэт харагдавч, дотроо хоёр нүүрт зан болон хууль бус явдлаар дүүрэн аж.** /Матай 23:27-28/. Бурханы зөвт байдлын хэмжүүр нь маш өндөр учраас Бурхан Өөрийн зөвт байдлаа түүнд өгөлгүйгээр хэн ч үүнд нь хүрч чадахгүй юм. Тэр Есүсийг махан биеэр бидний дунд амьдруулахаар илгээхдээ Түүнийг бүхэлдээ зөвт амьдралаар амьдрахыг тушааж илгээсэн юм. **6Бид бүгдээрээ бузар нэгэн мэт болсон бөгөөд бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт байдаг....** /Исаиа 64:6a/. Бид өөрсдийн хүчээр зөвт амьдарч чадахгүй харин даруу байж гэмтэй гэдгээ ухааран, гэмт хуучин амьдралдаа үхэж, /Христ бидний оронд цовдлогдсон/ Есүсийн өгөх шинэ амьдралд Түүний хүчээр амьд гэдгээ таньж мэдэх хэрэгтэй. **9Хуулиас гардаг өөрийнхөө зөвт байдалтай биш, харин Христэд итгэх итгэлээр ирдэг, итгэлийн үндсэн дээр Бурханаас ирдэг зөвт байдалтай Түүний дотор би олдохын тулд юм.** /Филлиппой 3:9/.

Бурхан яагаад Израилийг Өөрөөсөө холдуулах болсон бэ?

Есүсийг ирэхэд Израильчууд өөрсдийн хүчээр, махан биеэр Бурханы хуулийг дагахын тулд хичээцгээж маш завгүй байлаа. /1Коринт 1:30/.

Бурхан Израилийг дэлхий ертөнцөд Өөрийн ивээлээ дамжуулах суваг болгон сонгосон юм. Гэвч тэд Есүсийг амлагдсан Аврагч хэмээн хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тул Бурхан тэднийг энэ сайн мэдээг дэлхийд хуваалцуулахын тулд ашиглаж чадаагүй юм. Хосеагийн эш үзүүлснээр Бурхан Өөрт нь итгэгч Харь үндэстнийг Өөрийн ард түмэн болгон сонгосон. Миний ард түмэн байгаагүй хүмүүст **“Та нар Миний ард түмэн” хэмээх бөгөөд тэд “Та бол миний Бурхан” хэмээх болно**. /Хосеа 2:23б/

Есүс нэгэн сургаалт зүйрлэл айлдав. Нэгэн газрын эзэн усан үзэм авчруулахаар боолуудаа усан үзмийн талбай руугаа илгээжээ. Гэвч түрээслэсэн усан үзмийн тариаланчид боолуудыг нь алж байлаа. Эцэст нь тэрээр хүүг минь хүндлэнэ гээд хүүгээ илгээв. Гэвч тэд өвийг нь өөрсдөө авахын тулд түүнийг бас алж орхив. Эцэст нь тэр өөрөө очиж тэднийг бүгдийг устагаад газараа өөр хүмүүст түрээслүүлсэн. /Матай 21:33-39/. Есүс хэлэхдээ ⁴³**Иймээс Би та нарт хэлье. Бурханы хаанчлалыг та нараас авч, түүний үр жимсийг нь ургуулах үндэстэнд өгөх болно.** /Матай 21:43/. Бид дараагийн хичээлдээ Бурхан нигүүсэнгүй байсан учраас Израилийг бүр мөсөн Өөрөөсөө холдуулаагүй талаар үзэх болно.

ХИЧЭЭЛ 22 ИЗРАИЛЬ АВРАГДАХ БОЛНО

Ром 11:1-32

¹Тэгвэл би хэлье. Бурхан Өөрийн ард түмнээ голсон гэж үү? Бүү ийм байх болтугай! Учир нь би бас Абрахамын үр удам, Бениамин овгийн Израиль хүн. ²Бурхан урьдаас мэдсэн Өөрийн ард түмнээ голоогүй. Эсвэл та нар Елиагийн тухай Сударт юу хэлдгийг мэддэггүй юм уу? Тэр Израилийн эсрэг Бурханд мэдүүлэн, ³"Эзэн, тэд Таны эш үзүүлэгчдийг алсан. Тэд Таны тахилын ширээнүүдийг нураан хаясан. Би ганцаараа үлдсэн бөгөөд тэд амийг минь хайж байна" гэсэн. ⁴Харин Бурханы хариу юу байв? "Баалд өвдөг сөгдөөгүй долоон мянган эрийг Би Өөртөө үлдээсэн" гэсэн юм. ⁵Үүний адил Бурханы нигүүлсэнгүй сонголтын дагуу үлдэгсэд эдүгээ цагт ч байгаа. ⁶Хэрэв энэ нь нигүүлслээр юм бол, цаашид үйлсээр биш ажээ. Эс тэгвэл нигүүлсэл нь нигүүлсэл биш болно. ⁷Тэгвэл юу болох вэ? Израиль эрснээ олж авсангүй. Харин сонгогдогсод нь үүнийг олж авав. Үлдсэнийг нь хатууруулжээ. ⁸Энэ нь

"Бурхан тэдэнд энэ өдрийг хүртэл мэдрэхгүй сүнс,

Харахгүй нүд, сонсохгүй

чих өгсөн" ⁹Давид

"Тэдний ширээ нь тэдэнд урхи, тор,

Бүдрүүлэх саад болон шан хариу болог.

¹⁰Харахгүйн тулд тэдний нүд харанхуйлж,

Нуруу нь үүрд бөгтөр болог" ¹¹Тиймд би хэлье. Тэд бүр унахаар бүдэрсэн гэж үү? Бүү ийм байх болтугай! Харин Израилийн атаархлыг төрүүлэхийн тулд тэдний алдаа зөрчлөөс болж харь үндэстнүүдэд аврал өгөгдөв.

¹²Хэрэв тэдний хилэнц нь дэлхийн баялаг болж, тэдний алдаа нь харь үндэстнүүдийн баялаг болдог юм бол тэдний дүүрэн байдал ямар их илүү байх бол! ¹³Гэвч харь үндэстэн та нарт би хэлье. Би харь үндэстнүүдийн элч тул өөрийн үйл хэргийг томруулдаг нь ¹⁴махан биеэрээ миний ах дүүс бологсдын атаархлыг хөдөлгөж, заримыг нь аврахын тулд юм. ¹⁵Учир нь хэрэв тэдний голсон явдал нь дэлхийн эвлэрэл бол тэдний хүлээн авалт нь үхэгсдээс амилуулах явдлаас өөр юу байх билээ? ¹⁶Хэрэв эхний үр ариун бол бөөндөө мөн тийм байна. Хэрэв үндэс ариун бол мөчрүүд мөн тийм байна.

¹⁷Харин хэрэв хэсэг мөчир тастагдаад зэрлэг чидун болох та, тэдний дунд залгагдаж, чидун модны үндэсний шимээс хүртэгч болсон бол, ¹⁸өнөөх мөчрүүдийн эсрэг бүү сайрх. Хэрэв та сайрхах аваас та үндсийг тэтгэж байгаа юм биш, харин үндэс таныг тэтгэж байгааг санагтун. ¹⁹Тэгээд та “Намайг модонд залгуулахын тулд тэр мөчрүүд тастагдсан шүү дээ” гэж хэлэх болно. ²⁰Тийм ээ, тэд итгэлгүйгээс болж тастагдсан. Харин та итгэлээрээ зогсож байна. Бүү ихэмсэг бай, харин эмээгтүн. ²¹Хэрэв Бурхан байгалийн мөчрүүдийг хэлтрүүлээгүй бол таныг ч гэсэн хэлтрүүлэхгүй. ²²Тиймээс Бурханы энэрэл хийгээд хатуу байдлыг харагтун. Унасан хүмүүсийн дээр хатуу байдал нь, харин таны дээр Бурханы энэрэл нь, хэрэв та Түүний энэрэл дотор цаашид байх аваас, байна. Эс бөгөөс та ч гэсэн тастагдах болно. ²³Мөн хэрэв тэд итгэлгүй байдалдаа цаашид байхгүй бол бас л залгагдах болно. Учир нь Бурхан тэднийг дахин залгах чадалтай. ²⁴Хэрэв та зэрлэг чидуны модноос тастагдсан бөгөөд чанарынх нь эсрэг таримал чидун модонд залгагдсан юм бол, тэгэх тусмаа байгалийнх

нь байгалийнхаа модонд залгагдах биш үү?

²⁵Ах дүү нар аа! Та нарыг өөрсдийнхөө бодлоор мэргэн болчих вий гэсэндээ энэ нууцыг та нар мэдэлгүй өнгөрөхийг би хүсэхгүй байна. Харь үндэстнүүд дүүрэн орох хүртэл Израилийн хэсэг хатуу сэтгэлтэй болсон нь энэхүү нууц билээ. ²⁶Ийнхүү бүх Израиль аврагдах болно. Энэ нь ийн бичигдсэн юм.

“Чөлөөлөгч Сионоос гарч ирнэ. Тэр Иаковаас бурханлаг бус байдлыг нь зайлуулна.

²⁷Би тэдний нүглүүдийг зайлуулах үед Энэ нь тэдэнтэй байгуулах Миний гэрээ мөн”.

²⁸Сайн мэдээний талаас, тэд та нарын төлөөх дайснууд боловч, харин сонголтын талаас, тэд эцгүүдийн төлөө хайрлагдагсад юм. ²⁹Учир нь Бурханы бэлгүүд ба дуудлага нь буцалтгүй ажээ. ³⁰Учир нь та нар урьд өмнө Бурханд дуулгаваргүй байсан боловч одоо тэдний дуулгаваргүй байдлаас болж та нар өршөөл үзсэнчлэн, ³¹мөн та нарт үзүүлсэн өршөөлийн улмаас тэд өршөөгдөхийн тулд эдүгээ тэд дуулгаваргүй байгаа юм. ³²Учир нь бүгдэд өршөөлөө үзүүлэхийн тулд Бурхан бүх хүнийг дуулгаваргүй байдал дотор хорьжээ.

Сохор гэдэг нь Бурханаас ирэх шийтгэл юм.

Маш олон Еврейчууд он цаг өнгөрөх тусам Бурханы амлалтууд болон Түүнд итгэх болсон. Тэдгээрийг Бурханы хүмүүс буюу Израилийн “хэсэг” гэж дууддаг. Гэхдээ хүмүүс Бурханыг сонсохыг хүсэхээ больсноор Бурхан тэдэнд үнэнд сохрохыг зөвшөөрсөн. Энэ зүйл Израиль үндэстэнд тохиолдсон юм. ¹⁰Учир нь ЭЗЭН та нарын дээр гүн нойрны сүнсийг цутгаж, /Исаиа 29:10a/. ¹⁴Тийм хүмүүс дээр Исаиагийн эш үзүүллэг биелдэг юм. Юу гэвэл тэр

“Та нар сонссоор, сонссоор байтал огт ухаарахгүй, харсаар, харсаар байтал огт ойлгохгүй. /Матай 13:14/, ¹⁴Харин тэдний ухаан санаа хатуурсан ажээ. Тэгээд яг энэ өдрийг хүртэл хуучин гэрээг уншихад нь ч өнөөх бүтээлэг авагдалгүй үлджээ. ¹⁶Гэвч хүн Эзэнд хандаж эргэх бүрд бүтээлэг авагддаг. /2Коринт 3:14а, 16/. Христэд хандсан тэд Бурханаас гарах үнэний Сүнс буюу Туслагчийг хүлээн авах болно. Үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. /Иохан 15:26, 16:13/. ¹⁸Загалмайн үг нь мөхөгсдийн хувьд мунхаг явдал боловч аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн. /1Коринт 1:18/.

Чидун жимсний мод

Бурхан Израилийг үүрд мөнх орхиогүй гэдгийг чидун модны жишээгээр харуулдаг. Израилийн ард түмэн бол Эзэний тарьсан чидун модны мөчрүүд байлаа. ¹⁶ЭЗЭН нэрийг чинь “Үзэсгэлэнт хэлбэртэй, жимстэй ногоон чидун мод” гэж дуудав.

Их нүжигнэсэн дуу чимээгээр Тэрээр түүн дээр гал ноцоов.

Тэгээд түүний мөчрүүд хэрэггүй болжээ. /Иеремиа 11:16/. Чидун мод Бурханы ариун газарт олон зүйлийг бүтээжээ. /Хаадын дээд 6:23, 32/. Дэнлүүг үргэлжид асааж байхын тулд гэрэлтүүлгэнд зориулсан чидун жимснээс шахсан цэвэр тос мөн майхан хийгээд ариун авдрыг тослох тосыг хийдэг байна. /Египетээс гарсан нь 27:20, 30:22-32/.

Чидун жимсний мод тарихад их хугацаа, хөдөлмөр шаардагддаг. Модыг байнга сэргээж босгохын тулд мөчир залгадаг бөгөөд хэрэв мөчрүүд нь цааш ургахааргүй бол тайрч өөр модны мөчрүүдийг залгадаг. Ийм ажлыг Бурхан хийдэг юм. Өөрийн жинхэнэ мөчир /Израиль/ тайрч хаягдан мөчир бүхий харь үндэстнүүд залгагдсан. Ингэж холилдон Израиль Бурханд эргэж ирсэн юм. ¹³Харин урьд нь алс хол байсан та нар эдүгээ Христ Есүс дотор Христийн цусаар

ойр болов. /Ефес 2:13/, ¹⁴Энэ нь Христ Есүс дотор Абрахамын ерөөлийг Харь үндэстнүүдэд ирүүлэхийн тулд юм. Ингэснээр бид итгэлээрээ Сүнсний амлалтыг хүлээн авах юм. /Галат 3:14/.

Бурхан Өөрийн нигүүлслээ харуулан Израилийг сэргээн босгох болно.

Сайн мэдээний талаас Израиль үндэстэн дайснууд боловч эцгүүдийн төлөө хайрлагдагсад юм. /Ром 11:28-29/. Бурхан Израилийн ард түмнийг буцааж авах болно гэж амласан юм. /Исаиа 11:11-16, 12:1-26, 59:20-21, Иереима 23:3, 31:1, 31:10-12, Езекиел 11:16-20, Зехариа 8:10-23/.

¹⁶Тиймээс “Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. “Би тэднийг алс хол, үндэстнүүдийн дунд шилжүүлж, улсуудын дунд тараасан, ...тараагдсан улсууд дотроос та нарыг буцаан авчрах бөгөөд Израилийн газрыг Би та нарт өгнө”. /Езекиел 11:16а, 17б/,
⁸Учир нь Тэр тэднээс гэм зэм олоод

“Харагтун, Би Израилийн гэр ба Иудагийн гэртэй Шинэ гэрээ байгуулах өдрүүд ирж байна” гэж Эзэн айлдаж байна, Би Өөрийн хуулиудыг тэдний ухаан санаанд оруулж, Би тэдний зүрхэнд бичнэ.

Би тэдний Бурхан болж, тэд Миний ард түмэн болно.

¹²Яагаад гэвэл Би тэдний гэм бурууд өршөөнгүй хандана.

Би цаашид тэдний нүглүүдийг дурсахгүй” /Еврей 8:8, 10б, 12/.

Бурханы зорилго бол Еврей болон харь үндэстнүүдийг Христ дотор нэгтгэх явдал юм. ¹⁶тэднийг аль алийг нь нэг бие дотор загалмайгаар дамжуулан Бурхантай эвлэрэх боломжтой болгов. Үүгээр дайсагналыг хөнөөв. /Ефес 2:16/.

ХИЧЭЭЛ 23 ХРИСТЭЧ ХҮМҮҮСИЙН ҮР ЖИМСТЭЙ БАЙХЫН УЧИР

Ром 11:33-36

³³Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь ямар гүн гүнзгий вэ! Түүний шүүлтүүд нь ямар ухаарагдашгүй, Түүний замууд нь ямар олж илрүүлшгүй вэ? ³⁴Учир нь хэн Эзэний оюун ухааныг мэдсэн бэ? Хэн Түүний зөвлөгч нь болсон бэ? ³⁵Эсвэл энэ нь өөртөө эргүүлж төлүүлэхийн тулд хэн Түүнд урьдчилж өгсөн бэ? ³⁶Учир нь Түүнээс, Түүгээр, Түүнд бүх юм байна. Түүнд алдар нь үүрд байх болтугай. Амен.

Ром 12:1-2

¹Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн. ²Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун.

Бидний гайхамшигт Бурханд хариулах нь

Бурханы нигүүслийн талаарх сайн мэдээгээ ярьж дуусгахдаа Паул Бурханыг магтаж Түүний сүр жавхланд мөргөдөг. **“⁹Тэрээр агуу, ухааршгүй зүйлсийг болон тоо томшгүй гайхамшгуудыг үйлддэг юм.”** /Иов 5:9/. Бурханы агуу нигүүслийн гэрэл дотор христэд итгэдэг хүмүүс амьд байгаадаа талархаж Бурханд өөрсдийн биеийг ариун өргөл болгон өргөх ёстой.

Хэрэв таны хуучин амьдрал үхсэн (христтэй хамт цовдлогдсон) ба дахин амилсан Есүсийн амьдрал таны дотор амьдарч байгаа бол тэр биеэ Бурханд зориулах нь чухал юм.

Та үүнийг одоо хийх үү? Жишээлбэл Түүнд алдар магтаал өргө, Түүний хайрын тухай бусдад ярь, Түүний хүссэн зүйлийг харахын тулд Түүнд нүдээ өг, Түүний хүссэн зүйлийг хийхийн тулд гараа өг, Түүний хүссэн газар луу явахын тулд Түүнд хөлөө өргө **“²⁸Танай зарим яруу найрагчдын “Бид бас Түүний үр удам” гэж хэлсэнчлэн, бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог.”** (үйлс 17:28)

Энэ дэлхий ертөнцтэй бүү адил бай

Бид бол энэ дэлхий ертөнцтэй адилгүй болсон билээ. Энэ

ертөнцийн бодож, ярьж, үйлддэг шиг байж болохгүй. “¹⁵Есүс бол Бурханы Хүү гэж хүлээн зөвшөөрдөг хэний ч дотор Бурхан байж, тэр Бурханы дотор байна. ¹⁶Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж, итгэдэг.

Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна. ¹⁷Үүгээр шүүлтийн өдөрт биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг.” (1 Иохан 2:15-17) “Тэгэхлээр ертөнцийн найз байхыг хүссэн хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм.” (Иаков 4:4б) Энэ нь нүгэлтэнгүүдтэй бүү найзла гэсэн үг биш. Есүс Өөрөө нүгэлт хүмүүсийн найз нь байсан юм. (Лук 19:1-7) Гэвч та тэдгээр хүмүүс шиг байх ёсгүй.

Өөрчлөлтийн төлөөх дуудлага

Дэлхийтэй адил байхын оронд бид, Бурханаар өөрчлөгдсөн буюу цоо шинэ хүн болох ёстой. Энэ нь “хэлбэрээ өөрчилнө” гэсэн үг юм. Дахин төрсөн Христэч хүн өөрийгөө таньж хуучин ертөнцөө орхино. “Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн байж, ¹⁹дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар нэг нэгэнтэйгээ ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохиогтун. ²⁰Бурхан болон Эцэгт бүхний төлөө бидний Эзэн Есүс Христийн нэрээр үргэлж талархал өргө. ²¹Христээс эмээн нэг нэгэндээ захирагд.”

(Ефес 5:18б-21)

Оюун санаагаа шинэчил

Бид үргэлж оюун санаагаа шинэчилснээр бүр мөсөн өөрчлөгдсөн. Учир нь бид юуны тухай бодно тэр нь бидний хэрхэн ярих болон үйлдэхэд нөлөөлдөг. “⁷Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм.” (Сургаалт үгс 23:7а) “²³оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж,” (Ефес 4:23) “⁴Та нар оюун ухаанаа газар дахь зүйлс дээр биш, харин дээгүүрх зүйлс дээр төвлөрүүл. ³Учир нь та нар үхсэн бөгөөд та нарын амь Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан. ⁴Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүний хамт илчлэгдэх болно.” (Колоссай 3:23)

Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхсон.

“Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарын хуваалцагч болох юм.” (2 Петр 1:46). Бид Бурханы үг болон Түүний агуу хайрын талаар дотроо тунгаан бодож болно.

“Юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахын тулд бид бүгдээрээ Христийн шүүхийн суудлын өмнө гарч ирэх ёстой.” (2 Коринт 10:56).

Оюун санаагаа Есүс дээр төвлөрүүл. Библийн дагуу Түүнийг тань.

“³Өөрийнхөө алдар ба давуу чанараар биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний бурханлаг хүч бидэнд амь болоод сүсэглэлд хамаатай бүхнийг соёрхсон.”(2 Петр 1:3а). Есүсийн талаарх мэдлэг дотроо бид өсч хуучин хүнээ тайлж шинэ хүнийг өмссөн. **“Энэ нь өөрийг нь бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу үнэн мэдлэгт шинэчлэгдсэн хүн юм.”** (Колоссай 3:10б). Зүх сэтгэл дотроо бүтэн өдрийн турш чанга дуугаар Бурхантай ярилц.

“³Танд итгэдэг учраас бодол санаагаар бат зогсогч хүнийг Та төгс амар тайван дотор хамгаална.” (Исаиа 26:3). **“⁷Учир нь унтагсад шөнө унтдаг, согтуурагчид шөнө согтдог.”** (1 Тесалоник 5:17)

“⁸Эцэст нь, ах дүү нар аа, юу нь үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь зөв, юу нь цэвэр ариун, юу нь сайхан, юу нь сайшаалтай байна, хэрэв аливаа сайн үйл байгаа бол, хэрэв магтууштай ямар нэгэн юм байгаа бол тэдгээр юмсыг бодож санацгаа.” (Филиппой 4:8). Есүсийн дүр төрх бүхий Ариун Сүнсээр бид бүхэн оюун санаагаа шинэчилж бүр мөсөн өөрчлөгдсөнөөр бид Бурханы хүсэл ямар төгс сайхан бэ гэдгийг ойлгох болно.

ХИЧЭЭЛ 24 ХРИСТЧ ХҮН БҮР ХРИСТИЙН БИЕЙН НЭГЭН ХЭСЭГ ЮМ

Ром 12:3-21

³Учир нь надад өгөгдсөн нигүүлслээр би та нарын дунд буй хүн бүрд хэлье. Өөрийнхөө талаар бодох ёстойгоосоо илүү дээгүүр бүү бод. Харин Бурханы хүн бүрд ногдуулсан итгэлийн хэмжээний дагуу эрүүл ухаанаар бод. ⁴Нэг биед олон эрхтэн байдгийн адил, мөн бүх эрхтэнд ижил үйл ажиллагаа байдаггүйн адил, ⁵бид олуулаа Христ дотор нэг бие болой. Харин хүн бүр нэг нэгэндээ эрхтэн юм. ⁶Бидэнд өгөгдсөн нигүүлслийн дагуу бид өөр өөр бэлгүүдтэй тул хэрэв эш үзүүлбэл, энэ нь тэр хүний итгэлийн дагуу аж. ⁷Хэрэв үйлчлэл бол тэр хүн үйлчлэлээ, сургаж байгаа бол сургаалаа, ⁸ятгадаг хүн бол ятгалга, өгч байгаа бол чин сэтгэлээр, тэргүүлж байгаа хүн бол хичээл зүтгэлээр, өршөөл үзүүлж байгаа бол баяртайгаар хийгтүн.

⁹Хайр нь хоёр нүүргүй байг. Бузар мууг жигш, сайнаас зуурч ав. ¹⁰Ах дүүсийн хайраар бие биеэ хайрла. Бие биеэ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл. ¹¹Хичээл зүтгэлд бүү хойрго бай. Эзэнд үйлчлэн сүнс дотор шат. ¹²Найдвар дотор баярла, зовлон дотор

тэвчээртэй бай, залбиралд өөрсдийгөө зориул, ¹³ариун хүмүүсийн хэрэгцээнд хандив өргө, зочломтгой бай. ¹⁴Та нарыг хавчигч хүмүүсийг ерөө. Ерөө, харин бүү хараа. ¹⁵Баяр хөөр болж буй хүмүүстэй хамт баярла, уйлж буй хүмүүстэй хамт уйл. ¹⁶Өөр хоорондоо нэг санаатай байцгаа. Ухаан бодолдоо ч бүү ихэрх. Харин төлөв даруу байхыг эрхэмлэ. Өөрөө өөрийгөө мэргэн бүү болго. ¹⁷Хэнд ч хэзээ ч бузар мууг бузар муугаар бүү хариул. Бүх хүний өмнө юу нь зөв болохыг л харгалзан үзэж бай. ¹⁸Хэрэв боломжтой бол, та нараас шалтгаалж байгаа бол бүх хүнтэй эвтэй байгтун. ¹⁹Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь “”Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө” гэж Эзэн айлдав” гэж бичигджээ. ²⁰”Хэрэв дайсан чинь өлссөн бол түүнийг хоолло. Хэрэв тэр цангасан бол түүнд уух юм өг. Учир нь чи ингэснээрээ түүний толгой дээр галтай нүүрс овоолж байгаа хэрэг”. ²¹Бузар муугаар бүү дийл, харин бузар мууг сайнаар дийлэгтүн. Бид бүхэн нэгэн биеийн эрхтнүүд юм.”(Ром 12:3-21). Христч

хүний амьдралыг харуулсан.

(Колоссай 2:196)

¹²Учир нь бие нэг атлаа олон эрхтэнтэй байдаг. Биеийн бүх эрхтнүүд нь хэдийгээр олон боловч нэг бие болдог мэт Христ ч мөн тийм болой. (1 Коринт 12:12).

Бурханы өсөлтөөр өсгөдөг Тэргүүнээс зуурдаггүй ажээ.

¹⁵Христийн амар тайван та нарын зүрх сэтгэлийг захираг. Үүний тулд л та нар нэгэн бие дотор дуудагдсан юм. Талархагтун. ²Ингэснээр тэдний зүрх хайрын дотор холбогдон, (Колоссай 3:15; 2:2a)

Христийн биед үйлчлэхийн тулд Сүнслэг билэг авъяас өгөгдсөн

Бурхан бидний биеийн бүхий л хэсгүүдийг хамтдаа ажиллаж байхаар гайхалтай сайхнаар бүтээсэн учраас Христ доторх хүн бүр Христийн биеийн хосгүй эрхтэнүүд юм. ¹⁷Хэрэв бүхэл бие нүд байсан бол сонсгол нь хаана байх байсан бэ? Хэрэв бүхэл бие сонсгол байсан бол үнэрлэх мэдрэмж нь хаана байх билээ? ¹⁸Харин эдүгээ Бурхан Өөрөө хүссэнчлэн эрхтэн тус бүрийг биед байрлуулжээ. ²¹Нүд “Чи надад хэрэггүй” гэж гарт хэлж чадахгүй. (1 Коринт 12:17 ; 18 ; 21a)

“Бэлгүүд нь ялгаатай боловч адилхан Сүнс. ⁵Үйлчлэлүүд нь ялгаатай боловч адилхан Эзэн. ⁶Үйлдлүүд нь ялгаатай боловч бүгдийн дотор бүх юмсыг үйлдэгч нь адилхан Бурхан юм. ⁷Нийтийн тусын тулд Сүнсний илрэлийг хүн тус бүрд өгсөн аж”. (1 Коринт 12:4-7).

Хэрэв та Христ дотор байвал таньд бэлэг өгөгдсөн байдаг.

¹⁴Чамд байгаа сүнслэг бэлгийг бүү үл хайхар (1 Тимот 4:14a). Бэлэгнүүд нь Христийн биеийг салгахын тулд бус харин босгон байгуулахын тулд өгөгдсөн юм. “Хүн бүр хүлээн авсан бэлгээрээ бие биедээ Бурханы олон төрлийн нигүүлслийн сайн нярвууд шиг үйлчил. Үйлчилдэг хүн нь Бурханаас тэтгэгддэг хүчээр үйлдэг. Тэгээд бүх зүйлд Есүс Христээр дамжуулан Бурхан алдаршуулагдах юм. Есүс Христэд алдар ба ноёрхол нь үеийн үед байх болтугай. Амен.” (1 Петр 4:10 ; 11б).

Сүнслэг бэлгүүд хайраас гарч ашиглагдах ёстой

Бурханаас ирсэн бэлэгнүүд үнэхээр гайхалтай, гэвч тэднийг хайр дотор ашиглах ёстой. “Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх

нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш” (1 Коринт 13: 2).

Есүс Матай 22:37-40-д хоёр тушаалын талаар айлдсан байдаг. Бид өөрсдөө эдгээр тушаалыг дагаж мөрдөж чадахгүй. Гэвч бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгасан үед чадна. (Ром 5:5)

4Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно. /Ром 8:4/. Учир нь бусдыг хайрладаг хүн хуулийг биелүүлсэн хэрэг. ¹⁰Хайр бол хөршдөө буруу зүйл үйлддэггүй. Иймд хайр нь хуулийн биелэлт мөн. (Ром 13:8б ;10).

ХИЧЭЭЛ 25 ХРИСТЧ ХҮНИЙ ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Ром 13:1-7

¹Дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд. Учир нь Бурханаар тогтоогдсоноос өөр эрх мэдэл гэж байхгүй. Оршин байгаа нь Бурханаар тогтоогдсон юм. ²Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэнхэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсдөдөө шийтгэл хүртэх болно. ³Учир нь сайныг үйлдэхэд захирагч нар нь айдас болдоггүй, харин бузар мууг үйлдэхэд айдас болдог. Та эрх мэдлээс айхгүй байхыг хүсэж байна уу? Сайныг үйлд. Та түүнээс магтаал хүртэх болно. ⁴Учир нь тэр танд сайны төлөөх Бурханы үйлчлэгч юм. Хэрэв та бузар

мууг үйлдвэл айтун. Учир нь тэр нь илд дэмий зүүгээгүй. Тэр бол бузар мууг үйлдэгч нэгэн дээр уур хилэнг буулгах өшөө авагч, Бурханы үйлчлэгч мөн. ⁵Тиймээс зөвхөн уур хилэнгийн улмаас бус, бас мөс чанарынхаа төлөө захирагдах хэрэгтэй. ⁶Ийм учраас та нар ч гэсэн татвар төлдөг. Учир нь захирагч нар Бурханы зарц нар бөгөөд энэхүү ажилд өөрсдийгөө зориулдаг юм. ⁷Бүгдэд өгөх ёстойгоо өг. Татвар авах ёстой хүнд татвараа, гаалийн татвар авах ёстой хүнд гаалийн татвараа төл, айж эмээвэл зохих хүнээс айж эмээ, хүндэтгэл хүлээх ёстой хүнийг хүндэл.

Хийх зүйлс

1. Паул ямар эрх мэдлийн жишээг ашиглаж байсан бэ? _____
_____ эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд (13:1)

2. Эрх мэдэл байх эсэхийг хэн шийдэх вэ? _____ /13:1)

3. Удирдагчдад зориулсан Бурханы зорилго юу вэ? “Сайныг үйлдэхэд захирагч нар нь _____ болддоггүй, харин _____ үйлдэхэд айдас болдог” (13:3). “Тэр нь илд _____ зүүгээгүй. “Тэр бол бузар мууг үйлдэгч нэгэн дээр _____ буулгах _____, Бурханы үйлчлэгч мөн” (13:4)

4. Бид яагаад захирагч нартаа захирагдах ёстой вэ? “Зөвхөн уур хилэнгийн улмаас бус, бас _____ төлөө захирагдах хэрэгтэй” (13:5)

“Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө хүний мөсөөр гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ”. (үйлс 24:166)

Бурхан эрх мэдлийг тогтоодог

Бурхан хэнийг ч сонгосон байсан эрх мэдлийг тогтоож өгдөг. Небухаднезар бол агуу хаан байсан. Бурхан түүнд **“Чи үхэр мэт өвс идэж, Хамгийн Дээд Нэгэн хүний хаанчлалыг захирч, Өөрийн хүссэн хүндээ түүнийг өгдгийг чи ойлгох хүртлээ энэ мэтээр долоон үеийг өнгөрөөх болно”** гэв. (Даниел 4:32б). **Есүсийг цовдуулахаар Пилат руу илгээх үед Есүс хэлсэн Танд дээрээс эрх мэдэл өгөгдөөгүй л бол, Миний эсрэг байх ямар ч эрх мэдэл баймааргүйсэн.** (Иохан 19:11а). Бурхан бүх эрх мэдэлтнүүдийг ариусгадаг. **1Хааны зүрх ЭЗЭНий мутарт атгаастай байгаа усны урсгал мэт юм.**

Тэр хүссэн цагтаа урсгалыг өөрчилдөг. (Сургаалт үгс 21:1).

Эрх мэдлийг эсэргүүцэх нь Бурханыг эсэргүүцсэнтэй адил

Есүс Христтэй хамт үр жимстэй амьдарна гэдэг нь эрх мэдэлд дуулгавартай байх явдал юм.

Яагаад? Учир нь эрх мэдэл нь Бурханаас ирдэг. Түүнийг эсэргүүцэх нь бурханыг эсэргүүцэж байгаатай адил. Энэ нь сатан болон зарим хуурамч бурхадаас ирдэг.

“Учир нь тэрслэх нь ид шидийн нүгэл адил,

захирагдахгүй байх нь гэм ба шүтээнд мөргөхтэй адил билээ. (Самуел 15:23а). Чуулган Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд. (Ефес 5:24) **1Хүүхдүүд ээ, [Эзэн дотор] эцэг эхээ дага. Учир нь энэ бол зөв юм.** (Ефес 6:1) **5Боолчууд аа, Христийг дагадгийн адил та нар**

эмээхүй болон чичрэлтээр чин сэтгэлээсээ махан биеийн дагуу эздэд дуулгавартай бай. (Ефес 6:5).

Эрх мэдэлтэй тэдгээр хүмүүс нь Бурханаар хүлээн зөвшөрөгдсөн юм.

Эрх мэдэлтэй бүх хүн Бурханаас тэдэнд өгөгдсөн давуу байдлаа хэрхэн ашигласанаар тэд хариуцлагаа хүлээнэ. Бусдыг хорлох замаар эрх мэдлийг хэрэгжүүлдэг хүн ч байдаг аж. (Номлогчийн үгс 8:9б). Тэдний бүх үйлдэл нь Бурханаар шүүгдэх болно.

Бурхан эцгүүдийг, нөхрүүдийг, ажил олгогчдыг зааж сургадаг.

“Эцгүүд ээ, та нар хүүхдүүдээ бүү уурлуул. Харин тэднийг Эзэний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүл.” (Ефес 6:4).

“Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла.” (Ефес 5:25).

“Эзэд ээ, үүний адил боолууддаа ханд. Тэдний болон та нарын Эзэн тэнгэрт байгааг болон Түүний ялгаварладаггүй болохыг ойлгон, айлгаж сүрдүүлэхээ боль.” (Ефес 6:9а)

Эрх мэдэл доторх тэдгээр зүйлд бид заавал захирагдах ёстой юу?

Эрх мэдэлтэй хэн нэгэн дээд эрх мэдэлтний эсрэг ямар нэгэн зүйл хийхийг таниас шаардаж болох юм. Хэрэв эцэг, нөхөр, ажил олгогч засгийн газрын хуулийн эсрэг эсвэл Бурханы хуулийн эсрэг таниар юм хийлгэх гэвэл та дээд эрх мэдэлд захирагдах ёстой болдог. Хэрэв засгийн газар Бурханы тухай хүүхдүүддээ ярихыг нь хоригловол эцэг эхчүүд Бурханыг дагаж Бурханд захирагдах ёстой. **Өнөөдөр миний чамд тушааж байгаа энэ үгсийг чи зүрхэндээ байлгаж, ¹хөвгүүддээ хичээнгүйлэн зааж, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, хэвтэж байхдаа ч, өндийн босохдоо ч түүний тухай ярьж бай.** (Дэд хууль 6:6-7). Хэрэв Бурханы тушаалуудын эсрэг биш бол тэд засгийн газрыг хүндэлж хуулинд захирагдах ёстой. Петр бичихдээ: “Харин та нар зөвт байдлын төлөө зовлон эдлэхэд хүрлээ ч, та нар ерөөлтэй. Тэдний сүрдүүлгээс бүү ай, бүү зов. ¹⁷**Хэрэв Бурхан таалах аваас та нар мууг үйлдсэнийхээ төлөө зовсноос зөвийг үйлдсэнийхээ төлөө зовсон нь дээр.** (1 Петр 3:14,17). Библид Даниелын тухай өгүүлэхдээ. Даниел хаанд болон хиймэл шүтээнд 30 өдрийн турш мөргөх хааны тушаалыг эсэргүүцсэн. Тиймээс Даниелыг өлсгөлөн арслангийн нүхэнд хаясан боловч Бурхан түүнийг хамгаалсан. **“Миний Бурхан тэнгэр элчээ**

илгээж, арслангуудын амыг тагласан бөгөөд арслангууд надад хор учруулсангүй. Харин ч би Түүний өмнө гэмгүйд тооцогдож, бас хаан минь, танд ямар ч гэм хийгээгүй гэв.” (Даниел 6:22б).

Есүсийн дагалдагч нарыг шоронд хорьж Есүсийн нэрээр сургаал заахгүй байхыг тэдэнд хатуу сануулсан.

²⁹Харин Петр болон бусад элч нар тэдэнд

-Бид хүнийг дагахаасаа илүү Бурханыг дагах ёстой. /Үйлс 5:29/. Тэд цаашид үргэлжлүүлэн заасаар байсан. Учир нь Есүс айлдахдаа: -Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. ¹⁹Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, ²⁰Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав. /Матай 28:18б-20/. Бид Бурханы үгийг дагаж Түүнийг таниж мэдэх үед Түүний эрх мэдэл бидэнтэй үргэлж хамт байх болно. Ингэснээр тэрхүү араатны хөрөг ярьж, араатны хөрөгт мөргөдөггүй бүх хүнийг алуулах юм. /Илчлэлт 13:15б/. Бид бүхэн Бурханы тушаалыг заавал санаж байх ёстой. ³Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй. /Египетээс гарсан нь 20:3/. Есүсийн айлдсан үгсийг санаж байх: биеийг хөнөөгсдөөс бүү ай. Хөнөөсний дараа тэд яаж ч чадахгүй. /Лук 12:4б/

Эрх мэдлийг захирах нь

Татвар, гаалийн татвар, зохистой хүндлэл нь эрх мэдлийн дагуу юм. Есүс өөрөө татвар төлж байсан юм. /Матай 17:24-27/. Цезарьт татвар төлөх нь зөв үү? гэж асуухад Тэр айлдахдаа: -Цезарийн юмыг Цезарьт нь, Бурханы юмыг Бурханд өг гэж айлдав. /Лук 20:25б/. Зарим зүйлс зөвхөн Бурханд хамаатай байдаг. Итгэгчид бидний хүндлэл энэ ертөнцөд хамаарагдахгүй. ²⁰Харин бидний иргэний харьяалал нь тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна. /Филлиппой 3:20/.

ХИЧЭЭЛ 26 ХРИСТЭЧ ХҮНИЙ ДЭЛХИЙТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Ром 13:8-14

⁸Нэг нэгэндээ хайртай байхаас өөр хэнд ч ямар ч өргүй бай. Учир нь бусдыг хайрладаг хүн хуулийг биелүүлсэн хэрэг. ⁹Учир нь “Бүү завхайр, бүү ал, бүү хулгай хий, бүү шунахайр” гэсэн тушаал болоод өөр ямар ч тушаал байна, энэ нь “Хөршөө өөрийн адил хайрла” гэсэн үгийн дотор агуулагддаг юм. ¹⁰Хайр бол хөршдөө буруу зүйл үйлддэггүй. Иймд хайр нь хуулийн биелэлт мөн.

¹¹Цаг үеийг, нойрноосоо сэрэх цаг хэдийнээ болжээ гэдгийг мэдэн үүнийг хий.

Учир нь урьд бидний итгэсэн үеэс аврал одоо бидэнд улам ойрхон байна. ¹²Шөнө өнгөрч, өдөр ойртов. Тиймээс харанхуйн үйлсийг хажуу тийш тавьж, гэрлийн зэвсгүүдийг агсацгаая. ¹³Утга учиргүй найрлан цэнгэж, архидах бус, садарлан, тачаадах бус, хэрэлдэн маргаж, атаархан жөтөөрхөх бус, харин өдөр буй мэт бүгдээрээ зүй зохистой явцгаая. ¹⁴Эзэн Есүс Христийг өөртөө өмс. Хүсэл тачаалынх нь талаар махан биеийг юугаар ч бүү ханга.

Хийх зүйлс:

1. Паулын иш татсан 5 тушаалыг нэрлэ. /13:9/

А. “Бүү _____”

Б. “Бүү _____”

В. “Бүү _____”

Г. “_____ бүү тэвч”

Д. “Бүү _____”

2. Эдгээр 5 тушаалыг ямар нэг тушаал багтааж байна вэ? “_____ өөрийн адил _____” /13:9/

3. Хуулийн биелэлт юу вэ? _____ /13:10/

Бидний цорын ганц өр

Паул итгэгч нарт хандаж: Та нар засаг захиргаанд татвар төлдөг. Тиймээс итгэгч хүмүүс нь бие биедээ хайртай байхаас өөрөөр хэнд ч бүү өртэй бай гэсэн. Есүс хэлэхдээ: ³⁴Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. /Иохан 13:34/. Бидний оронд үхүүлэхээр Есүсийг илгээснээр Бурхан Өөрийн агуу

уудам хайраа харуулсан юм. Ямар агуу хайрыг бид хүлээн аваа вэ?
¹¹Хайртууд минь, хэрэв Бурхан биднийг ийнхүү хайрласан бол бид ч бие биеэ хайрлах ёстой. ¹²Хэн ч, хэзээ ч Бурханыг хараагүй. Хэрэв бид бие биеэ хайрлавал, Бурхан бидний дотор байж, Түүний хайр бидний дотор бүрэн төгс болно.

¹³Тэр Өөрийнхөө Сүнсийг бидэнд өгсөн учир бид Түүний дотор, Тэр бидний дотор буйг бид үүгээр мэднэ. /1Иохан 4:11-13/.

Гэрлийн зэвсгээ агсацгаая

Есүс дахин ирэх гэж байна? Нойрноосоо сэрэх цаг болсон. Харанхуйд амьдарч байхдаа хийсэн бүх үйлсээ хажуу тийш нь тавьж “Гэрлийн зэвсэг”-ийг агсацгаая. Хуяг, зэвсэг бол хамгаалалт юм. Гэрэл бол харанхуйгаас хамгаалах хамгаалалт билээ. **Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав.** /Иохан 8:12/, ⁴⁶Надад итгэдэг хүн бүрийг харанхуйд байлгахгүйн тулд Би ертөнцөд гэрэл болон ирсэн. /Иохан 12:46/, ¹⁹Тэрхүү яллалт ийм билээ. Гэрэл ертөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм. /Иохан 3:19/. Гэрэл дотор алхах дуртай нь Есүс уруу очих болно. ¹⁴Та нар бол дэлхийн гэрэл мөн. /Матай 5:14a/.

Дэлхий ертөнцийн гэрэл болох Тэр бидний дотор амьдарвал бид мөн дэлхий дээр гэрэл болох болно. “Гэрлийн зэвсэгийг өмс гэдэг нь” Эзэн Есүс Христийг өөртөө өмс гэсэнтэй адил юм. Хэрэв Есүс бидний дотор амьдарвал гэрэл ч бас бидний дотор байх болно. ⁶Хэрэв бид Бурхантай нөхөрлөдөг гэж яриад, харанхуй дотор алхаж байвал бид худал хэлж, үнэнийг үйлддэггүй ажээ /1Иохан 1:6/. Бид гэрэл дотор алхаж байхад Есүс бидний гэм нүглийг ухааруулж Түүгээр дамжуулан чөлөөлөгдөнө. Ингэснээр үргэлжийн Түүнтэй хамт гэрэл дотор алхах болно. ⁷Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг ажээ. /1Иохан 1:7/.

²⁷Христ уруу баптисм хүртсэн та нар бүгдээрээ Христ уруу Христийг өмссөн юм /Галат 3:27/. Өглөө бүр босоод тэр өөртөө зориулж хувцасладаг, үүнтэй адил сүнсэндээ та “Харанхуйн хувцасаа” тайлж /харанхуй бөгөөд хувиа хичээсэн зүйлс/ гэрэлт өдрийн хувцасаа өмс. ⁸Харин бид өдрийнх тул итгэлийн ба хайрын хуяг,

дуулга болгон авралын найдварыг өмсөн, /1Тесалоник 5:8а/, ¹⁴Энэ бүгдийн дээр хайрыг өмс. /Колоссай 3:14а/. Та зөвхөн Есүсээр хувцаславал бусдыг хайрлаж, Бурханы хууль буюу хайрын хуулийг гүйцэлдүүлнэ. Есүсээр өдөр бүр хувцаслах нь юутай гайхамшигтай вэ? ²⁸Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар Түүний дотор бай. Тэгвэл Түүнийг үзэгдэх үед бид Түүний өмнө зоригтой байж, Түүнийг ирэхэд өмнө нь ичгүүргүй байх болно. /1Иохан 2:28/.

Зөвхөн махан биеийн хэрэгцээг хангахын тулд бүү амьдар.

Есүсээр хувцасласан хүмүүс махан биеийн шуналаас Есүсийн хүчээр чөлөөлөгдөнө.”²⁴Христ [Есүст] хамаатай хүмүүс өөрсдийн махан биеэ бузар хүсэл, тачаалынх нь хамт загалмайд цовдолсон ажээ.” /Галат 5:24/, 3Би нүднийхээ өмнө ямар ч хорон юмыг байлгахгүй./Дуулал 101:3а/, ¹¹Хайрт хүмүүс ээ, сэтгэлийн чинь эсрэг дайн хийдэг махан биеийн хүсэл тачаалуудыг цээрлэхийг харь хүмүүс болон түр хугацаагаар байгч та нараас би гуйя. /1Петр 2:11/.

ХИЧЭЭЛ 27 ХРИСТЭД ИТГЭГЧИД САНАЛ НИЙЛЭХГҮЙ БАЙХ ҮЕД

Ром 14:1-23

¹Итгэлээр сул нэгнээ хүлээж ав. Ингэхдээ түүний бодол санааных нь талаар бүү зарга хий. ²Бүх юмыг идэж болно гэж итгэдэг хүн байдаг. Харин сул нэгэн нь ногоо иддэг. ³Иддэг нэгэн нь иддэггүй нэгнээ бүү басамжлаг. Иддэггүй нэгэн нь иддэг нэгнээ бүү шүүг. Учир нь Бурхан түүнийг хүлээн авсан юм. ⁴Бусдын боолыг шүүгч та хэн бэ? Тэр өөрийнхөө эзний өмнө зогсдог эсвэл унадаг. Эзэн түүнийг босгох чадалтай учир тэр зогсох болно. ⁵Нэг

хүн нэг өдрийг нөгөөгөөс нь онцгойлон үздэг байхад, өөр нэг хүн өдөр бүрийг адилхан гэж үздэг. Хүн бүр өөрийн бодолдоо бат итгэлтэй байг. ⁶Өдрийг сахигч хүн Эзэний төлөө үүнийг сахидаг. Иддэг хүн нь Эзэний төлөө иддэг. Учир нь тэр Бурханд талархал өргөдөг. Иддэггүй хүн Эзэний төлөө иддэггүй. Тэр ч Бурханд талархал өргөдөг. ⁷Учир нь бидний хэн нь ч өөрийнхөө төлөө амьдардаггүй. Хэн нь ч өөрийнхөө төлөө үхдэггүй. ⁸Хэрэв бид амьдарвал, Эзэний төлөө амьдардаг. Хэрэв бид

үхвэл Эзэний төлөө үхдэг. Тиймээс амьдрах ч бай, үхэх ч бай бид Эзэнийх. ⁹Учир нь үхэгсэд болон амьд байгсдын аль алиных нь Эзэн байхын тулд үүний тулд л Христ үхээд амилсан билээ. ¹⁰Харин та юунд ах дүүгээ шүүнэ вэ? Эсвэл та юунд мөн ах дүүгээ басамжилна вэ? Учир нь бид бүгдээрээ Бурханы шүүх ширээний өмнө зогсох болно. ¹¹Учир нь “”Би Өөрийн амьд буйгаар тангараглая. Миний өмнө өвдөг бүхэн сөгдөх болно,

Хэл бүхэн Бурханд өчил өргөх болно” гэж

Эзэн айлдаж байна” ¹²Тиймээс бидний хүн бүр өөрийнхөө тайланг Бурханд өгөх болно.

¹³Иймд цаашид бид бие биеэ шүүхээ больё. Харин ч та нар ах дүүдээ бүдрүүлэх чулуу, эсвэл саад тотгор тавихгүй байя гэж шийдэгтүн. ¹⁴Юу ч өөрөө өөртөө бузар биш, харин аливаа юмыг бузар гэж үздэг хүний хувьд л тэр нь бузар юм гэдгийг би Эзэн Есүс дотор мэдэн, итгэж байна. ¹⁵Хэрэв идэх юмнаас болж ах дүүгээ гомдоовол, та нэгэнт хайрын дагуу явахгүй байна.

Та тэр хүнийг идэх юмаараа бүү устга. Учир нь түүний төлөө Христ үхсэн юм. ¹⁶Тиймд та нарын хувьд сайн нь бүү муугаар хэлэгдэг. ¹⁷Учир нь Бурханы хаанчлал бол идэх болон уух явдал нь биш, харин Ариун Сүнс доторх зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгалан нь юм. ¹⁸Учир нь Христэд ийнхүү үйлчилдэг хүн Бурханд таалагдаж, хүмүүсээр сайшаагдана. ¹⁹Тиймд амар тайванг тогтоодог болон бие биеэ босгон байгуулдаг зүйлсийн хойноос мөшгөцгөө. ²⁰Идэх юмнаас болж Бурханы ажлыг бүү нураа. Үнэндээ бүх юм цэвэр аж. Харин тэдгээр нь бүдрүүлэх саад болж иддэг хүний хувьд л бузар муу байгаа юм. ²¹Мах идэхгүй, дарс уухгүй, эсвэл ах дүү чинь бүдэрдэг ямар нэгэн зүйлийг үйлдэхгүй байх нь сайн. ²²Та өөртөө байгаа итгэлээ Бурханы өмнө өөрийнхөө хувьд л байлга. Зөвшөөрдөг зүйлдээ өөрийгөө ялладаггүй хүн нь ерөөлтэй еэ! ²³Харин эргэлзэгч нэгэн нь хэрэв идэх аваас яллагдана. Яагаад гэвэл итгэлээр биш юм. Итгэлээр биш алив бүхэн нь нүгэл юм.

Хийх зүйлс

А. Христч хүн бүрийн үнэн юу вэ?

1. “Бурхан түүнийг _____ юм.” /14:36/
2. “Тэр өөрийнхөө _____ өмнө зогсдог эсвэл унадаг” /14:4/
3. “Эзэн түүнийг босгох чадалтай учир тэр _____ болно”.

/14:46/

4. Өдрийг сахигч хүн _____ төлөө үүнийг хийдэг. /14:6/
5. “Бүгд Бурханд _____ өргөдөг”. /14:6/
6. “Тиймээс амьдрах ч бай, үхэх ч бай тэд _____”. /14:86/.
7. Бид бүгдээрээ _____ шүүх ширээний өмнө зогсох болно. /14:106/.

“Бидний хүн бүр өөрийнхөө _____ өгөх болно.” /14:12/.

Б. Бид яагаад бусад Христч хүмүүсийг шүүж болдоггүй вэ?

1. “Юу ч өөрөө өөртөө бузар биш”/14:14/ //Тимот 1:15а, 16а//
2. “Бид нэгэнт _____ дагуу явахгүй байна.” /14:15/
3. Бид нэгнээ _____ ёсгүй. Учир нь түүний төлөө Христ үхсэн юм. /14:15/.

4. Бидний хувьд _____ бүү _____ хэлэгдэг. /14:16/.

5. Бурханы хаанчлал бол _____ болон уух явдал биш. Харин Ариун Сүнс доторх зөвт байдал, _____ хийгээд _____ нь юм. /14:17/.

/Бурханы хаант улсад орох нь бидний юу хийсэн эсвэл, хийгээгүйгээс үл шалтгаалдаг. Бурханы зөвт байдал бол үнэгүй бэлэг юм. Бидний дотор буй Ариун Сүнсний хүчээр Бурханы зөвт байдлаар амьдарвал бид Бурханы амар тайван болон баяр хөөрийг мэдэх болно./

6. Христэд ийнхүү үйлчилдэг хүн Бурханд _____, хүмүүсээр _____ . /14:18/.

7. Тиймд _____ тогтоодог болон бие биеэ _____ зүйлсийн хойноос мөшгөцгөөе. /14:19/. Идэх юмнаас болж _____ ажлыг бүү _____ . /14:20/.

/Христч хүн бүрийн дотор Бурханы Ариун Сүнс ажлаа хийдэг./ Филиппой 2:13.

8. Ах дүү чинь _____ ямар нэгэн зүйлийг үйлдэхгүй байх нь сайн /14:21/. Итгэлээр биш алив бүхэн нь нүгэл юм. /14:23/

⁹Харин та нарын энэ эрх мөхөс хүмүүст бүдрүүлэх чулуу болох вий гэдэгт санаа тавь. ¹²Ийнхүү ах дүүсийнхээ эсрэг нүгэл хийж, тэдний мөхөс мөс чанарыг шархлуулснаараа чи Христийн

эсрэг нүгэл хийж байгаа юм. /1Коринт 8:9-12/, ²²бузар мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд өөрсдийн зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, үнэн зүрхээрээ ойртон очигцооё. /Еврей 10:22a/.

Зөрчилдөх асуудал

Христэч хүмүүсийн хоорондын аливаа асуудалд Паул мэдрэмжтэй хандаж байлаа. Коринт хотод зарим итгэгч хүмүүсийг шүүхэд бие биенээсээ эсрэг байлаа. ⁷Үнэн хэрэгтээ та нар бие биетэйгээ заргалдаж буй нь та нарын хувьд аль хэдийн сүйрэл мөн. Харин ч яагаад буруутгагдаж болдоггүй юм бэ? Харин ч яагаад мэхлэгдэж болдоггүй юм бэ? /1Коринт 6:7/. Паул Галатын сүмд хандан ¹⁵Хэрэв та нар нэг нэгнээ зуудаг, цөлмөдөг бол, та нар бие биеэ хөнөөх вий гэж болгоомжлогтун. /Галат 5:15/ гэж бичжээ.

Есүс Өөрөө Түүнд итгэх хүмүүсийн төлөө залбирдаг. ²¹Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно. (Иохан 17: 21, 23б) Тиймээ, бид өөрсдийгөө орхин зөвхөн Эзэнийг баярлуулах гэж амьдрах болно. ¹Харагтун, ах дүүсийн хувьд хамтдаа нэгдмэлээр амьдрах нь

Хичнээн сайхан, хичнээн тааламжтай вэ!

²Энэ нь сахал дээгүүр,

Аароны сахал дээгүүр доошоо урсан,

Хувцасных нь захаар доошоо урсаж буй

Толгой дээрх үнэ цэнэтэй тостой адил юм. (Дуулал 133:1,2)

Христэч ахан дүүс нартай нэгдэж амьдрах цорын ганц л зам бий. Энэ нь өөрсдөө нэгдэх гэж хичээснээр бус, харин Есүс Христийг сүмийн тэргүүн нь болгож Түүний Ариун Сүнсний тосолгоог Түүний биеийн бүх гишүүдэд урсгаснаар бий болдог юм. Христээр нэгдсэн хэн боловч Түүний биеийг зөрчилдөөн болон хагарлаар салгаж чадахгүй.

Амар тайвныг хайж, түүнийг мөрдөн мөшгө. (Дуулал 34:14б)

Эргэлзээ бий болгох зүйлс

Паул хэлэхдээ: жинхэнэ итгэгчдийн хооронд санал зөрчилдөх хоёр зүйл бий болгодог.

1-рт: Идэж болох ба идэж болохгүй зүйлс;

2-рт, Ямар өдрүүдийг тэмдэглэж болох.

Зарим Еврей итгэгчид Хуучин гэрээнд буй унд хоолны тухай хуулиудийг дагасан хэвээр байх ёстой гэж итгэдэг байв. Хэрэв мах нь идэхэд зохисгүй бол түүнийг огт иддэггүй байв.

Тэд амралтын ба баярын өдрүүдийг тэмдэглэсэн хэвээр байх ёстой гэж үздэг байв. Зарим харь үндэстнүүд хиймэл шүтээнүүдэд өгөгдсөн ундыг идэх хэрэггүй гэж итгэдэг байв. **Зарим нь өдөр бүрийг Эзэнд үйлчлэх мөн эдгээр нь Христ доторх бидний амралын өдөр хэмээн итгэдэг байв.** (Колоссай 2:16,17). Есүс Христ Хуучин гэрээний бүх хуулийг гүйцэлдүүлсэн гэдэгт бат итгэлтэй хүмүүс нь Ариун Сүнсэн дотор алхаж тэдгээрийн дотор амьдарч буй Ариун Сүнсний хүч чадлын дагуу хайрын хуулийг дагах нь Их Эзэнд хамгийн их тааламжтай байдаг гэж итгэдэг байв. **Тэдний хувьд ямарч хоол унд “бохир” бус ба өдөр бүр нь өөрсдийн ажлуудаас амрах “амралтын” өдөр юм.** (Еврей 4:9,10)

Библид намайг хүлээн авсан болгон “Тэгснээрээ тэд Надад итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно” гэсэн. (үйлс 26:186).

Жинхэнэ Христэч хүмүүсийн итгэлийн амьдралаар амьдрах итгэл нь өөр өөр байдаг боловч тэд бүгдээрээ Эзэнийг алдаршуулж Түүнд үйлчлэхийг хүсдэгээрээ адил юм.

Бие биенээ хүлээж ав

7Тиймээс мөн Христ та нарыг Бурханы алдрын төлөө хүлээн авсны адил бие биеэ хүлээж авагун. (Ром 15:7). Есүс Христ чамайг хэрхэн хүлээж авсан бэ? Энэ нь чиний хийж байсан эсвэл хийгээгүй зүйлийн төлөө биш, харин Түүний нигүүслийн дагуу юм. Үүнтэй адил бид Христэд итгэгч хүн нэг бүрийг нигүүслийн дагуу хүлээж авах хэрэгтэй. Есүс Өөрийн дагалдагчдыг Израйлийн хотууд руу илгээхдээ ингэж хэлжээ. **14Хэн та нарыг хүлээн авалгүй, үгийг чинь үл ойшоох аваас, тэр айлаас эсвэл хотоос гарахдаа та нар хөлийнхөө тоосыг сэгсрэн унага.** **15Үнэнээр Би та нарт хэлье, шүүлтийн өдөр Содом ба Гоморрагийн газар нь тэр хотоос илүү тэвчмээр байх болно.** (Матай 10:14,15). Энэ нь Есүсийн дагалдагчдыг хүлээж аваагүй хүмүүсийн эсрэг хүчтэй сануулга юм. **40Та нарыг хүлээн авсан хүн Намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авсан хүн Намайг илгээсэн Түүнийг хүлээн авсан**

хэрэг юм. (Матай 10:40).

Зарим хүмүүс Бурханы хаанчлалын талаар итгэлтэй байхад бусад нь итгэлгүй байдаг. **Есүс үүнийг Бурханы ажлын төлөө гэрлээгүй хүмүүст хандан ярихад харуулжээ. бүх хүн хүлээн зөвшөөрч чадахгүй, харин энэ нь өгөгдсөн хүмүүс л чадна.** (Матай 19:116).

Паул нь Бурханаас ирэх өөрийн итгэлийн дагуу Түүнийг алдаршуул гэж зааж байна. Харин тэд өөрсдтэй нь адил итгэлгүй хүмүүсийг шүүх ёсгүй. Итгэгч хүн бүр Христийн бие дотор янз бүрийн үүрэгтэй бөгөөд хүн бүр өөрт өгөгдсөн гайхамшигтай даалгавартай. Бүгд Бурханы өмнө үүрэг хариуцлагатай бөгөөд хийсэн зүйлийнхээ хариуд өөр өөрсдийн шагналыг хүртэх болно. **⁸Таригч, услагч нь нэг юм. Тэд тус бүрдээ хөдөлмөрийнхөө дагуу шагналаа авах болно.** (1 Коринт 3:8). Тэгвэл та нар нэгийнхээ төлөө нөгөөгийнхөө эсрэг их зантай болохгүй. **⁷Үнэндээ хэн та нарыг шилдэг хэмээн үзнэ вэ? Та нарт байгааг та нар хүлээж аваагүй гэж үү?** (1 Коринт 4:6б,7а)

Хэрхэн бид Бурханаас эмээж Түүний өмнө даруу байх нь Бурханы үнэ цэнэтэй хүмүүст хэрхэн хандаж байгаагаас харагдана. **¹¹Ах дүү нар аа, бие биеэ бүү гүжирд. Ах дүүгээ гүжирддэг эсвэл өөрийн ах дүүг шүүдэг хүн бол хуулийг гүжирдэгч болон хуулийг шүүгч ажээ. Харин хөршөө шүүгч та хэн юм бэ?** (Иаков 4:11а, 12б).

Бурхан биднийг хэрэв хүн ямар нэг буруу юманд эзэмдүүлсэн бол Түүнийг дөлгөөн байдлын сүнс дотор шинэчлэн засахыг хүсдэг. (Галат 6:1). **⁸Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний ирэх ойртсон тул зүрхээ чангал. ⁹Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүгдчихгүйн тулд бие биеийнхээ эсрэг бүү гомдолло. Харагтун, шүүгч хаалган дээр зогсож байна.** (Иаков 5:8,9).

Ах дүү нараа бүү хорсолтойгоор шүү

Есүс өөрөө хүмүүсээр буруу шүүлтээр шүүгдэх ямар байдгийг мэдэж байв. Би Амралтын өдөр хүн эдгээсэн учраас та нар Надад уурлана уу? **²⁴Гаднах төрхөөр нь бүү шүү. Харин үнэн зөв шүүлтээр шүү гэж айлдав.** (Иохан 7: 23б, 24) **¹Шүүгдэхгүйн тулд чи бүү шүү. ²Учир нь та нар яаж шүүнэ, түүнчлэн шүүгдэнэ.** (Матай 7:1, 2а).

Бид өөрсдийгөө шүүх ёстой. Харин хүн өөрийгөө шалгаж байгаад талхыг идэг, аяганаас ууг... Хэрэв бид өөрсдийгөө

зөв шүүсэн бол шийтгэгдэхгүй байх байсан. (1 Коринт 11:28а, 31). Өөрсдийн замуудыг нягтлан ажиглаад, ЭЗЭН уруу буцацгаая. (Иеремиагийн гашуудал 3:40). Хэрэв бид гуйх юм бол Бурхан бидний зүрх сэтгэлийг харуулах болно. Өө, Бурхан, намайг судлан, миний зүрхийг мэдээч. Намайг шалгаж, миний бодлуудыг мэдээч. Миний дотор ямар нэгэн хөнөөлт үйл буй эсэхийг харж, Мөнхийн зам уруу намайг залаач. (Дуулал 139:23, 24).

Бид бүгд Есүсээр шүүгдэх болно

⁹Тиймд гэртээ байсан ч, гэрээсээ холдсон ч Түүнд таалагдах нь бидний эрмэлзэл билээ. ¹⁰Учир нь хүн бүр мууг ч бай, сайныг ч бай, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахын тулд бид бүгдээрээ Христийн шүүхийн суудлын өмнө гарч ирэх ёстой. (2 Коринт 5:9,10). Есүс бол цорын ганц шудрага шүүгч юм. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг. (Иохан 5:30б). Тэр дэлхийг зөв шударгаар шүүх болно. (Дуулал 9:8а)

Бид хүнд бус Эзэнд үйлчилдэг

“Та нар юу ч хийсэн, хүмүүсийн төлөө бус, Эзэний төлөө үйлддэг шиг чин сэтгэлээсээ хийгтүн. ²⁴Учир нь та нар Эзэнээс өв залгамжлалын шагналыг хүлээн авна гэдгээ мэддэг. Чи Эзэн Христэд үйлчилж байгаа юм.” (Колоссай 3:23, 24). Есүс бол жинхэнэ Христ ч хүмүүсийн Эзэн бөгөөд хүн нэг бүрт юу хийхийг хэлж өгдөг цорын ганц Эзэн юм. Ром 14-т би Бурханаас өөрийн зүрх сэтгэлээ харуулаач гэж гуйхад би уй гашуутайгаар цурхиран уйлж байх юм. Бурхан биднээс бие биенийгээ хайрлахыг үнэхээр их хүсэж байна. Есүс хэлэхдээ **Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол Миний тушаал. Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь.** /Иохан 15:12, 14:15/.

Есүс чамайг хайрласан шиг чи Есүсийг хайрлаж байна уу?

ХИЧЭЭЛ 28 ЕСҮС ХРИСТ БОЛ БИДНИЙ ҮЛГЭР ДУУРИАЛАЛ

Ром 15:1-13

“Хүчтэй бид өөрсдийнхөө сэтгэлд нийцүүлэлгүй, хүчгүйнхээ сул дорой байдлыг үүрэх ёстой. ²Бидний хүн бүр хөршийнхөө сайн сайхны төлөө түүнийг босгон байгуулахын тулд сэтгэлд нь нийцүүлэе. ³Учир нь Христ ч гэсэн Өөрийнхөө сэтгэлд нийцүүлээгүй. Харин “Таныг буруутгасан хүмүүсийн буруутгал Над дээр буув” гэсний адил байсан юм. ⁴Учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм. Ингэснээр Судруудын тэвчээр болон урамшуулалтаар дамжуулан бидэнд найдвар байх юм. ⁵Тэвчээр ба урамшууллыг өгөгч Бурхан нь Христ Есүсийн дагуу та нарыг нэг бодол санаатай байлган соёрхох болтугай. ⁶Ингэснээр бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурханыг та нар нэг дуу хоолойгоор алдаршуулахын тул юм.

⁷Тиймээс мөн Христ та нарыг Бурханы алдрын төлөө хүлээн авсны адил бие биеэ хүлээж авагун. ⁸Учир нь би хэлнэ. Эцгүүдэд

өгсөн амлалтуудыг батлахын тулд Бурханы үнэний төлөө Христ хөвч хөндүүлэгсдийн зарц болсон. ⁹Энэ нь мөн Түүний өршөөлийнх нь төлөө харь үндэстнүүд Бурханыг алдаршуулахын тулд ажээ.

“Иймд би харь үндэстнүүдийн дунд Танд магтаалыг өргөнө.

Таны нэрийг би дуулна” гэж бичжээ.

¹⁰Тэр дахин “Харь үндэстнүүд ээ, Түүний ард түмэнтэй хамт баярлацгаа” гээд,

¹¹мөн дахин “Бүх харь үндэстнүүд ээ, та нар Эзэнийг магтацгаа.

Бүх ард түмэн Түүнийг магтах болтугай” гэжээ.

¹²Исаиа дахин “Иессийн үндэс гарч ирнэ.

Харь үндэстнүүдийг захирахын тулд босох Түүнд

Харь үндэстнүүд найдах болно” ¹³Ариун Сүнсний хүчээр та нар найдвараар бялхсан байхын тулд найдварын Бурхан та нарыг итгэл дотор бүх баяр баясгалан болон амар тайвнаар дүүргэх болтугай.”

Хийх зүйлс

1. _____ бид өөрсдийнхөө сэтгэлд _____ хүчгүйнхээ _____ байдлыг _____ ёстой (15:2)

2. Бидний хүн бүр хөршийнхөө _____ төлөө түүнийг босгон байгуулахын тулд сэтгэлд нь _____ (15:2).

3. Учир нь Христэд гэсэн өөрийнхөө сэтгэлд _____ (15:3) “Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.” (Филиппой 2:136).

4. _____ ба _____ өгөгч Бурхан нь Христ _____ дагуу та нарыг нэг бодол санаатай байлган соёрхох болтугай. (15:5). Учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйл нь биднийг _____ бичигдсэн юм. Ингэснээр Судруудын _____ болон _____ дамжуулан бидэнд _____ байх юм. (15:4).

(бид библийг унших юм бол үүнийг энэ үеийн эцэст амьдарч буй бидэнд сануулга болгон бичсэн бөгөөд энэ нь өнөөдөр бидэнд тусалдаг /1 Коринт 10:116/ “Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. ¹⁷Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.” (2 Тимот 3:16,17)

“Таны үг намайг сэргээсэн нь Миний зовлон зүдгүүрийн дундах миний тайвшрал юм.” (Дуулал 119:50), “Би бүх баялагт баясдагтай адил Таны гэрчлэлүүдийн замд баяссан юм.” (Дуулал 119:114), “Түүний үгэнд би найддаг билээ” (Дуулал 130:56).

5. _____ ба _____ өгөгч Бурхан нь Христ _____ дагуу та нарыг нэг бодол санаатай байлган соёрхох болтугай. (15:5).

6. Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурханыг та нар _____, _____ алдаршуулахын тулд юм. (15:6).

[Бид өөрсдийн бодол санаа болон дуу хоолойгоор хоёулангаар нь Бурханыг алдаршуулах хэрэгтэй юм. “Миний хад болон миний Аврагч болох ЭЗЭН, Амнаас минь гарах үгс хийгээд зүрхний минь бясалгалууд Таны мэлмийд тааламжтай болох болтугай!” (Дуулал 19:14)]

7. Тиймээс мөн Христ та нарыг Бурханы _____ төлөө _____ адил бие биеэ _____. (15:7).

“Та нарыг хүлээн авсан хүн Намайг хүлээн авсан хэрэг юм” (Матай 10:40а)]

8. Эцгүүдэд өгсөн _____ батлахын тулд Бурханы _____ төлөө

Есүс Христ хөвч хөндүүлэгсдийн _____ болсон. (15:8). Энэ нь мөн түүний _____ төлөө харь үндэстнүүд Бурханыг _____ ажээ. (15:9).

[“Түүний сүмд юм бүгд “Алдар” гэж хэлцгээдэг. ЭЗЭН үерийн усан дээр суусан. (Дуулал 25:96,10а), **“Харин ЭЗЭН Та бол өршөөлт, нигүүлсэлт, Уурлахдаа удаан, хайр энэрэл болон үнэнээр элбэг баян Бурхан юм.”** (Дуулал 86:15), **“Өө Эзэн, би хүмүүсийн дунд Танд талархал өргөнө. Би үндэстнүүдийн дунд Таныг магтан дуулна.”** (Дуулал 57:9)]

9. Ариун Сүнсний _____ та нар _____ бялхсан байхын тулд _____ Бурхан та нарыг _____ бүх баяр баясгалан болон амар тайвнаар дүүргэх болтугай. (15:13)

[“Учир нь чи баяртайгаар гарч явж, амар тайвнаар хөтлүүлнэ. (Исаиа 55:12а)]

Өөрийнхөө бус Эзэний тааллын төлөө амьдар

Бурханы өмнө даруу алхах маш олон шалтгаан бий. Тэрээр бидэнд жинхэнэ үнэнийг таниулж өөрийн хайр нигүүлсээ харуулсан. **“Хүн ээ, юу нь сайн болохыг Тэр чамд айлдсан. Шударгыг үйлд, энэрлийг хайрла, өөрийн Бурхантай хамт даруухнаар алх гэхээс өөр юуг Тэр чамаас шаарддаг вэ?** (Мика 6:8)

Гэм нүглийн мөн чанар нь биднийг өөрийн замаар явуулж өөрсдийн тааллын төлөө амьдруулах явдал юм. Энэ нь Есүс бидний төлөө үхэх болсон шалтгаан юм. **“Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов.”** (Исаиа 53:6)

Бид өөрсдийнхөөрөө амьдарч, зөвхөн өөрсдийн тааллаар Бурханд алдрыг авчирч чадахгүй. **“Зарим нь итгээгүй бол яах вэ? Тэдний итгэлгүй байдал Бурханы итгэмжит байдлыг хүчингүй болгоно гэж үү?”** (Ром 3:23). Тийм учраас Бурханыг баярлуулж Түүнд алдар магтаалыг авчрах нь маш чухал. Бид үүнийг өөрсдийн хүчээр хийж чадахгүй, зөвхөн Есүсбидэнд өгөх хүч чадалаар хийж чадна. Тэр бидний дотор амьдардаг юм.

Есүс Аавын тааллын Төлөө амьдарсан

Паул Есүс хүртэл Өөрийнхөө тааллын төлөө амьдраагүй гэж онцолсон бичсэн байдаг.

“Тиймээс Есүс [тэдэнд] -Та нар Хүний Хүүг өргөвөл, “Би байдаг” гэдгийг, мөн Би Өөрийн санаагаар юуг ч хийдэггүй, харин Эцэгийн

Надад зааснаар Би эдгээрийг ярьдаг гэдгийг мэдэх болно. Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг учир Тэр Намайг ганцааранг минь орхисонгүй гэв.” (Иохан 8: 28, 29б). Есүс хэлэхдээ: **“Таны хүслийг үйлдэхээр Би ирлээ. Миний тухай хуйлмал номд бичигдсэн” гэж хэлсэн** /Еврей 10:76/, **“Тэр тэднээс жаахан цаашаа яваад, нүүрээрээ унаж, -Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог гэж залбирлаа.”** /Матай 26:39/.

Есүс Бурханд тааламжтай зүйлс хийж байсан учир Түүнийг алдаршуулсан юм. **“-Энэ бол Миний хайрт Хүү мөн. Түүнд Миний таалал оршдог. Түүнийг сонсогтун гэх дуу гарав.”** (Матай 17:56). **“Одоо Хүний Хүү алдаршлаа. Бурхан Түүгээр алдаршлаа.”** (Иохан 13:31б)

Бидний амьдрал Бурханд алдрыг авчрах ёстой

Бид бусад итгэгчидтэй Бурханыг алдаршуулахын төлөө нэгдэх нь итгэгч бус хүмүүст Бурханы хайр ба нигүүслийн гэрч болох юм. (Ром 15:6,7). Тэд ч мөн Эзэн дотор баярлацгаах болно. (Ром 15:9-11). **“Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг.”** (Матай 5:16). **“Хүмүүний зам ЭЗЭНий таалалд нийцэх цагт Тэрээр түүний дайснуудыг нь хүртэл түүнтэй эв түнжинтэй байлгадаг.”**(Сургаалт үгс 16:7)

“Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу? ²⁰Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун.” (1 Коринт 6:19,20).

“Хэрэв та нар Христийн нэрээс болж зүхэгдвэл ерөөлтэй. Учир нь алдрын ба Бурханы Сүнс та нарын дээр оршдог. ¹⁵Та нараас хэн нь ч алуурчин, эсвэл хулгайч, эсвэл хорон мууг үйлдэгч юм уу, эсвэл бусдын хэрэгт хошуу дүрдэг нэгэн мэт бүү зовог. ¹⁶Хэрэв Христийнх гэдгээсээ болж зовдог бол бүү ич. Харин энэхүү нэрээрээ Бурханыг алдаршуул.” (1 Петр 4:14-16).

“Адил сэтгэж, адил хайртай байж, сэтгэлээрээ нэгдэн, нэгэн бодолтой байж, намайг гүйцэд баярлуул. ³Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэж, ⁴хүн бүр зөвхөн хувийн ашиг

сонирхлыг бус, харин бусдын ашиг сонирхлыг хар.” (Филиппой 2:2-4)

Хэрхэн бусдын тааллын Төлөө амьдрах вэ?

Паул нь Христ дотор эрх чөлөөтэй гэдгээ мэддэг байв. Гэвч тэрээр өөрийн “эрх мэдлээ” сул дорой итгэгчдийн төлөө хойш тавьсан. “Бүх юмс зөвшөөрөгддөг, харин бүгд тустай биш. Бүх юмс зөвшөөрөгддөг, харин бүгд босгон байгуулдаггүй. ²⁴**Хэн ч өөрийн ашгийг бүү эр, харин бусдынхыг эрэг...Яг надтай адил байгтун. Хүмүүсийг аврагдаасай гэсэндээ би өөрийн ашгийг бус, харин олны ашгийг хайн, бүхний дотор бүх хүний таалалд нийцүүлдэг. ...Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайцгаа.**” (1 Коринт 10:23,24; 11:1). Бид бусдадаа туслахын төлөө амьдрах хэрэгтэй. “Бие биеэ хайр болон сайн үйлсэд хөхүүлэн урамшуулахад анхааръя. ²⁵**Ингэхдээ зарим хүмүүсийн зуршил болсон шиг хамтран цуглахаа болилгүй, харин нөгөө өдөр ойртож буйг харах тусам бие биеэ зоригжуулъя**” (Еврей 10:24,25).

Өөрсдийгөө төгс болгохын тулд Хуучин Гэрээний хуулиудыг дагахыг шаарддаг хүмүүсийг дагаж тэднийг тааламжтай болгосноор Паул итгэгчдийг “дахиж боолчлолын буулганд оруулахыг” хүсээгүй юм. “**Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун.**” (Галат 5:16). Паул үүнийг “Өөрийн сайн мэдээ” гэсэн юм. “**Хэрэв би эдүгээ хүртэл хүмүүсийн сэтгэлд нийцүүлсээр байсан бол би Христийн боол биш байх байсан.**” (Галат 1:10б)

ХИЧЭЭЛ 29 ПАУЛ ЖИНХЭНЭ ИТГЭГЧ ХҮНИЙ ЖИШЭЭ

Ром 15:14-33

“Ах дүү нар минь, та нарын хувьд гэвэл та нар өөрсдөө аливаа сайн сайхнаар дүүрэн, бүхийлмэдлэгээр дүүргэгдсэн, мөн нэг нэгнээ ятгах чадвартай гэдэгт би итгэсэн юм. ¹⁵Гэвч та нарт дахин сануулахын тулд зарим зүйл дээр би их зоригтойгоор бичлээ. Учир нь Бурханаас надад өгөгдсөн нигүүлслээр ¹⁶Бурхан намайг харь үндэстнүүдэд Христ Есүсийн үйлчлэгч болгосон. Би харь үндэстнүүдийг Ариун Сүнсээр ариусган Бурханд тааламжит өргөл болгохын төлөө Бурханы сайн мэдээг тунхаглах тахилчийн үүргийг гүйцэлдүүлсэн. ¹⁷Тиймд Бурханд хамаарах зүйлсээр Христ Есүс дотор сайрхах шалтгаан надад бий. ¹⁸Учир нь Христийн надаар дамжуулан хийсэн зүйлээс өөр ямар ч юмыг би ярьж зүрхлэхгүй. Тэрээр надаар дамжуулан Харь үндэстнүүдийг дуулгавартай байдалд үгээр болон үйлсээр минь, ¹⁹тэмдгүүд болон гайхамшгийн хүч дотор, Ариун Сүнсний хүч дотор авчирсан юм. Тэрчлэн би Иерусалимаас Иллурикум хүртэлх нутгаар Христийн сайн мэдээг бүрэн дэлгэрүүлсэн. ²⁰Ийнхүү

би өөр хүний суурин дээр барихгүйн тулд Христийн нэр дуурсагдаагүй газарт л сайн мэдээг дэлгэрүүлэхийг хичээсэн. ²¹Харин энэ нь “Түүний тухай мэдээгүй хүмүүс харах болно.

Сонсоогүй хүмүүс ойлгох болно” ²²Энэ шалтгаанаас болж би та нар уруу очих гээд олонтаа саатуулагдсан билээ. ²³Харин одоо миний хувьд эдгээр нутагт цаашид ажиллах өөр газар байхгүй. Би та нар уруу очихыг олон жилийн өмнөөс хүсэж байна. ²⁴Би Испани уруу явах замдаа та нартай уулзаж, түр зуур ч гэсэн эхлээд та нартай нөхөрлөн баярлаж байгаад дараа нь намайг тийшээ явахад минь туслах байх гэдэгт найддаг. ²⁵Харин одоо би ариун хүмүүст үйлчлэхээр Иерусалим уруу явах гэж байна. ²⁶Учир нь Иерусалим дахь ариун хүмүүсийн дотор буй ядууст зориулж хандив өгөх болсон нь Македони болон Ахайн хүмүүсийн сэтгэлд нийцэв. ²⁷Тийм ээ, тэдний сэтгэлд нийцсэн юм. Тэд Иерусалим дахь ариун хүмүүсийн өмнө өртөнгүүд юм. Учир нь хэрэв харь үндэстнүүд тэдний сүнслэг зүйлсийг хуваалцсан

бол эд зүйлсээрээ ч бас тэдэнд үйлчлэх өртэй юм. ²⁸Тиймд би тэдэнд цуглуулсан юмыг нь өгч, үүнийг дуусгаад, та нарыг дайран Испани уруу явна. ²⁹Би та нар уруу очихдоо Христийн ерөөлийн дүүрэн байдалд очно гэдгээ мэднэ.

³⁰Ах дүү нар аа, бидний Эзэн Есүс Христээр болон Сүнсний хайраар би та нараас гуйя. Би залбирч байна. Та нар ч миний төлөө Бурханд

хичээнгүйлэн залбираарай. ³¹Энэ нь би Иудей дахь дуулгаваргүй хүмүүсээс чөлөөлөгдөн Иерусалим дахь миний үйлчлэл нь ариун хүмүүст зөвшөөрөгдөөсэй гэсэнд юм. ³²Ингэвэл би Бурханы хүслээр та нар уруу баяртайгаар очиж, та нарын хамт амрах болно. ³³Амар амгалангийн Бурхан та бүгдийн хамт байх болтугай. Амен.”

Хийх зүйлс

1. Паул Ромд буй Итгэгч ахан дүүсээ аливаа _____ дүүрэн бүхий л _____ дүүргэгдсэн мөн нэг нэгнээ ятгах чадвартай гэдэгт итгэсэн юм. (15:14).

2. Бурханаас түүнд өгөгдсөн _____ тэр тэдэнд дахин сануулахын тулд зарим зүйл дээр бичсэн (15:15)

3. Паул _____ Христ Есүсийн үйлчлэгч байсан. (15:16)

4. Паул харь үндэстнүүдийг Ариун Сүнсээр _____ Бурханд тааламжит өргөл болгохын төлөө Бурханы сайн мэдээг тунхаглах тахилчийн үүргийг гүйцэлдүүлсэн (15:16).

5. Паулд _____ дотор сайрхах шалтгаан байсан (15:17). _____ түүгээр дамжуулан хийсэн зүйлээс өөр ямар ч юмыг тэр ярьж зүрхлэхгүй. (15:18)

["Харин Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон. Түүний надад үзүүлсэн нигүүлсэл хоосон байгаагүй. Харин ч би тэд бүгдээс илүү их хөдөлмөрлөсөн юм. Гэхдээ би биш бөгөөд харин надтай хамт байдаг Бурханы нигүүлсэл болой."] (1 Коринт 15:10).

6. Паул өөр хүний _____ дээр барихгүйн тулд Христийн нэр дуурсагдаагүй газарт л сайн мэдээг дэлгэрүүлэхийг л хичээсэн (15:20).

Паул зам тавихаар дуудагдсан бөгөөд Аврагчийн цовдолох талаар Исаиагийн иш үзүүлэг дээр үндэслэж тэр хэн ч очиж байгаагүй газаруудаар явж харь үндэстэнүүдэд сайн мэдээ ярьж байсан. ["Учир нь тэдэнд хэлээгүй юмыг тэд харж, тэдэнд сонсгоогүй юмыг тэд

ойлгоно”]. (Исаиа 52:156)].

7. Паул Ром дахь Итгэгч ахан дүүсдээ өөрийн төлөө Бурханд хичээнгүйлэн _____ гуйсан. (15:30)

Паулын залбирлын 3 сэдэв

Паул Испани явах замдаа **“Иерусалим руу явъя гэж сүнсээр шийдэн, Тэнд хэсэг байгаад би Ромд очих ёстой гэв”** (үйлс 19:21) (Бид Паулыг Испани руу очсон үгүйг мэдэхгүй). **Тэрээр ариун хүмүүсийн төлөөх хуримтлалын талаар Галатын чуулгануудад аль хэдийн чиг өгсөн.** (1 Коринт 16:1). Харь үндэстнүүд үүнийг хийхдээ маш баяртай байсан, учир нь өөрсөдтэй нь сайн мэдээ хуваалцсан еврей ах дүү нартаа өртэй мэт тэдэнд санагдаж байлаа. Еврей үндэстний хувьд Паул үүнийг зааж байлаа. Тэрээр **“Хэрэв бид та нарт сүнслэг зүйлсийг тариад та нараас бид махан биеийн юмсыг хураасан бол энэ нь дэндүү их байна уу?”** /1 Коринт 9:11/, **“Үгэнд суралцагч нь сургагчтайгаа сайн бүхнээ хуваалцаг.”** / Галат 6:6/ гэж бичжээ.

Паул Ром дахь Христэд итгэгчидийг дараах 3 зүйлийн төлөө нэгдэн залбирахыг гуйж байв.

1. Тэрээр Иуда дахь итгэгч бус хүмүүсээс ангижрахын төлөө
2. Иерусалимын төлөөх түүний үйлчлэл нь тэндэхийн ариун хүмүүст хүртээмжтэй болохын төлөө
3. Бурханы хүслээр Ромд ирж тэдэнтэй хамт шинэчлэгдэхийн төлөө.

Паулын залбирлын хариу

Бурхан Паулын залбиралд маш өвөрмөц байдлаар хариулжээ. (үйлс 20-28-р бүлэг). **“Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. 6Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно.”**(Сургаалт үгс 3:5, 6). Паул түүнийг алах хуйвалдаанаас хамгаалагдсан хэдий ч тэрээр Ромд сайн мэдээний төлөө хоригдол болон ирсэн. 2 жилийн турш гэрийн хорионд байсны эцэст түүнийг хүмүүст Есүсийн талаар чөлөөтэй заахыг зөвшөөрчээ. Тэнд цаазлагдахаасаа өмнө, **“Би сайн тэмцлээр тэмцсэн. Би замаа дуусгасан, итгэлээ сахисан.”** (2 Тимот 4:7) гэж бичжээ.

ХИЧЭЭЛ 30 ПАУЛЫН ХУВИЙН ЗАХИАС

Ром 16:1-27

“Кенхрей дахь чуулганы үйлчлэгч болох бидний эгч Фойбег би та нарт сайшааж байна. ²Ариун хүмүүст зохих ёсоор түүнийг Эзэн дотор хүлээн авч, та нарын хэрэг байж болох аливаа юманд нь түүнд туслаарай. Учир нь тэр өөрөө олон хүнд, мөн надад ч тусалж байсан.

³Христ Есүс дотор надтай хамтран зүтгэгч Приска, Акул нарт мэнд хүргээрэй. ⁴Тэд миний амийн төлөө өөрсдийгөө үхлийн аюулд оруулсан билээ. Тэдэнд ганц би ч биш, мөн харь үндэстнүүдийн бүх чуулган талархдаг билээ. ⁵Тэдний гэрийн чуулганд болон мөн Христэд эргэсэн Азийн анхны хүн болох миний хайрт Епайнетад мэнд хүргээрэй. ⁶Та нарын төлөө шаргуу ажилласан Мариад мэнд хүргээрэй. ⁷Миний садан, надтай хамт хоригдол байсан Андроник, Иуни нарт мэнд хүргээрэй. Тэд элч нарын дунд нэр цуутай нь бөгөөд надаас ч өмнө Христийн дотор байсан юм. ⁸Эзэн доторх миний хайрт Амплиатад мэнд хүргээрэй. ⁹Христ доторх бидэнтэй хамтран зүтгэгч Урбан, миний хайрт Стах нарт мэнд хүргээрэй. ¹⁰Христ дотор сайшаагдсан Апелд

мэнд хүргээрэй. Аристобулын гэрийнхэнд мэнд хүргээрэй. ¹¹Миний садан Херодионд мэнд хүргээрэй. Эзэн дотор байгч Наркиссын гэрийнхэнд мэнд хүргээрэй. ¹²Эзэн дотор ажиллагч Труфайна болон Труфоса нарт мэнд хүргээрэй. Эзэн дотор шаргуу ажилласан хайрт Персист мэнд хүргээрэй. ¹³Эзэн дотор сонгогдсон Руфт мэнд хүргээрэй. Миний ээж болох түүний ээжид мэнд хүргээрэй. ¹⁴Асункрит, Флегон, Хермес, Патроб болон Хермас нарт болон тэдэнтэй хамт байгаа ахдүүст мэнд хүргээрэй. ¹⁵Филолог болон Иулиа, Нере болон түүний эмэгтэй дүү, мөн Олумп болон тэдэнтэй хамт байгч бүх ариун хүмүүст мэнд хүргээрэй. ¹⁶Бие биедээ ариун үнсэлтээр мэнд хүргээрэй. Христийн бүх чуулган та нарт мэнд хүргэж байна.

¹⁷Ах дүү нар аа, та нарын сурсан сургаалын эсрэг хэрүүл маргаан, саад тотгор гаргагч хүмүүсээс сэрэмжлэхийг би ятгаж байна. Тэднээс холдогтун. ¹⁸Учир нь тийм хүмүүс бидний Эзэн Христэд биш, харин өөрсдийн ходоодондоо боолчлогддог. Тэд ялдам, зусар үг яриагаараа гэнэн хүмүүсийн зүрхийг мэхэлдэг. ¹⁹Та нарын

дуулгавартай байдал бүгдэд дуулдсан юм. Тиймээс би та нарын талаар баярладаг. Гэхдээ та нарыг сайнд мэргэн, харин бузар мууд гэмгүй байгаасай гэж би хүсэж байна. ²⁰Амар амгалангийн Бурхан та нарын хөл дор Сатаныг удахгүй бяцална. Бидний Эзэн Есүсийн нигүүлсэл та нартай хамт байх болтугай.

²¹Надтай хамтран зүтгэгч Тимот, мөн миний садан болох Луки, Иасон болон Сосипатр нар та нарт мэнд хүргэж байна. ²²Энэхүү захиаг бичиж буй Терт би та нарт Эзэн дотор мэнд хүргэе. ²³Намайг болон бүх чуулганы зочлогч гэрийн эзэн Гай та нарт мэнд хүргэж байна. Хотын сан хөмрөгийн нярав

Ераст, дүү Куарт нар та нарт мэнд хүргэж байна. ²⁴[Бидний Эзэн Есүс Христийн нигүүлсэл та бүгдтэй хамт байх болтугай. Амен.]

²⁵Бурхан миний сайн мэдээг болон Есүс Христийг тунхагласнаар дамжуулан өнө эртний турш нууцлагдаж байсан нууцыг илчилж та нарыг бат бэх болгоно. ²⁶Тэр нууц нь эдүгээ илэрхий болж мөнх Бурханы тушаалын дагуу эш үзүүлэгчдийн Судруудаар дамжин бүх үндэстэнд мэдэгдэн, тэд итгэж, дуулгавартай дагах болсон. ²⁷Цорын ганц мэргэн Бурханд, Есүс Христээр алдар нь үүрд мөнх байх болтугай. Амен.”

Хийх зүйлс

Ром номны сүүлийн бүлгээс нөхөж бичээрэй

1. Паул _____ Ром дахь итгэгч нарт сайшааж Түүнийг хүлээн авч аливаа юманд нь туслахыг гуйсан (16:1) [Эзэн доторх эгч болон эмэгтэй Кенхрей дахь чуулганы үйлчлэгч Ромд очиж Паулын захидлыг хүргэхээр төлөвлөсөн байв]

2. Паул хамтран зүтгэгч _____, _____ нартаа мэнд хүргэсэн байна. Тэд түүний амийн төлөө өөрсдийгөө үхлийн аюулд оруулсан байлаа. (16:3) [Паул энэ 2 хүнтэй анх Коринт хотод тааралджээ. (үйлс 18:1-3) “Харин Прискила, Акул нар түүнийг сонсоод хажуу тийш нь авч гараад, түүнд [Бурханы] замыг улам ч зөв тайлбарлаж өгөв.” (үйлс 18:26б)]

3. Паул мөн Эзэн дотор сонгогдсон “_____ болон түүний ээжид мэнд хүргүүлсэн байна. (16:13) [(Марк 15:21)]

4. Коринтод түүнтэй цуг ажиллаж байсан хэдэн хүмүүс мөн тэдний нэг болох Паулын хэлснийг бичиж байсан _____ тэдэнд мэнд хүргэжээ. (16:22)

5. Паулыг Коринтод байх хугацаанд түүнийг болон бүх чуулганыг гэрийн Эзэн _____ зочилж байсан (16:23) [**Энэ хүн Паулаар баптисм хүртэж байжээ** (1 Коринт 1:14)]

6. Паул Ром дахь Итгэгч нартаа тэдний сурсан сургаалын эсрэг _____, саад тотгор гаргагч хүмүүсээс сэрэмжлэхийг сануулсан (16:17). Учир нь тийм хүмүүс Эзэн Христэд биш “харин өөрсдийн _____ боолчлогддог” (16:18) [“Миний та нарт үргэлж ярьж байсан олон хүмүүс Христийн загалмайн дайснууд мэт явдаг гэж би одоо уйлан байж хэлж байна. **19Тэдний төгсгөл бол сүйрэл. Тэдний бурхан бол ходоод бөгөөд тэд гутамшигт зүйлсээр сайрхдаг. Тэд дэлхийн юмыг л сэтгэж боддог.**” /Филиппой 3:18,19/]

7. Паул тэднийг “сайнд _____ харин бузар мууд _____” байхыг хүссэн (16:19)

Ивээл

Нууцлагдмал байсан сайн мэдээ нь одоо Библид ил тодоор нээгдлээ. Паул өөрийн гайхамшигт ер бусын захиагаа Бурхан Өөрөө Есүс Христээр дамжуулан үүрд мөнх алдаршиж мөн чамайг босгон байгуулах талаар сануулан дуусгаж байна. “Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, гэм зэмгүйгээр зогсоож чадах Түүнд, **25бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, ноёрхол, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен.**” /Иуда 24,25/.

Асуултын хариултууд

Хуудас 2

1. Эш үзүүлэгчдээрээ, Судруудад
2. Есүс Христийн
3. Махан биеэр, Давидын
4. Амилснаар, Бурханы Хүү
5. Үндэстний, дуулгавартай байдлыг, нигүүлсэл

Хуудас 7-8

1. Алдаршуулсан, талархал
2. Мэргэн, мунхаг
3. Алдрыг, дүрээр
4. Бузар, гутаахад
5. Үнэнийг, худал хуурмагаар, Бүтээгчээс, бүтээлд
6. Гутамшигт, хүсэл тачаалд, эмэгтэйчүүд ч, эрчүүд ч
7. Завхарсан
8. Үхвэл, зарлигийг, сайшаадаг

Хуудас 10

1. Үнэний
2. Үйлсийнх, бузар мууг, Сайныг
3. Ялгаварлах
4. Христ Есүсээр

Хуудас 12

1. Иудей
2. Хуульд
3. Бурханаар
4. Хүслийг
5. Онц сайн

Хуудас 13

1. Хулгай
2. Завхайрдаг
3. Тонодог
4. Зөрчсөнөөрөө

Хуудас 15-16

1. Алга, ганц
2. Алга
3. Алга
4. Бүгд
5. Хэрэгцээгүй
6. Сайныг, ганц
7. Хоолой
8. Хуурч мэхэлдэг
9. Могойн хор
10. Хараал, гашуун
11. Цус урсгахдаа
12. Гай гамшиг
13. Амар амгалангийн
14. Айдас

Хуудас 19-20

1. Хуулиас, Есүс Христэд, итгэх итгэлээр, бүх
2. Зөвтгөгдсөн, цусанд, эвлэрүүлэл
3. Есүст, зөвтгөгч, зөвийг
4. Зайлуулагджээ
5. Үйлээс, итгэлээр, итгэлийн

Хуудас 24-25

1. Ажил, Бурханлаг бус, итгэл
2. Хөвч хөндүүлээгүй
3. Итгэлийн, тамгаар
4. Итгэдэг, Эцэг, зөвд
5. Үхэгсдэд, байгаагаар
6. Алдрыг
7. Биелүүлэх
8. Үхэгсдээс, амилуулсан, итгэж
9. Тушаагдсан, зөвтгөлийн

Хуудас 26-27

1. Итгэлээр, Бурхантай
2. Орох
3. Алдрын
4. Зовлонтойдоо, тэвчээрийг, туршлагатай, найдварыг
5. Урам хугалдаггүй, Ариун Сүнсээр, хайр
6. Уур хилэнгээс
7. Амиар, аврагдах

Хуудас 29-30

1. Нүгэл, үхэл, бүгд
2. Ноёрхсон
3. Бүх, ялд
4. Дуулгаваргүй, нүгэлтэн
5. Үхлээр
6. Бэлэг, олон
7. Шүүлт, үнэгүй
8. Нигүүлслийн, ноёрхоно
9. Зөвт, Бүх, амийн
10. Дуулгавартай, зөвт

Хуудас 32-33

1. Боолчуулалгүй, цовдлогдсоныг, чөлөөлөгдсөн
2. Амилуулагдсан, нэг, Бурханд
3. Нүгэлд, үхсэн, Бурханд, амьд
4. Үхэгсдээс, амьд
5. Зөвт, зэвсэг

Хуудас 44

1. Христ Есүс, ял
2. Амийн, хууль, нүглийн, хуулиас, чөлөөлсөн
3. Хуулийн, махан биетэй, махан биеийн, нүглийг
4. Шаардлага, махан биеийн

Хуудас 48

1. Махан биеийн, Сүнсний
2. Амь, амар тайван
3. Дайсагнал, таашаагдаж

Хуудас 52-53

1. Сүнсээр, удирдуулж
2. Айдаст, боолчлолын
3. Сүнс, гэрчилдэг
4. Зовдог

Хуудас 56

5. бүтээл, төрөх зовлон, Бурханы хөвгүүд
6. Сүнсний, биеийн, тэсэн ядан
7. Сүнс, илэрхийлэшгүйгээр, Ариун

Хуудас 62-63

1. үрчлэл
2. алдар
3. гэрээнүүд
4. хууль
5. үйлчлэл
6. амлалтууд
7. эцгүүд
8. христ, Бурхан

Хуудас 68

1. ойр, аманд, зүрх сэтгэлд
2. Эзэн Есүс
3. үхэгсдээс, амилуулсан
4. хүн зүрхэндээ итгэвэл зөвт байдалд
5. хүн амаараа хүлээн зөвшөөрвөл авралд
6. нэрээр дуудах
7. сонсохоос, үгээр

Хуудас 81

1. Дээд
2. Бурхан
3. Айдас, бузар мууг, илд, уур хилэнг, өшөө авагч.
4. мөн чанарынхаа

Хуудас 84

1. А. Завхайр
- Б. Ал
- В. Хулгай хий
- Г. Хуурамч гэрчийг
- Д. Шунхайр
2. хөршөө, хайрла
3. хайр

Хуудас 88

- А 1. Хүлээн авсан
2. Эзэний
3. зогсон
4. Эзэний
5. Талархал
6. Эзэнийх
7. Христийн, тайланг, Бурханд
- Б. 1.
2. Хайрын
3. Устгах
4. Сайн нь, муугаар
5. Идэн, уух, баяр баясгалан.
6. Таалагдаж, сайшаагдана.
7. Тайванг, босгон байгуулдаг, Бурханы, нураа.
8. Бүдэрдэг.

Хуудас 94-95

1. Хүчтэй, нийцүүлэлгүй, сул дорой, үүрэх.
2. Сайн сайхны, нийцүүлье.
3. Нийцүүлээгүй.
4. Сургахын тулд, тэвчээр, урамшуулалтаар, найдвар.
5. Тэвчээр, урамшууллыг, Есүсийн.
6. Нэг оюун санаа, нэг дуу хоолойгоор.
7. Алдрын, хүлээн авсны, хүлээж авагтун.
8. Амлалтуудыг, үнэнийг, зарц, өршөөлийнх нь, алдаршуулахын тулд.
9. Хүчээр, найдвараар, найдварын, итгэл дотор.

Хуудас 99

1. сайн сайхнаар, мэдлэгээр.
2. Нигүүслээр.
3. Үндэстнүүдэд
4. Ариусгал.
5. Христ Есүс, Христийн.
6. Суурин.
7. Залбирахыг.

Хуудас 102

1. Фойбег
 2. Приска, Акул
 3. Руфт
 4. Терт
 5. Гай
 6. Хэрүүл маргаан
 7. Мэргэн, гэмгүй
- 113 хуудас

РОМ НОМ ДАХЬ САЙН МЭДЭЭНҮҮД

1. Бурханы хүч чадал нь таныг Түүний уур хилэнгээс хамгаалах болно.

¹⁶Би сайн мэдээнээс ичихгүй. Яагаад гэвэл тэр нь итгэгч хүн бүрийг авралд хүргэх Бурханы хүч мөн.

¹⁸Бурханы уур хилэн үнэнийг зөвт бусаар нуун дарагч хүмүүсийн аливаа бурханлаг бус ба зөвт бус байдлын эсрэг тэнгэрээс илчлэгддэг. (ром 1:16, 18)

2. Бурханы сайн сайхан нь таныг гэмшилд хөтлөх болно.

⁴ариун байдлын Сүнсээр үхэгсдээс амилснаар сүр хүчээр Бурханы Хүү гэж тодорхойлогдсон бидний Эзэн Есүс Христ мөн.

²³Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй, (ром 2:4; 3:23)

3. Бурханы зөвт байдал нь үйлсээр бус харин итгэлээр ирдэг юм

⁵Харин ажил хийдэггүй боловч, бурханлаг бус хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг хүний хувьд итгэл нь зөвд тооцогддог. (ром 4:5)

4. таны төлөөх Христийн үхлээр дамжуулан Бурханы агуу хайрыг харж болно.

⁸Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. (ром 5:8)

5. Бурханы бэлэг бол Христ Есүс доторхи мөнхийн амь мөн

²³Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн. (ром 6: 23)

6. Христ Есүс доторхи амийн сүнсний хууль нь таныг гэмээс чөлөөлдөг.

¹¹Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаа гэж тооц.

¹Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. 2Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ. (ром 6:11; 8:1,2)

7. Бурханы хүсэл бол сайн

²³Зөвхөн үүнд ч биш, харин бас бид, өөрсдөдөө Сүнсний анхны үр жимсийг авсан бид ч дотроо ёлон биднийг үрчилж авахыг буюу бидний биеийг золин аврахыг тэсэн ядаж хүлээдэг

²Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун. (ром 8:28; 12:2)

ЕСҮСТ ИТГЭСЭН ТҮҮНИЙ НЭРЭЭР ДУУДСАН ХЭН БОЛОВЧ АВРАГДАХ БОЛНО

⁹Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно 10Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ.

¹³Учир нь "Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно". (ром 10:9,10,13)

Та бидэнтэй холбоо барихыг хүсвэл доорхи хаягаар захидал бичээрэй. УБ-13, Ш/Х-180